ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

# ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ






## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ:

Д.Лүндээжанцан /эрхлэгч/
О.Амархүү /ерөнхий редактор/
Гишүүд: Ж.Болдбаатар
Ч.Энхбаатар
Н.Лүндэндорж
Б.Мандахбилэг
П.Түвшинтөгс
/нарийн бичгийн дарга/

Редакцийн хаяг:Сүхбаатар дүүрэг 6 дугаар хороо, Их сургуулийн гудамж, Шихихутуг ХЗДС-ийн хичээлийн I байр

WEB site: www.shihihutug.edu.mn
E-mail: shikhi_setguul@yahoo.com
Утас: 314977
91181909
99179537

## ЭНЭ ДУГААРТ

1. Д. Лүндээжанцан
Монгол улсын үндсэн хуулийн шинэчлэл ба төрийн эрх мэдлийн хуваарилалт

2. О. Амархүү
Монголын Экологийн эрх зүйн шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн зарим асуудал

3. Р.Оюунбадам
Шүүхийн өмнөх шатанд сэжигтэн, яллагдагчдийн эрхийг хамгаалах асуудал

4. П.Түвшинтөгс
Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

5. Б.Минжүүрдорж
Эрх зүйн философи ба харьцуулсан эрх зүй судлал

6. Б.Цэрэнчимэд
Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

7. М.Түвшинжаргал
Японы эрүүгийн эрх зүй нь хосолсон эрүүгийн эрх зүйн систем болох нь

8. Ч.Жадамба
Интернэтийн орчин дахь зохиогчийн эрхийн асуудал

9. Г.Гантогтох
Үндсэн хуулийг шүүхэд хэрэглэх зарим асуудал

Шихихутуг ХЗДС байгуулагдсаны 20 жилийн ойн баярын хурал дээр захирал, дэд профессор Д.Оюунцэцэгийн хэлсэн үг

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА

ШИНЭ НОМ

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ БА ТӨРИЙН ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ

*Д.Лүндээжанцан*

*УИХ-ын гишүүн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор*

Монголын шинэ Үндсэн хууль бол үндэснийхээ оюуны чадавхид түшиглэн, бодит нөхцлөө харгалзан уламжлал, шинэтгэлийн жам ёсыг тусгасан үзэл баримтлаа бүхий манай ард түмний өөрсдийнх нь бүтээл туурвил мөн.[1]

Үндсэн хуулийн оршилд «Монголын ард түмэн бид...» гэж хэлдэгийг санамсаргүй хэмээн үзэх учиргүй.

«Үндсэн хууль бол Монгол Улсын тулгуур хууль болохын хувьд төрийн бусад хууль, эрх зүйн алив баримт бичгийн эх сурвалж болдог үндэсний төр ёсны тунгаамал үнэт хэсэг, төрийн тогтолцоо оршин байхын нэгэн гол субъектив нөхцөл»[2] мөн.

Монгол улс 1992 онд Үндсэн хуулиа шинэчлэн баталж мөрдөөд даруй 20 жил болж байна.

Улс орны хөгжлийн явц, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс шалтгаалж Үндсэн хуулийг боловсронгуй болгох шаардлага бий болдог.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг[3] дээдлэн сахиж, хүндэтгэн биелүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах нь Монгол Улсын тусгаар тогтносон, бүрэн эрхт байдлаар оршин тогтнохуйн эрх зүйн үндэс, Монгол Улсын Их Хурлын онцгой чухал үүрэг мөн бөгөөд энэ хүрээнд уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран найм, Жаран есдүгээр зүйлд заасан үндэслэлийн дагуу хянан шийдвэрлэх үйл ажиллагааны зарчим, журмыг зохицуулж өгсөн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр баталсан билээ.

Дэлхийн улсуудын практикт нэмэлт, өөрчлөлт оруулж болох хялбар нөхцөлтэй журам тогтоосон уян хатан Үндсэн хууль, хатуу нөхцөлтэй журам тогтоосон хатуу Үндсэн хууль үйлчилж байна. Хатуу нөхцөлтэй журам нь дотроо хоёр янз байдаг байна. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг парламентаар хэлэлцэж ард нийтийн санал асуулгаар баталдаг, хоёр парламент дамжиж хэлэлцдэг, эсхүл төв парламент, орон нутгийн парламент нэг бүрээр хэлэлцдэг хүнд нөхцөлтэй, нөгөө нь парламентын гуравны хоёр, дөрөвний гурваар хэлэлцэн баталдаг харьцангуй хүндэвтэр нөхцөлтэй журам байна. Ийм хүндэвтэр нөхцөлтэй журам тогтоосон орны нэгд Монгол Улс багтдаг.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар бүлгийн Жаран наймдугаар зүйлийн 2-т «Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно.«, Жаран есдүгээр зүйлийн 1-д «Үндсэн хууль, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар батална.» гэж заасан үндэслэл нь хүндэвтэр нөхцөлтэй журамд хамаарна гэж Үндсэн хуулийн эрх зүйчид болоод судлаачид дүгнэн хэлдэг билээ.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдснаас хойш анх удаа Үндсэн

1 Б.Чимид. Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн тогтсон тухайд. Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал сэдэвт бага хурлын материалын эмхтгэл. УБ., 2005. 30 дахь тал.

2 П.Очирбат. "Алдаж болохгүй агшин". УБ., 1997. 363 дахь тал.

3 Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдснаар Үндсэн хуулийн тогтвортой байх чанар хадгалагдаж, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хуульчлагдаж өгсөн явдал цаашид Үндсэн хуулийг боловсронгуй болгох эрх зүйн орчинг улам төгөлдөржүүлэх ач холбогдолтой гэж дүгнэн хэлж болно.

Улсын Их Хурал, хууль санаачлагч нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны бүх үе шатанд Үндсэн хуулийг дээдлэн сахих, түүний тогтвортой байдлыг хамгаалах; ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах; бодитой, ил тод байх гэсэн үндсэн зарчмыг баримтлах учиртай.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн агуулга, хязгаар болон Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болох нөхцөлийг, хууль санаачлагч өөрийн хүслээр хуулийн төслийн бичвэр өргөн барих биш, харин төрийн гол хууль санаачлах өндөр шаардлагыг хангах хэмжээнд асуудлыг нягтлан боловсруулах ёстойг, мөн Үндсэн хуульд зөвхөн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулах, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг ердийн хууль хэлэлцдэг дэгийг баримтлахгүй байхыг хуульчилж өгснөөрөө тус Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн онцлог, ач холбогдол оршиж байгаа юм.

Иймд өнөөдөр Үндсэн хуулийн «дагуух» шинэтгэлийг хийх цаг болсон гэдгийг цаг хугацаа харуулж байна.

Харин энэхүү шинэтгэлийг дотоод, гадаад олон учир шалтгааны үндэс болгон харгалзваас парламентын Бүгд найрамдах хэлбэрээс татгалзах эсэх, эсхүл эл засгийн хэлбэрээ бэхжүүлж, парламентат ёсыг төгөлдөржүүлэхэд анхаарлаа хандуулах уу гэдэг нь бидний өмнө тулгамдсан зорилт болж байна. Иймд Монголын нийгмийн улс төрийн харилцааны үндэс нь олон нам үндэслэсэн парламентат ёс тул түүнийг бэхжүүлэх нь зөв зүйтэй алхам болж чадна гэж миний бие үзэж байгаа билээ.

Тэгвэл парламентын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож төлөөллийн ардчиллыг улам төгөлдөржүүлэх, парламентын тогтолцоонд шинэчлэл хийх чиглэлээр хийгдэж буй эхний ажил бол парламентын хоёр танхимын асуудал юм. Улсын Их Хурал нь Төлөөлөгчдийн Танхим, Үндэсний Зөвлөл гэсэн хоёр танхимтай байх эсэх асуудал билээ.

*Аливаа улс орон парламентын хоёр танхимтай болох үйл явц нь парламентат ёсны хөгжлийн үр дүнгээр тодорхойлогддог байна.*[4] Тэгэхлээр парламентын хоёр танхимтай болох эсэх асуудал тухайн оронд тохирох, эс тохирох асуудал гол биш байна. Гэхдээ тухайн улсын төрийн байгууламж холбооны, эсхүл нэгдмэл гэдгээс тодорхой хэмжээнд хамаарах боловч нэгдмэл улсын хувьд дээд танхимыг хэрхэн, яаж бүрдүүлэх асуудал чухлаар тавигддаг байна.

Мөн танхимын гишүүдийн тооны асуудал чухал бөгөөд Төлөөлөгчдийн танхим нь Монгол улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгосон 108 гишүүнээс бүрдэх; харин Үндэсний зөвлөл буюу дээд танхим нь 51 гишүүнээс бүрдэх эсэх асуудал ч гэсэн онолын болон практик, судалгааны түвшинд маргаан, мэтгэлцээн өрнүүлэн цаашид боловсронгуй болгох асуудал яригдаж байна.

Ер нь улс төр судлалын болон Үндсэн хуулийн эрх зүйн нэг маргаантай асуудал бол парламентын гишүүний тоо. Алив улс үндэстэн парламентын хэдэн гишүүнтэй байх нь хүсэл зоригийн хэрэг байдаггүй. Төр ёсных нь түүхэн уламжлал, үндэсний онцлог, газар зүйн байрлал, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо зэрэг олон нөхцөл, хүчин зүйлийг харгалзан үзнэ.

Улсын Их Хурлын нийт гишүүн нь Үндсэн хуульд заасан ёсоор 76 гишүүн байгаа билээ. Монгол Улсын Их хурлын гишүүний тоог их байна гэж үзэж, гишүүний тоог цөөлөх саналтай сонгогчид байдаг ба түүнчлэн Улсын Их Хурлын гишүүд дотор ч тийм бодолтой, тийм дүгнэлтэд хүрсэн гишүүд цөөнгүй байна.

4 Л.Өлзийсайхан. Парламент. УБ., 2001,53 дахь тал.

Монгол Улсын Их Хурлын гишүүний тоо их биш гэдгийг 2 сая хүн амтай улс орны парламентын гишүүний тоотой харьцуулан үзэхэд[5] манай улсын гишүүний тоо 76 байгаа нь их биш гэдгийг дээрх судалгаа харуулж байна. Тэгэхлээр Улсын Их Хурлын гишүүний тоог 99 болгох гэсэн асуудал ч тавигдаж байгаа билээ.

Үндсэн хууль бодитой оршихын шалгуур нь хууль тогтоох журмаар баталсан ямар нэг хууль зүйн бичвэр байхын нэр огт биш. Харин хяналт, тэнцвэрийн зарчмын дагуу төрийн эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийн баталгааг жинхэнэ ёсоор хангасан байх явдал юм.[6] Эрх зүйн сэтгэлгээ, тэр тусмаа Үндсэн хуульт ёсны нэн чухал ололт, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлд төрийн эрх мэдлийг хуваарилах асуудал зүй ёсоор орно.[7]

1789 оны Францын «Хүний болон иргэний эрхийн тунхаг»-ийн 16 дугаар зүйлд «Хүний эрхийг хамгаалаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй улсад Үндсэн хууль оршдоггүй» гэж заасан билээ. Иймд төрийн эрх мэдлийн байгууллагуудын хооронд харилцан тэнцвэртэй, бие биенээ тэгш хянах, харьцангуй бие даасан байх хийгээд үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоог улам тодорхой болгож төгөлдөржүүлэх нь тулгамдсан асуудал юм. Тухайлбал, Монгол улсад төрийн эрх мэдлийг хуваарилсан Үндсэн хуулийн үзэл баримтлалын гол агуулгыг тодорхойлж, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хооронд харилцан тэнцвэр барьсан, бие биенээ тэгш хянасан, харьцангуй бие даасан байдалтай байх шаардлагыг хангахуйц дотоод динамик механизмыг тодорхойлох нь нэн шаардлагатай байна.

Манай улс 1992 оны 1 дүгээр сарын 13-нд ардчилсан Үндсэн хуулиа батласнаас хойш зөвхөн нэг удаа 2000 оны 12 дугаар сарын 14-нд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан нь өнөөдөр хүртэл маргаан зөрөөтэй байсаар байна.

Энэ нэмэлт, өөрчлөлтийн талаар засаг төр, нам, улс төрийн байгууллага, эрдэмтэн судлаачид өнөөдрийг хүртэл өөр өөр байр суурийг илэрхийлж ирсэн нь түүнийг эргэн харж нэгэн мөр шийдвэрлэхийн чухлыг басхүү харуулсаар байна. Энэ хүрээнд тодруулбал:

**1. Үндсэн хуулийн Хорин долдугаар** зүйлийн 2-ыг «Улсын Их хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа далан тавaас доошгүй ажлын өдөр чуулна» гэснийг «Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулж» байхаар өөрчлөн найруулсны талаар:

- Улсын Их Хурал нь хууль тогтоох байнгын буюу тасралтгүй ажиллах байгууллага байх нөхцөл шалгуурыг дордуулсан;
- жилийн ихэнх үлдсэн хоногт юу хийх вэ гэсэн олон ойлгомжгүй асуудлууд гарч ирсэн;
- чуулган гол хэлбэр мөнийг огт харгалзаагүй;
- Улсын Их Хуралд байнга сууж, хууль тогтоох гишүүний үүрэг эрс багасав гэсэн шүүмжлэлийг;

**2. Үндсэн хуулийн Хорин долдугаар** зүйлийн 6-г «Үндсэн хууль, бусад хуульд өөрөөр заагаагүй бол УИХ-ын нийт гишүүний дийлэнх олонхи нь хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд үзэж, чуулганд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ» гэснийг «УИХ-ын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн санаалаар асуудлыг шийдвэрлэнэ» гэж өөрчлөн найруулж, «Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ» гэж нэмсэн нь:

- гишүүд чуулгандаа ирэх нь ховордсонтой холбоотой өөрчлөлт мөн;
- чуулган хүчин төгөлдөр байх шаардлага илт суларсан. 39:2=19.5 (20) гишүүн хууль батлах болсон;
- асуудал олонхиор шийдэх зарчмыг алдагдуулж, төлөөллийн үүрэг, ач

---

5 Д.Лундээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005. 114-117дахь тал. /судалгааг дэлгэрүүлэн үзнэ үү/

6 Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010. 9 дэх тал.

7 Д.лундээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001. 49 дэх тал.

холбогдлыг бууруулсан;

- саналаа чөлөөтэй гаргах боломж хаагдсан (багассан);
- нэмэлт ёсоор саналаа илээр гаргах нь гишүүнд тавих намын хяналтыг ноёлох байранд гаргасан гэсэн шүүмжлэлийг;

3. **Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 1-ийг** «УИХ-ын гишүүн нь хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэснийг «УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй» гэж өөрчлөн найруулсан нь:

- Үндсэн хуулийн нэгэн гол үзэл баримтлалыг алдагдуулсан явдал болсон,
- эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулж, парламентыг гүйцэтгэх эрх мэдэл нь давамгайлж байсан хуучин тогтолцоог сэргээсэн,
- /Герман *-646*, Англи *- 1855* буюу нийтийн танхим *- 659*, Лордын танхим *- 1196* гишүүнтэй/ Иймээс тэнд цөөн сайд парламентад ялимгүй хувь эзэлдэг. Тэгвэл 20 гишүүн хууль баталж буй манай нөхцөлд Засгийн газрын олон гишүүн давамгайлах боломжтой байдал бий болоод байгаа гэсэн шүүмжлэлийг;

4. **Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1.2-ыг** «УИХ-д олонхи суудал авсан намтай, аль ч нам олонхийн суудал аваагүй бол УИХ-д суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох санал, түүнчлэн Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулах» гэснийг «УИХ-д олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг, аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг, хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах» гэж өөрчлөн найруулсан нь:

- субъект эсрэгээр солигдсон. Энэ асуудлаар Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг хасаж нам эдлэх болсон. Ерөнхийлөгч хийдэг зарим ажил, шийддэг асуудлыг намтай урьдчилан зөвшилцөх эрхийг хасаж зарчмыг гуйвуулсан. Тэрээр зөвхөн намуудын хүсэл зоригт захирагдах болгосноор, болзошгүй хуйвалдаан гарч, бүлгийн сонирхлыг Төрийн тэргүүнд тулгах боломжтой болсон гэсэн шүүмжлэлийг

5. **Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1-д** «УИХ-ын дарга, дэд даргыг УИХ-ын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа нууцаар гаргаж сонгоно» гэснийг эхний хэсэг хэвээр «УИХ-ын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс УИХ-ын дэд даргыг сонгоно» гэж нэмсэн нь:

- гишүүд саналаа ямар ч хавчлагагүй, чөлөөтэй гаргах эрхийг хязгаарласан,
- намын шууд хяналт буюу «нүдлэн хамгаалалт» тогтоосон,
- даргын орон тоо нэмсний дээр «бүлэггүй» гишүүний дэд даргаар сонгогдох эрхийг хассан гэх үндэстэй гэсэн шүүмжлэлийг,

6. **Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2-т** «МУ-ын Ерөнхий сайд засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлнэ» гэснийг эхний хэсэг хэвээр «Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол УИХ-д өөрөө өргөн мэдүүлнэ» гэсэн 2 дахь хэсэг нэмсэн нь:

- хэрэв санал зөрвөл Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчийнхээ «дээгүүр нь алхах» болгов,
- гүйцэтгэх эрх мэдлийг хянах, чиглүүлэх төрийн тэргүүний үүргийг үгүйсгэж, Ерөнхийлөгч, Засгийн газар хоёрын «эрх зүйн холбоог тасалж хамаарлыг» алдагдуулсан.

7. **Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2-т** «УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл энэ шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын

даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ» гэснийг «Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол МУ-ын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл МУ-ын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах тухай шийдвэр гаргана» гэсэн дугааргүй хэсэг нэмсэн нь:

- Ерөнхийлөгчийн санал болгох эрх зүйн үндэслэл буюу парламент тарах нөхцлүүдийг органик хуулиар нэрлэн тогтоох шаарлагатай байтал ганцхан «тохиолдлыг» үндсэн нөхцөл болгон зааж явцууруулсан,
- «боломжгүй» болсон гэж үзэх нийтлэг үндэслэлийг мөн органик хуулиар олон нөхцөл (болзол) тогтоон эрэмбэтэй заах шаардлагатай бөгөөд эл шаардлага хэвээр байвч Үндсэн хуулийн «шинэ заалт» саад учруулахаар болжээ[8] гэсэн шүүмжлэлийг Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн эргэн тойронд[9] гэсэн бүтээлд болон эрдэмтэн судлаачдын бүтээлд олонтаа дурдсан байгааг хэлж болно.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эргэн тойронд байгаа дээрх шүүмжлэл, маргаан, санал дүгнэлтийг бид эргэн харах, засан сайжруулах, алдаа оноогоо дүгнэх цаг болсноос гадна эл нэмэлт, өөрчлөлт орох болсон 1998, 1999, 2000 оны бодит түүхэн улс төрийн үйл явцыг бас санах, мартах ёсгүй билээ.

Хэдийгээр УИХ-ын чуулган чуулах хугацаа 75-ыг 50 болгосон ч 2000 оноос хойшхи бүхий л чуулган 75-аас доошгүй ажлын өдөр чуулсан байдаг. Эндээс харвал УИХ-ын чуулах хугацааг заавал хагас жил тутам нэг удаа гэхгүй улирал тутам 35-аас доошгүй ажлын өдөр чуулахаар болговол байнгын байгууллага гэдэг шинжиндээ илүүтэй нийцнэ гэж үзэж байна.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр чуулганыг хүчинтэйд тооцох заалт нь «төрийн машин» гацахгүй ажиллах нөхцөл болж өгсөн бөгөөд хэрэв дийлэнх олонхоор гэж хуучныг нь сэргээвэл Үндсэн хуульд УИХ-ын гишүүдийн чуулган, байнгын хорооны хуралдаан орхих, завсарлага авах эрхийг хязгаарлах заалтыг оруулах шаардлага зайлшгүй үүснэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол саналаа илээр гаргаж шийдвэрлэх заалт нь ард түмний элч-төрийн түшээгийн өгсөн санал нээлттэй байх нь сөрөгөөсөө эерэг тал нь илүүтэй гэж үзэж байна.

Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад нэр дэвшигчийг тав хоногийн дотор УИХ-д оруулах болон Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний талаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөх заалт мөн л улс төрийн амьдрал буюу улс төрийн намууд Ерөнхийлөгчийн харилцаанаас үүдсэн зайлшгүй шаардлагаас урган гарсан гэдгийг хэлэх хэрэгтэй.

Сонгуульд олонхи болсон эсхүл хамгийн олон суудал авсан нам Ерөнхий сайдад нэр дэвшигчээ УИХ-д оруулж чадахгүй бол сонгуульд оролцсоны утга учир алдагдахад хүрнэ хэмээн тайлбарладаг.

Ер нь Монгол Улс бол парламентын засаглал бүхий улсын хувьд Ерөнхийлөгчид шууд ба шууд бус замаар тодорхой бүрэн эрхүүдийг органик ба бусад хуулиар шилжүүлсээр байгаад эрх мэдлийн тэнцвэрийг алдагдуулж мэдэхээр болоод байна гэсэн судлаачидын шүүмжлэлийг хуваалцахаас аргагүйд хүрч байна.

УИХ-ын дэд даргыг нам, эвсэлийн бүлэг тус бүрээс сонгох болсон нь парламентын засаглалтай улс орнуудын жишиг юм. Онолын хувьд олон дэд дарга гарах боломж байвч практик амьдрал дээр гурваас нэг их хэтрэхгүй гэж тооцоолсон юм.

УИХ-ын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр хавсран ажиллахыг зөвшөөрсөн эл заалтыг эргэн харах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Гэхдээ үүнийг хэт

8 Б.Чимид. Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. УБ., 2008. 192-194 дэх тал.

9 Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн эргэн тойронд. УБ., 2010 он.

нэг тийш нь туйлшруулан шийдэж болохгүй юм.

XX зуунд төрийн эрх мэдлийг хуваарилах онолд гарсан нэг модернизаци бол хууль тогтоох байгууллагын гишүүн нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын удирдлагад ажиллах боломжийг үгүйсгэхгүй гэсэн баримтлал юм.

Гэхдээ манай улсын тухайд парламентын гишүүний тоо харьцангуй цөөн, нэг танхимтай парламент учраас УИХ-ын гишүүдээс Засгийн газрын бүрэлдэхүүнийг бүхэлд нь бүрдүүлэх зохимжгүй юм. Иймд Ерөнхий сайд болон үндсэн чиг үүргийн яамд болох Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй дотоод хэргийн яамны эрхэлсэн сайд нарыг буюу Засгийн газрын танхимын гуравны нэг хүртэлх хэмжээнд л байхаар хязгаарлаж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлд «Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Монгол улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн УИХ-д өргөн мэдүүлнэ. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр УИХ хүн бүрээр хэлэлцэж томилно» гэж заасан.

Засгийн газрыг Ерөнхий сайд удирдаж, үйл ажиллагаагаа УИХ-ын өмнө хариуцдаг явдал нь Ерөнхий сайд өөрийн танхимын гишүүдийн хамт улс төрийн хийгээд хууль зүйн үзэл бодлын хувьд нэг бодлогыг барих учиртай. Иймд Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлд зааснаар Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцаж байгаагийн хувьд бүрэлдэхүүнээ өөрөө томилж бүрдүүлдэг байх нь илүү зохимжтой хувилбар байх талтай.

Жишээ нь, парламентын улсын сонгодог хэлбэр ХБНГУ-ын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар Холбооны Канцлерийг Холбооны ерөнхийлөгчийн санал болгосноор Бундестаг томилдог. Мөн тус хуулийн 64 дүгээр зүйлээр Засгийн газрын гишүүдийг Канцлерийн санал болгосноор Холбооны ерөнхийлөгч томилж, чөлөөлдөг гэсэн практикийг ч олзуурхан харах хэрэгтэй байна.

Мөн Үндсэн хуулийн тайлбар гаргах эрх нь аль институтэд хамаарах тухай хуулийн хэм хэмжээ тогтоогүй байгааг анхаарах цаг болжээ.

Өдгөө судлаачид Үндсэн хуулийн цэцийг Үндсэн хуулийг тайлбарлах ёстой гэсэн үзлийг олон улсын жишиг, онолын үүднээс хэвшүүлэхийг оролдож байгаа. Харин одоо хуульчлах шаардлага байгаа.

Эрх зүйн аливаа тайлбар нь хуулийн утга санааг бүрэн гүйцэд нээн харуулахын оронд хэн нэгний «шахалт дарамтаар» эсхүл «захиалгаар» хийгдэх учиргүй. Энэ тохиолдолд хуулиа илүү тодорхой хийдэл, цоорхойгүй гаргаж байж л үүнийг даван туулна.

Улсын Дээд Шүүхээс гаргаж буй хуулийн тайлбар эсхүл Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, сайд нарын тогтоол, тушаалаар баталсан хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмууд нь уг хуулийнхаа утга агуулгаас халих улмаар УИХ-ын хууль тогтоох эрх мэдэлд халдсан шинжтэй болдогийг анхаарах цаг болжээ.

Иймд Үндсэн хуульд заасан Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарлах эрхийн зохицуулалтыг органик хуулиар нарийвчилан тодотгож өгөх шаардлага тавигдаж байгааг тэмдэглэе.

Төвлөрлийг сааруулах тэр дундаа нутгийн удирдлагын эрхийг өргөтгөх тухай санал санаачлага хүчтэй яригдаж байна.

Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс бөгөөд үндэсний аюулгүй байдлын эрх ашиг, бүс нутгийг жигд хөгжүүлэх шаардлагаас үүдэн орон нутагтай харилцах төв засгийн эрх мэдлийг багасгаж болохгүй гэж үзэж байна.

# МОНГОЛЫН ЭКОЛОГИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Осорын Амархүү*

*Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Монгол Улсын гавьяат хуульч*

Монголын хууль зүйн шинжлэх ухааны түүхэн замналын хүрээнд Экологийн эрх зүй хэмээн нэрийдсэн салбар шинжлэх ухаан хэрхэн үүсч, хэрхэн хөгжиж байгаа асуудлыг судлан шинжилж, шинжлэх ухааны үндэслэл бүхий тайлбар хэлнэ гэдэг бол сонирхолтой сэдэв.

Энэ сэдвийг судлахдаа эрх зүй судлалын ерөнхий онолыг түшиглэж салбар эрх зүй судлалын онол, арга зүйг удиртгал болгох ёстой гэж үзэж байна. Энэ утгаар нь авч үзвэл экологийн эрх зүйн шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн асуудал манайд төдийлэн тусгайлан судлагдаагүй байгаа гэж хэлж болно. Харин экологийн эрх зүй бол шинжлэх ухааны нэгэн салбар гэж хүлээн зөвшөөрөгдөх хүртэл түүний суурь судалгааны гол элемент нь болсон эрх зүйн хэм хэмжээ буюу хууль тогтоомжийн судалгаа багагүй хийгдсэн байна. Энэ бол хөгжлийн нэг алхам мөн.

Үүнээс үндэслэн бивээр шинжлэх ухаан, хууль тогтоомж гэсэн ойлголтын хооронд тодорхой орон зайтай гэж үзэж байна. Юу вэ гэвэл, хууль тогтоомж бол байгаа зүйл буюу позитив хандлага, цаана нь эрх зүйд хандах позитив бус хандлага буюу байх ёстой зүйл гэж бий. Чухам үүний хувьд судалгааны ажил орхигдоод байна гэж үзэж буй.

Энэхүү сэдвийг судлахдаа эрх зүйн либерал онолд тулгуурлаж экологийн эрх зүйн хэм хэмжээг нийгмийн бусад хэм хэмжээтэй харьцуулж, хослол цогцол, ялгагдах онцлог, харилцан нэг нэгнээ сэлбэж баяжуулах өвөрмөц шинжийг тусгасан танин мэдэхийн учир холбогдлын өнцгөөс хандсан болно.

Экологийн эрх зүй судлалыг материаллаг-зан үйлийн хэм хэмжээний; хэлбэрийн-эрх зүйн хэм хэмжээний гэсэн өөр хоорондоо уялдаа бүхий эх сурвалжаас ургуулан авч үзэж тайлбарлах нь эрх зүйн онолын сэтгэлгээнд илүү тохирох болов уу гэж бодож байна.

Монголын экологийн эрх зүйн шинжлэх ухааны үүсэл, хөгжлийн асуудлыг он тооллын хугацааны хувьд авч үзвэл:

- **Нэн эртний буюу Хүннүгийн Монголоос Тэмүүжинг Чингис хаанд өргөмжилсөн үе хүртэл;**
- **XIII зууны эхэн үеэс үндэсний ардчилсан хувьсгалын ялалтыг хүртлэх үе;**
- **Үндэсний ардчилсан хувьсгалын ялалтаас ардчилал, зах зээлийн эдийн засгийн хувьсгал буюу шинэ Үндсэн хууль(1992 оны) хүртлэх үе;**
- **XX зууны сүүлчээс XXI зууны эхэн үе гэсэн дөрвөн үндсэн үе шатад хувааж үзэж болохоор санагдана.**

Нэгдэх үе буюу Монгол туургатан бүрэлдэн тогтсон, Монгол төрт ёс эхлэн тогтсон тэр үед байгальд хандах, байгалийн баялагийг амьдрал ахуйдаа ашиглаж хэрэглэх хууль цаазны уламжлал ямар байсан нь эдүгээ хүртэл үндсэндээ судлагдаагүй үлджээ.

Харин бусад гурван үед нь байгаль хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх асуудалтай холбоо бүхий **монгол хууль цааз буюу эрх зүйн уламжлал, шинэчлэлийн асуудал** багагүй судлагдсаар иржээ. Жишээ нь: Т.Сэнгэдорж Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал: уламжлал, шинэчлэл, 1994; Д.Лүндээжанцан Экологийн эрх зүй: Хууль тогтоомж, зөрчил

хариуцлага, 1995; О.Амархүү Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил, хууль цааз. Уламжлал, шинэчлэлийн асуудал. 2000, гэх мэт бүтээлүүд гарчээ.

Хууль цааз буюу эрх зүйгээс бүр урьд өмнө нь байсаар ирсэн манай өвөг дээдсийн газар шороо, уул ус, ургамал, амьтан, эрдэнэс баялагаа хайрлан хамгаалж, ухаалаг ашиглаж ирсэн **монгол аж төрөх ёс, хэв заншил, зан үйл** XX зууны дунд буюу сүүлч үеийг хүртэл судалгааны анхааралд өртөөгүй явж ирсэн гэж үзэж болохоор байна. XX зууны дунд үеэс энэ асуудал хуульч, түүхч, угсаатны зүй судлаач, шашин номын судлаач зэрэг эрдэмтэд, судлаачдын судалгааны ажлын эргэлтэд үүвэр түүвэр байдлаар орж эхэлсэн. Тэдний ээлд нь гэвэл О.Амархүү, Т.Сэнгэдорж, Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл, Ж.Саруулбуян, О.Сүхбаатар, С.Бадамхатан, Т.Содной нарыг нэрлэж болно.

Эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар **байгаль хамгаалах монгол уламжлалт зан үйл бол өргөн утгаараа эх орны маань байгаль орчин, монгол хүний оюун ухаан хоорондын шүтэлцээт холбоо, монголчуудын оюуны их өв сан гарцаагүй мөн.**

Гэтэл тийм их өвөрмөц онцлог, үнэт зүйлс цаг хугацааны явцад аажмаар бүдгэрэн орхигдож гээгдсээр, зарим нь бүр мартагдаж арилсан байдал бодитой болсон.

Монголчуудын үндэсний язгуур эрх ашиг болж, нутаг усандаа ухаалаг эзэн нь байж чадсан байгальд хандах уламжлалт зан үйлийн агуулга, арга хэлбэрийн талаар миний бие 1997 онд олон улсын монголч эрдэмтдийн VII их хуралд «Монголчуудын байгаль хамгаалах түүхэн өв уламжлал» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Энэ илтгэл өгүүлэн буй сэдвээр монголдоо судалгааны ажлын анхны багцлал байсан бөгөөд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг багагүй татаж байсан.

Уламжлалт хэв шинжүүдийг тогтож хэвшсэн зан үйлийн агуулга, хэлбэрээр нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий таван төрөлд ангилан үзэх онол, арга зүйн асуудлыг илтгэлдээ товойлгон тавьсан юм.

**Энэрэл хүндэтгэлийн**

Газар нутаг, уул ус, ургамал, мал амьтнаа хүндэтгэн хамгаалж, туйлын ариг гамтай хэрэглэх ухаан.

**Хорио цээрлэлийн**

Байгаль хамгаалах сэтгэлгээ, соёлыг хувь хүнд төлөвшүүлж, байгальд хандахдаа ямар үйлийг тэвчин цээрлэх, байгалийн өөрөө сэргэн төлжих чадавхийг хадгалан үлдээх ухаарлыг суулгах арга ухаан.

**Сургаал номлолын**

Энэрэл хүндэтгэл, хорио цээрлэл, байгалийн жам ёсыг танин мэдүүлэх, байгалийн баялагийг арвич хямгач ашиглах арга ухааныг хүний ой тойнд суулгаж хэвшүүлэх зан үйл.

**Сүсэг бишрэлийн**

Эртний шүтлэгийн хэлбэрүүдээс эхлээд бурхны шашны номлол, ёс жаяг, ардын зан заншилтай харилцан сүлбэлдэж байгальд хандах зэрэг сэтгэлгээ суулгах арга ухаан

**Ажиглаалт, танин мэдэхүйн**

Цаг агаарын хувьсал өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдлийг урьдаас ажиглан танин мэдэрч, ажил төрөл, амьдрал ахуйгаа тохируулан, байгальтай дасан зохицож аж төрөх нүүдэлчдийн мэдлэгийн өв сан, ахуйд илүү ойрхон мэдлэг.

Хүн, байгаль хоёр улам бүр харилцан хамааралтай болсон өнөөгийн нөхцөлд уламжлалыг судлан сэргээнэ гэдэг маань өнгөрсөн цагаараа амьдарна гэсэн үг огт биш, өвгөд дээдсийн ухаанаар аьдарна гэсэн үг.

Монгол төрийн байгаль хамгаалах хууль цааз монголчуудын уламжлалт зан үйл дээр тулгуурлан бий болсон гэсэн дүгнэлт хийж байна. Эрх зүйн ерөнхий онголын үүсэл хөгжил Өрнөдийн, Дорно дахины гэсэн хоёр том урсгалаас угшилтайг Та бүхэн сайн мэднэ. Монголын хувьд Дорно дахины, тэр дундаа Хятад, Энэтхэгийн угшилтай гэж эрдэмтэд, судлаачид үзэх боллоо. Миний бодлоор энэ хоёр орны угшилыг бодолцохын зэрэгцээ Монголын гэсэн өөрийн угшил байгаа биш үү. Энэ нь экологийн эрх зүйн шинжлэх ухаанд бүр ч илүү тод харагдаж байгаа гэж бодож байна.

XIII зууны эхэн үеэс үндэсний ардчилсан хувьсгалын ялалтыг хүртлэх үед бий болж хэрэгжиж ирсэн Монголын хууль цаазын эх сурвалжуудыг судлан үзэхэд экологийн эрх зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх гурван гол чиг хандлага гарч ирсэн гэж үзэж болохоор байна.

Нэгд, томоохон эх сурвалжуудад байгаль хамгаалах, баялагийг нь ухаалаг ашиглах зүйл, заалтуудыг тусгайлан оруулж, чанд сахин мөрдөж ирсэн; хоёрт, Монгол оронд тусгай хамгаалалттай газар нутгийг анх удаа хуульчлан тогтоосон, гуравт, байгаль хамгаалах уламжлалт зан үйлийг зориуд хуульчилж, байгаль хамгаалах анхны төрөлжсөн хууль батласан, ийм байдлууд илт харагдаж байгаа юм.

Үүний нэгдэхийг агуулгаар нь тоймлон хэлбэл:

- 1206 онд батласан Монголын нэгдсэн төрийн анхны бичмэл хууль- Их засагт 4 зүйл орсон.
- Юан гүрний хууль зарлигуудаас хамгийн томоохонд тооцогддог Их Юаний нэвтэрхий хуульд 3 зүйл орсон.
- XVI зууны сүүлчээр бий болсон Алтан хааны цаазын бичигт 10,11 дүгээр зүйл, есдэх хэсгийн 91-95 дугаар зүйл, нийтдээ 7 зүйл заалт орсон.
- 1640 онд бий болсон Дөчин дөрвөн хоёрын их цааз буюу Монгол-Ойрадын хуульд 3 зүйл орсон.
- 1643-1795 оны үед дагаж мөрдөж ирсэн Монгол цаазын бичигт 6 зүйл орсон.
- XVIII зуны эхэн үеэс XX зууны эхэн үе хүртэл 200 гаруй жил үйлчилсэн Халх журамд агуулгаар нь авч үзэхэд 9 зүйл орсон, ийм 6 томоохон хуулийн 32 зүйл заалтыг хамруулсан гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй байгаа юм.

Хоёрдахь нь гэвэл, Богд хан хайрхан уулыг дархан цаазтай болгох тухай санал санаачлагыг Их хүрээний сайд Юндэндорж, ноён Сансайдорж нар гаргаж, өргөх бичгийг Манж Чин улсын хаанд өргөн мэдүүлснийг хүлээн авч, Тэнгэрийг тэтгэсний 43 дугаар оны 9 дүгээр сарын 24-ний өдөр буюу 1778 онд Богдхан уул, Хан хэнтий, Отгонтэнгэр уул, Дарь (Алтан) овоог дархан цаазтай газар нутаг болгосон зарлиг гарсан гэсэн түүхэн баримт байгааг онцлож байна. Нэрлэсэн газар нутгууд дэлхийн анхны дархан цаазат газрууд ч байж мэднэ.

Гуравдахийн хувьд 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Монголын үндэсний тусгаар тогнолыг сэргээн тунхагласны дараа Богд Жавзандамба Хутагт хааны зарлигаар 1915 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын хуулийг зохиох тусгай ажлын хэсэг байгуулагдаж, 1915-1918 онуудад хуулиудыг зохион боловсруулж ээлж дараалан баталсан Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг 65 дэвтрээр бий болсон том үйл явдлыг хамруулах нь зүйтэй гэж үзсэн болно. Энэхүү 65 дэвтэр хуулиудаас 7 дэвтэр хуульд нь байгаль хамгаалах, байгалийн баялагийг зөв зохистой ашиглах, цаг агаарын төлөв байдлыг ажиглан, танин мэдэж, ган, зуд зэрэг байгалийн гамшигтай дасан зохицож амьдрал, ахуйгаа эрхлэх агуулга бүхий 20 гаруй зүйл заалт орсон байна. Үүний дотор Гучин хоёрдугаар дэвтэр нь «Тайх тахиглах ёслолын хууль» гэсэн уламжлалт зан үйлийг хуульчилсан байгаль хамгааллын анхны төрөлжсөн хууль байв.

Монголын экологийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжлийн гуравдахь үед бас онцлог ажиглагддаг. Эрх зүйн эх сурвалж нь нэгд, байгалийн баялагийн төрөл тус бүрээр дүрэм, заавар, тогтоол зэрэг эрх зүйн актаас бие даасан төрөлжсөн хууль гарах хүртэл өргөжин хөгжсөн, хоёрт, эрх зүйн зохицуулалтад хамрагдсан объект нь байгалийн төрөл зүйлүүдээс хальж, хүний амьдралын эрүүл, аюулгүй орчны харилцааг хамарч өргөжиж тэлсэн онцлогтой гэж үзэж болно.

Дөрөвдэх үе шатыг товчдоо шинэ зууны шинэ хандлага гэж хэлж болно. Шинэ Үндсэн хуульдаа тулгуурлаж, хүрээлэн буй орчны асуудлыг иж бүрдлээр нь хамаарсан олон тооны хуультай боллоо. Тэр дотроо Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус, цаг уур, орчны шинжилгээний тухай хууль, Байгаль орчны үнэлгээний тухай хууль гэх мэтийн кодекс хуулиуд ч төрөв. Эдгээр нь хөгжлийн нэг чухал ахиц дэвшил, шинжлэх ухаан цаашид гүнзгийрэн, улам нарийвчлагдахыг амьдрал шаардаж байгааг хүлээн зөвшөөрсний бодит шинж төлөв мөн.

Эцэст нь онцлон хэлэхэд олон хуультай болсноор шинжлэх ухаан сайхан хөгжиж байгаа гэж хэн ч хэлэхгүй. Цаашид гурван гол асуудалд анхаарал хандуулах ёстой гэж үзэж байна. Нэгд, байгаль орчны хуулиудыг улам бүр боловсронгуй болгож кодексжуулах зайлшгүй хэрэгцээтэй байна. Жишээ нь, газрын харилцааны хувьд л гэхэд 10-аад хууль байна. 10 хуулийг мэдэж, хэрэгжүүлэх, нэг цогц хуулийг мэдэж хэрэгжүүлэх, энэ хооронд мөн ч их зай байгаа биз. Хоёрт, ярьж буй сэдвээр эрдэмтэд, судлаачдыг олноор бэлтгэх асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэмээр байна. Гуравт, хууль зөрчиж байгаль орчныг сүйтгэдэг, хүн, мал сүрэг, ан амьтад, ус, ургамал, ой мод бусад амьд организмын хэвийн амьдрах орчингүй болгож байгаа айдас хүйдэс төрүүлж байгаа хувь хүн, аж ахуйн нэгжүүдийг хууль мэддэг, биелүүлдэг, дээдэлдэг оюун ухаантай болгомоор байна, төрийн хамгаалах чиг үүргийг амьд бодитой болгомоор байна.

# ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТАНД СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ АСУУДАЛ

*Роломсүрэнгийн Оюунбадам*
*/Монгол Улсын гавьяат хуульч, Шихихутуг ХЗДС-ийн багш/*

Улсын хэмжээгээр төрөл дэглэмийн хорих ангиудад жилд дунджаар 6800-7000 хоригдол ял эдлэж байна. Түүний 7% нь эмэгтэйчүүд 75 % нь залуучууд 0.6 % нь насанд хүрээгүй хүмүүс байна. Үүнээс 2120 хүн буюу 34 % нь хорих газраас суллагдаж, 2998 хүн шинээр хорих ял эдэлдэг. Нийслэл болон орон нутгийн урьдчилан цагдан хорих төвүүдэд дунджаар1200-аад сэжигтэн яллагдагчид хоригдож байгаагаас тодорхой хувь нь хэрэг нь хэрэгсэхгүй болдог. Түүнээс хавьгүй илүү хувь нь шинээр урьдчилан хоригддог гэсэн бодит статистик байна. Муу ёрын тойрог гэмээр нийгмийн энэ үзэгдэлийн цаана хүний эрх, хүний зовлон зүдгүүр, ааш, араншин хүсэл, хясал бүхэн хорих, цагдан хорих байгууллагийн ажилтны нүдэн дээр болж байдаг төдийгүй тэр болгоныг хэрхэн зохицуулах, яаж харьцах зэрэг хүндхэн хариуцлагатай тулгарна. Хоригдсон, цагдан хоригдсон нийт хүнийг хүн амын тоонд авч үзэхэд олон улсын хэмжээнд нэлээд өндөр үзүүлэлттэй байна. Аливаа этгээдийг үйлдсэн гэмт хэрэгт нь шийтгэх ба гэмт хэргийн сэжигтнээр татахад тухайн хувь хүн эр чөлөөгөө гэлтгүй бусад эрхүүдээ алдах эрсдэлтэй байдаг. Хувь хүн эрүүгийн хариуцлагад татагдаж шүүхийн өмнө зогсохдоо тухайн этгээд бүхэл бүтэн төрийн аппарат цагдаагийн байгууллага, байцаалтын өрөө, цагдан хорих байр, шүүхийн танхим, хорих ангитай нүүр тулдаг. Сэжигтнээр татагдсан мөчөөс эхлэн, баривчлагдах, саатуулагдах, мөрдөн байцаагдах, шүүх ажиллагаа болон давж заалдах зэрэг байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд хүний эрх зөрчигдөх өндөр эрсдэлтэй байдаг.

Шүүхээс өмнөх шатанд цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн, яллагдагчийн эрхийг хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудал өнөөдөр хуульчдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Аливаа хэлбэрээр хоригдсон болон саатуулагдсан хүмүүсийн дотроос хамгийн нарийн төвөгтэй, хамгийн маргаантай нь урьдчилан цагдан хоригдогчийн асуудал гэвэл маргах хүн гарахгүй байх. Урьдчилан цагдан хоригдогчид гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй учраас тэдгээр хүмүүстэй хуульд заасан хязгаарлалаас гадна аль ч шатанд хэтрүүлэн харьцах боломжгүй. Илүү иргэнлэг харьцаатай байхыг шаардана. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл хуульд заасан үндэслэн журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баримвчлах, хорих, мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заасан. Хэдийгээр хуульд заасан үндэслэлээр эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлаж байгаа ч гэсэн баривчлах ажиллагааны хэм хэмжээг хэтрүүлбэл дур мэдэн баривчлахтай адилтган үздэг. ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан **«дур мэдэн»** хэмээх нэр томъёог зөвхөн хууль бус хорьж саатуулахыг хэлээд зогсохгүй хүч хэтрүүлсэн, шударга бус болон хойшлуулшгүй эсхүл таамаглах аргагүй гэсэн нөхцлүүдийг агуулсан илүү өргөн агуулгатай гэж тайлбарласан байна. ИУТЭОУПактаар Хоригдсон буюу саатуулагдсан хүмүүст хүч хэтрүүлэн хэрэглэхийг хориглосон байдал бүх нөхцөлд хориглох боломжгүй юм. Учир нь хууль сахиулагч албан тушаалтнууд гарцаагүй тохиолдолд үүргээ биелүүлэхэд шаардлагатай хэмжээгээр хүч хэрэглэж болно. Тухайлбал хоригдлууд оргон зайлахыг завдсан болон бусад хууль ёсны хэв журам зөрчигдөж өөрт нь болон бусад хүмүүсийн амь насанд аюул заналхийлсэн ноцтой хүнд хохирлоос хамгаалах тохиолдолд хүч хэрэглэж болохыг дурьджээ.

Сэжигтэн яллагдагчийг баривчилж хорьж саатуулахдаа тэдний хэргийг мөрдөн байцааж байгаа албан тушаалтнууд зөвхөн хуулийн дагуу олгодог бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллах ёстой. Олон Улсын Хүний эрхийн хэм хэмжээ нь хүнийг хууль бусаар дур мэдэн баривчлиж эрх чөлөөг нь хязгээрлахгүй байх болон албадан суутуулагдсан үед гарч болох бусад хэлбэрийн зөрчил гарахаас давхар хамгаалсан байдаг.[1] Аливаа улс хуульдаа ямар албан тушаалтан хүний эрх чөлөөг хязгаарлах эрхтэй болохыг тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Албан тушаалтан хийсэн үйлдэлдээ ялангуяа баривчлах, хорих ял оногдуулах зэрэгтээ хариуцлага хүлээх нөхцөлүүдийг тусгах хэрэгтэй.[2] Эдгээрийг шүүхийн өмнөх шатанд заавал хийгдэх ёстой ажлууд гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үндсэн зарчмуудад зааж өгсөн байна. Нийгмийн сэтгэл зүйд цагдан хоригдож байгаа хүн бол эрх чөлөөгүй хүмүүс гэсэн ойлголт байдаг. Тэгвэл тэд бусдын нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх учиртай. 1992 онд Монгол улсын Үндсэн хууль Монгол улсын иргэн бүр, Халдашгүй дархан байх эрх, Эрх чөлөөтэй байх, Амьд явах эрхтэй гэж заасан нь хоригдож байгаа болон цагдан хоригдож байгаа хүнд нэн хамаатай. Эдгээрийн дотроос халдашгүй дархан байх эрхийг дараах байдлаар тайлбарлаж байна.

- ✓ Хоригдогчид хоригдож байх хугацаандаа эрүү шүүлт хилсээр хэрэгт тулгуулахгүй байх
- ✓ Хэн нэгний дарамт шаардлагад өртөхгүй байх
- ✓ Тэдэнд сэтгэл санааны дарамт учруулахгүй байх
- ✓ Эрүүл мэндээ хамгаалуулах
- ✓ Эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг ойлголт зэргээр тайлбарлдагдана.
- ✓ Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн хувьд сэжигтэн, яллагдагчид олгогдсон эрх эдлэх, үүрэг хүлээх
- ✓ Мэдээлэл авах
- ✓ Гадаад ертөнцтэй харилцах
- ✓ Өөрийн заяамал эрхээ хангуулах гэх мэт. Хоригдох нөхцөл журамтай холбогдуулан олон эрхүүдийг дурьдаж болно.

Жишээ нь нөхцөл сайтай байранд амьдрах, биологийн хэрэгцээ болон алдсан энергийг нөхөх хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, ундны усаар хангуулах, эмнэлэгийн үйлчилгээ авах, эрүүл мэндээ хамгаалуулах зэрэг олон зүйл багтана.

Даяарчлалын эрэн үед Монгол Улс зөвхөн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний эрхийг хамгаалах асуудлын талаар авч үзэх нь явцуу асуудал учраас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийг мөрдөх, бусад орны сайн туршлагуудыг өөрийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлэх боломжуудыг бүрдүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна. Олон улсын баримт бичигт хорих цагдан хорих газар бол заавал хянах ёстой газар гэж үздэг.Яагаад хянах ёстой вэ? гэвэл: Шүүхийн өмнөх шатанд гэмт хэрэгт сэжигтин яллагдагчаар татагдахад хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхээ алдах эрсдэлтэй байдаг. Иймд сэжигтэн ялдагчдийн эрхийн зайлшгүй хамааглах шаардлагатай болдог. Шүүхий нөмнөх шатанд байгаа гэдэг утгаараа сэжигтэн яллагдагийн эрхийн хамгаалах, тэдэнтэй харьцах талаар илүү болгооомжтой харьцах учиртай.

Хуульд заасан эрхийг хамгаалахын зэрэгцээ заяамал эрхийг нь хөндөхгүй нэр төрийг нь сэвтүүлэхгүй байхад анхаарах нь ардчилсан төрийн албан хаагчдын ёс зүйн болон мэргэжлийн өндөр түвшинд ажиллах ур чадвар юм. Хуулийн дагуу хоригдож буй хүмүүсийн эрх, эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдана. Тухайлбал гадгаш зорчих, эвлэлдэн нэгдэх эрхээ хязгаарлуулна. Нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдож байгаа ч түр саатуулагдаж байгаа хүмүүс, хоригдлууд нь хяналтын дор байдаг учраас эмзэг байдаг. Хоригдож байгаа этгээдийн эрхийн зарим хязгаарлалт нь түүний хувь заяанд нөлөөлсөн байдаг. Хуулинд тодорхойлсноор хорих цагдан хорих төв нь хаалттай бус юм. Тиймээс хоригдогч нийгмээс тусгаарлагдаж нийгмийн нөлөөлийн гадна үлддэг. Хорих ял эдлэгсэд нь хоригдож байгаа газраа ямарч цаг үед ширүүн догшин харьцаа амсах, эрүү шүүлтэнд өртөж болзошгүй байдаг. Хорих ял шийтгэлийн хамгийн хүнд хэлбэр юм. Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай

1 "Шударгаар шүүлгэх эрх" Эмнести Интернэшнл, 2012 он, 24 дэх тал
2 "Шударгаар шүүлгэх эрх" Эмнести Интернэшнл, 2012 он, 24 дэх тал

Монгол улсын хууль болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд сэжигтэн яллагдагчийг хүлээн авах тухай хангалттай заалтууд тусгалаа олсон хэдийч заавал биелүүлэх шаардлагуудыг хангасан байвал зохино. Эдгээрийг харьцуулан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Мэдээлэл авах эрх. Хоригдох этгээдийг хүлээн авахдаа шалган нэвтрүүлэх байрны харуул, ээлжийн дарга нар цагдан хорьж байгаа албан тушаалтынг байлцуулан үзлэг хийж, хориотой эд зүйлсийг хураан авч, тэмдэглэл хөтлөн холбогдох этгээдээр гарын үсэг зуруулна. Хоригдох этгээдийг хүлээн авсан тухай лавлагааг жижүүрийн туслах хөтлөх бөгөөд хүлээлгэн өгсөн албан тушаалтнаар лавлагаанд гарын үсэг зуруулна. Лавлагаанд уг этгээдээс баривчлах, хорих болсон шалтгаан, цагдан хорих гэж байгаа газрын талаар түүний ар гэрийхэн, төрөл төрөгсөд болон өмгөөлөгчид нь албан ёсоор мэдэгдсэн эсэх талаар лавлаж тэмдэглэл үйлдэнэ. Хоригдох этгээдэд хорих байрны дотоод журам, цагийн хуваарь, сахилгын шийтгэл ногдуулах журам, эрх, үүргийг нь тоо бүртгэлийн ажилтан танилцуулж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Хоригдох этгээдэд дээрх мэдээллийг бичгээр гаргаж өгнө. Жижүүрийн туслах уг мэдээллийг бичиг үсэг мэдэхгүй хүнд тайлбарлан өгөх үүрэг хүлээнэ[3] гэж манай хууль журамд заасан бол Олон улын баримт бичигт: Баривчлагдсан хүн бүрт түүнийг баривчлах болсон шалтааганыг баривлах үед нь мэдээлж аливаа сонгосон ялыг түүнд нэн даруй мэдэгдэх ёстой. Эрүүгийн хэргээр яллагдаж байгаа бүх хүн өөрийнхөө өмгөөлөгчтэй найдвартай уулзах цаг байрны нөхцөлөөр бүрэн хангах ёстой[4] гэжээ.

Гадаад ертөнцтэй харилцах бусадтай уулзах эрх. Албан тушаалтны албан ёсны зөвшөөрлийг үндэслэн 7хоногт 2 удаа 10-17 цагийн хооронд уулзах цагийн хуваарийг хорих ангийн дарга батална. Хоригдсон этгээдийг 1 удаагийн уулзалтаар уулзах түр хугацааны уулзалтыг 20 минутаас хэтрүүлэхгүй байхыг харуул хаамгаалатын ажилтанд хяналт тавьж хорих байранд хориглосон зүйл дамжуулахыг хориглоно. Хоригдсон этгээдийг бусадттай уулзахад нь иргэний бичиг баримтыг тоо бүртгэл дээр нь шалгаж найз нөхөд төрөл садангийн хүн мөн эсэхийг тулгаж шалгана[3] гэж монгол улсын хууль журам үздэг бол НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12-р сарын 9 ний өдөр 43\173-р тогтоолоор баталсан «Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц»-ын 19 дүгээр зарчим, НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харилцах асуудлаар анхны их хурал дээр 1955 онд баталсан «Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм» 37 дугаар зарчимуудад

Гадаад ертөнцтэй аль болох илүү холбоотой байхыг зөвшөөрч хөхүлэн дэмжих нь зүйтэй. Уулзалтын нөхцөл нь аюулгүй байдлын шаардага ба хүний нэр төрийг хүндэтгэсэн байх ёстой. Гэр бүлтэйгээ тусдаа уулзах өрөө тасалгааг урамшуулан дэмжих ёстой. Хоригдогчид зөвхөн гэр бүл, найз нөхцөөс гадна хуульч болон шүүхийн байгуулагын ажилтнуудттай уулзах эрхээр хангагдах ёстой гэж үзжээ. Мөн АНУ-ын өмнөт мужийн Луизиана, Миссисипи, Алабама мужийн цагдан хорих төвүүд болон засан сайжруулах газрууд сонин сэтгүүлтэй байдаг. Тэндээ дүрэм, журам хоригдогчийн хүмүүжил, өөрийн үйл ажиллагааны талаар нийтэлдэг Идэвхитэн бичигч хоригдлуудтай юм билээ. Албама мужийн Баруун Мобайлын төв гяндангийн хэрэгтэн, сэжигтний мөрдөх дүрмийн хэсгээс дурьдвал

- ✓ Хоригдлууд өөрсдийн уулзахыг хүссэн 3-аас илүүгүй хүний нэрсийг бичүүлэх боломжоор хангагдсан байх
- ✓ Эргэлт уулзалтаар ирсэгсэд гяндангийн захиргаанд урьдчилан уулзалтын цагаа мэдүүлэн тохиролцсон байх ёстой.
- ✓ Уулзалтаар ирэгсэд уулзалт эхлэхээс 10 минутын өмнө ирсэн байвал зохино[5] гэжээ.

Мэдээж хэрэг бусад орны дүрэм журмыг дуурайх, хуулбарлахыг чухалд үзээгүй. Гэвч

3 Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам 2011 он ШШГЕГ. Харуул хамгаалалтын ажилтанд зориулсан гарын авлага, 88 дахь тал

4 НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1988 оны 12-р сарын 9 ний өдөр 43\173 –р тогтоолоор баталсан "Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц"-ын 13-р зарчим:

5 Баривчлах цагдан хорих байрны дотоод журам 2011 он ШШГЕГ харуул хамгаалалтын ажилтанд зориулсан гарын авлага 94 дахь тал

анхааран үзэх зүйл олон байна. Уулзалт хийлгэх ажилтан болон уулзалтад оролцогч нарт аль нэгэнд нь ямар нэг хүндрэлгүй зохицуулсан, уншихад ойлгомжтой, хэрэгжүүлэхэд хялбар, үг хэллэг нь энгийн тэгсэн байтлаа дүрэм журмыг зөрчих боломжгүй байна.

Хоригдож буй этгээдүүд хэзээ нэгэн цагт эрх чөлөөтэй болохыг мартах аргагүй зүйл бөгөөд эргэлт уулзалт бол хамгийн сайн харилцаа байдаг тул хоригдогчийн бусадтай уулзах, захидал харилцаатай байх хууль журмын дагуу утсаар ярих боломжтой байх зэрэг нь тэднийг нийгмийн амьдралд буцааж ороход нь хамгийн сайн үр дүнтэй арга юм. Гэвч хэмжээнээсээ хэтэрвэл амьдрал дээр сөрөг үр дагавар олныг дагуулдаг. Жишээ нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар жирийн дэглэмд ял эдлэж буй хоригдол бусадтай түр хугацаагаар уулзахад хязгаарлал тогтоогоогүйгээс ялангуяа эмэгтэй хоригдолууд хувийн хэрэгтээ бараг 20-30 түүнээс ч илүү хүн бичүүлсэн байх тохиолдол байдаг. Ар талдаа бололцоотой, хэргийн хувьд ихэвчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн зарим хоригдол шүүхээс оногдуулсан хорих ялын 20 гаруй хувийг гэр бүл найз нөхөдтэй уулзаж, эргэлтээр ирсэн зүйлийг идэж ууж, элдвийг ярилцан өнгөрөөж байгааг судалгаагаар тогтоосон зүйл. Энэ нь сайн талтай ч нөгөө талдаа хорих байгууллагын ажилтны ажлын чанартай цагийг барсан, хохирогчийн гомдол дагуулсан, ял завших сул талтай.

Хоол хүнсний хангамж үйлчилгээ: Хоригдсон этгээдэд өгөх цай хоол өдөрт 2 удаа халуун хоол 3 удаа цай 1 удаа гурилан бүтээгдэхүүн хоногийн хоолны илчлэг нь 3400 ккл-аас багагүй байга нэг удаа олгох цай 1.5 л хоол 0.5 литр гэжээ.[6] НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт этгээдүүдтэй харьцах асуудал 1955 онд баталсан хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм 20 дугаар дүрэм: Шоронгийн захиргаа ердийн тогтсон цагт хоригдогч бүрийг эрүүл мэнд, хүч тамирыг хэвийн хадгалах хангалттай тэжээллэг, сайн чанарыг сайтар бэлтгэсэн хоол ундаар хангах ёстой. Хоригдол бүр хэрэгцээтэй үедээ уух ундааны устай байх ёстой. Хоригдолын хоолны амт чанар, хэмжээ, нэр төрлөөрөө хоригдогчийн эрүүл мэндийг хангахуйц байх ёстой гэжээ.

Ариун цэвэр , цагаан хэрэглэл: Халуун усанд 14 хоногт нэг удаа орно. Усанд ороход шаардагдах ариун цэврийн хэрэгсэл саван бусад хэрэгслийг өөрсдөө хариуцна. Хувцас цагаан хэрэглэлийг 14 хоногт 1 удаа нэгдсэн угаалгахад авна[7] гэжээ.

Цагдан хорих төвүүдэд дунджаар зуу шахам эмэгтэйчүүд хоригддог. Тэд сэжигтний, яллагдагчийн, давж заалдах хугацаанаас хамаараад янз бүрийн хугацаанд хамгийн багадаа 14 тэгээд цаашдаа хэдэн сар жилээр ч хоригдох тохиолдол бий.

Гэвч эмэгтэй хүнийг цагдан хорих нөхцөл журам тухайлбал хоол хүнс, хувцас, ариун цэвэр эрүүл мэнд, эмнэлэгийн тусламж үйлчилгээ гэх мэт олон асуудал нь зайлшгүй онцлог зохицуулалттай байх ёстой. Харамсалтай нь манай хууль, дотоод журамд эмэгтэй хүний талаар, жирэмсэн эмэгтэйн талаар ганц хоёр зүйл дурьдсанаас өөр зүйл ороогүй байна. Харин жирэмсэн биш бусад эмэгтэй хоригдогчийн онцлогт нь тохирсон зохицуулалт үгүйлэгдэж байна.

НҮБ-1955 онд жишиг дүрэм: Эрүүл мэндээ хэвийн байлгах боломжтой иж бүрэн хэрэгсэл тавьж олгох нь зүйтэй. Хоригдогчийн хувцас нь гутаан доромжилсон шинжтэй байж болохгүй. Хувцас нь цэвэр бүрэн бүтэн байх ёстой. Ариун цэврийн шаардлагыг хангахуйцаар угаасан дотуур хувцас тавьж олгож байвал зохино. Эмэгтэйчүүд хувийн ариун цэвэр сахих үүднээс хэвийн болон сарын тэмдэг үзэгдэх үед шаардлагатай хэрэгслээр тогтмол хангагдах ёстой гэж үзсэн.

Эмнэлэгийн үйлчилгээ: Хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх халдваргүйжүүлэх, ажлыг эрүүл мэндийг хамгаалах холбогдох хууль тогтоомжуудад заасны дагуу явуулна. Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах үүрэгтэй.

6 Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 95 дахь тал

7 Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 93 дахь тал

✓ Хоригдсон этгээд хүндээр өвчилсөн, эсхүл нас барсан тохиолдолд хорих захиргаа нь түүний ойрын төрөл садан болон хорих шийдвэр гаргасан албан тушаалтан прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

✓ Хоригдсон этгээд нас барсан тохиолдолд цогцост шүүх эмнэлэгийн задлан хийсний дараа ар гэр, төрөл садны хүмүүст шилжүүлнэ. Цогцосыг ирж авах тухайн хорих байрны зардлаар оршуулна[8] гэсэн байна.

Олон улсын конвенцоор цагдан хорих асуудал нь хүмүүст өөрийн амьдралаар амьдрах боломж олгодоггүй учраас хоригдогчдын бие махбодийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дамжиж байх нь чухал. Эрүүл мэндийн үйлчилгээ нь эрх чөлөөт амьдралдаа авдаг үйлчилгээнээс ялгагдах ёсгүй. Хорих цагдан хорих газрууд эмэгтэйчүүд онцгой хэрэгцээнд муу зохицсон байдаг. Цагдан хорих байрны эмнэлэгийн ажилтнууд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарал хандуулах, эмэгтэйчүүдийн эмнэлэгийн үйлчилгээг баталгаатай авдаг байх ёстой[9] гэжээ. Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих тухай түүнд нийцүүлэн гаргасан дотоод журам хоригдогчийн хорих нөхцөл журам өргөн агуулгаар хуульчилжээ. Мэдээж хэрэг хүн амьдрах нөхцөл боломжийг хангах нь цөөн хэдэн зүйлээр хязгаарлах асуудал биш юм. Гэвч хүний заяамал эрхийг хангахаас эхлээд амьдралд тохиолдох бүхий л зүйлийг хуульчлахыг чухалд үзэж байгаа нь нэг талаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, нөгөө талаар хэдийгээр хоригдож байгаа боловч хүний амьдрал өргөн учир тэр болгоныг хууль журмаар заагаад байх нь ач холбогдолгүй гэж үзээд хорих, цагдан хорих газарт

Эрүү шүүлт ба хүнлэг бусаар харьцах тухай асуудал: Эрүүдэн шүүх, хэрцгийгээр хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг ямар ч нөхцөл байдал зөвтгөж чадахгүй. Эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гуравдагч этгээдээс мэдээ сэлт мэдүүлэг авах тухайн хүн буюу гуравдагч этгээдийн үйлдсэн сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу 3 дахь этгээдийн бие мах бодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ. Мөн манай улс 2000 оны эцсээр « Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгийн хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци-д нэгдэн орсон. Ардчилсан нийгэмд нийгмийн суурь үнэт зүйлийг хуулиар сахин хамгаалдаг. Тэдгээрийн хамгийн чухал нь хүмүүний төрлөхийн заяамал нэр төрийг тэдний хувийн болон нийгмийн байдлаас үл хамран хүндтэгэн үзэх явдал юм. Хүмүүнийг хэр зэрэг эрхэмлэн үзэж байгаа нь аливаа нийгэмд эрүүгийн хуулийг зөрчсөн эсвэл зөрчсөн гэж буруутгагдаж байгаа хүмүүст хэрхэн хандаж байгаагаар илэрнэ. Эдгээр хүмүүс нь өөрсдөө бусдын заяамал нэр төр эрхийг хүндэтгээгүй хүмүүс мөн. Гэвч хорих газрын ажилтнууд нь тэдний хийсэн хэргийг эс харгалзан нийгмийн нэрийн өмнөөс хүндэтгэн үзэх онцлог үүрэг хүлээдэг. Хорих үйлчилгээ нь эрүүгийн шүүхийн тогтолцооноос иргэний заяамал эрхэд хамгийн ихээр нөлдөөлдөг бүрдэл хэсэг юм . Тиймээс хорих газрын харгалзагч бороохой гозогнуулан хоригдлуудын дундуур явах зэрэг бүхий л төрлийн дээрэнгүй харьцах харьцааг хориглодог.

Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих тухай Монгол улсын хууль түүнд нийцүүлэн гаргасан цагдан хорих байрны дотоод журам нь хоригдогчийн эрх зүйн байдал, ахуй нөхцөл, эрүүл мэндийг хамгаалах асуудлыг өргөн агуулгаар хуульчилжээ.

Мэдээж хэрэг хүн амьдрах нөхцөл боломжийг хангах нь цөөн хэдэн зүйлээр хязгаарлах асуудал биш юм. Гэвч хүний заяамал эрхийг хангахаас эхлээд амьдралд тохиолдох бүхий л зүйлийг хуульчлахыг чухалд үзэж байгаа нь нэг талаар хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөгөө талаар хэдийгээр хоригдож байгаа боловч хүний амьдрал баян учир тэр болгоныг хууль журмаар заагаад байх нь ач холбогдол багатай билээ. Хамгийн гол нь Монгол улсад хорих ял эдлүүлэх болон сэжигтэн яллагдагчдын баривчлах цагдан хорих хууль, журмаас гадна хорих, цагдан хорих газарт хүн хорих үйл ажиллагаатай холбоотой зарим нөхцөлүүдийг тухайлбал

8 Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх хууль, ШШГБ-н харуул хамгаалалтын ажилтан нарт зориулсан хууль, журмын эмхэтгэл 2011 он, 69 дэх тал

9 Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг , ардчилсан удирдамж 2006 он, 126-130 дахь тал

орон байр, гэрэл, дулаан, хоол хүнс, эмнэлэгийн үйлчилгээ, эргэлт уулзалт гэх мэт олон асуудлыг шийдвэрлэхэд өөрийн онцлогтоо тохирсон үндэсний стандарт үгүйлэгдэж байна. Үүнийг Олон улсын баримт бичигт хүний эрхийн стандарт гэж тэмдэглэсэн байдаг. Үндэсний стандарттай болсон нөхцөлд бүх зүйлийг хуулиар зохицуулах шаардлага гарахгүй давуу талтай. Иймд манай өнөөгийн мөрдөж байгаа хууль тогтоомжоо эргэн харж цаашид боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай монгол улсын хуулийн бүлэг зүйлийн 70 шахам хувь нь цагдан хорих шийдвэрийг биелүүлэх байгууллага, ажилтны эрх үүргийг хуульчилжээ. Хүнлэг ардчилсан нийгмийг цогцлоон байгуулж буй өнөө үед хүнээ нэн тэргүүнд тавих зарчим үйлчлэх ёстой. Иймд хоригдож байгаа хүний эрхийг хорих цагдан хорих газар хэрхэн хангахыг дараа нь түүнийг хэрэгжүүлэх байгууллага, ажилтнууд ямар журмаар ажиллах тухай хуульчилж өгөх нь тохиромжтой. Практик дээр хууль хэрэгжүүлэх механизмыг тогтоож өгөхийн оронд журмаар хуулийн нэлээд хэсгийг хуулаад цаас ээлүүлж хүн уншихад хэт өргөн болгодог байдал ажиглагдаж байна. Хорин нэгдүгээр зуун бол цахим нийгэм учраас хүмүүс цаас унших дургүй цаг алдана гэж үзэх болсон. Үг хэллэг нь орооцолдсон урт байдгаас ойлгомжгүй уншихаас төвөгшөөдөг сул талтай. Зөвхөн дотоодын хууль журмандаа захирагдах байдлаар мэргэжлийн түвшингөө тогтоох бус даяарчилсан өнөө үед олон улсын хорих байгууллага дээр юу болж байна гэх мэтчилэн хүний эрхийн мэдрэмжтэй байх нь мэргэжлийн ур чадварыг тодорхойлох нэг үзүүлэлт болно.

# ЦАХИМ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

*П.Түвшинтөгс*

*Шихихутуг ХЗДС-ийн Салбар эрх зүйн тэнхмийн багш*

**ОРШИЛ**

1. Цахим аргаар гэрээ байгуулах арга, түүний онцлог
2. Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалт, үр дагавар
3. Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь

**Дүгнэлт**

**Номзүй**

## ОРШИЛ

Дэлхий ертөнц даяарчлагдан хувьсахын хирээр хууль тогтоомж мөн адил шинэчлэгдэн өөрчлөгдөж буй өнөө үед иргэний эрх зүйн тэр дундаа гэрээний эрх зүйд гэрээ байгуулах арга хэлбэр нь цахим аргаар явагдах нь их болсон билээ. Цахим худалдаанд техникийн болоод эдийн засгийн, хууль зүйн маш олон үр дагаварууд холбогдох бөгөөд үүнд, интернэт дэх хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах, гэрээний объектын доголдол, интернэтээр төлбөр төлөлт зэрэгтэй холбоотой асуудлууд юм. Цахим худалдаа нь хүний цаг зав, мөнгө зэргийг хэмнэх боловч нөгөө талаараа эрх зүйн хувьд тодорхой хамгаалалт хийж өгөөгүйгээс хэрэглэгчийн эрх ашгийг хамгийн их хохироож байгаа юм. Цахим хэлбэрээр худалдах, худалдан авах гэрээний хувьд гэрээ байгуулах саналыг нөгөө тал хэзээ хүлээн авсанд тооцох, гэрээнээс хэзээ татгалзах болон цуцлах эрхтэй вэ зэрэг эрх зүйн хувьд шийдвэрлэх шаардлагатай зүйлүүд байгаа юм.

### 1. Цахим аргаар гэрээ байгуулах арга, түүний онцлог

Гэрээ гэж /лат/ offertus; англ. Offer, ор. Оферт/ - иргэний эрх зүйд нэг этгээд нь өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх, үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлсэн илэрхийлэл[1] хэмээн тайлбарласан бол иргэн, бизнесийн эрх зүйн судлаач эрдэмтэдийн ном бүтээлд «Гэрээ гэж иргэний эрх, үүргийг бий болгож, өөрчилж, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр ба түүнээс дээш тооны этгээдийн хооронд хийсэн тохиролцоо юм»[2], «Гэрээ бол иргэний эрх зүйн нэгэн институт, хууль зүйн факт байдаг. Гэрээгүйгээр иргэний эрх зүйг ойгохын аргагүй юм. Учир нь гэрээ бол иргэний эрх зүйн харилцаанд оролцогч иргэд, хуулийн этгээдийн өдөр тутамд хоорондоо зайлшгүй харилцах хэрэгсэл, үүргийн эрхийн харилцааг үүсгэх гол үндэслэл байдагт оршино[3]» хэмээн үзсэн байна.

Харин Монгол улсын иргэний хуульд «Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй»[4] гэж заасан нь гэрээг гэрээнд оролцогч талууд сайн дураараа, чөлөөтэй тэгш эрхийн үндсэн дээр байгуулна гэдэг агуулга харагдаж байгаа юм. Мөн иргэний хуульд нэг этгээд өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсөн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу

1 С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг /Dictionary of law/. УБ, 2007 он., 152 дахь тал

2 Д.Аюуш, Г.Амаржаргалан, Ц.Давхарбаяр. Гэрээний эрх зүй-1 /гарын авлага/. УБ 2007 он., 31 дэх тал

3 Т.Мөнхжаргал. Монгол Улсын иргэний эрх зүй. УБ, 200 он., 21 дэх тал

4 Монгол улсын иргэний хууль УБ., 2002 он, 189-р зүйл

хэд хэдэн тодорхой этгээдэд хандан хүсэл зоригоо бодитойгоор, хангалттай тодорхой илэрхийлснийг гэрээ байгуулах санал гэнэ»[5] хэмээн тодорхойлсноос харвал гэрээг байгуулагч хоёр тал нэг нь нөгөөдөө гэрээ байгуулах тухай саналыг илгээж нөгөө тал нь түүнийг хүлээн авснаар гэрээг байгуулагдсанд тооцох боломжтой байгаа юм. Энэ бүхнээс дүгнэн үзвэл, гэрээ гэж «иргэний эрх үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн хүсэл зоригийн илэрхийллийг нөгөө тал хүлээн авсан тохиролцоог гэрээ гэнэ» гэж тодорхойлж болох юм.

Гэрээ байгуулах аргыг иргэний үеийн үеийн хуулиудад тодорхой зааж өгөөгүй болович хуулиудын зүйл заалтанд дүн шинжилгээ хийвэл 1963 оны иргэний хуулийн 110-р зүйлд Гэрээ хийх[6] талаар тусгаж өгсөн байгаа юм. 1994 оны Иргэний хуулиас харвал, 161-р зүйлд Гэрээ байгуулах[7], 162-р зүйлд Үнэ хаялцуулах ажиллагаа[8], 164-р зүйлд гэрээг заавал байгуулах[9] хэмээн зааж өгсөн нь гэрээг байгуулах арга хэлбэрийг тухайн үед

- Нийтлэг журмаар
- Үнэ хаялцуулах журмаар
- Гэрээг заавал байгуулах журмаар гэсэн эдгээр аргуудаар байгуулж болохыг илтгэн харуулж байна.

2002 оны Иргэний хуулиар 195.1-р зүйл, 196-р зүйл, 197-р зүйлүүдэд гэрээг байгуулах аргуудыг зааж өгсөн байгаа юм. Гэрээ байгуулах арга гэж гэрээ байгуулахдаа гэрээний зүйл оршин байгаа газар, баримтлах хууль, оролцогч талууд зэргээс хамааран гэрээг байгуулах нөхцөл байдал[10] хэмээн үзэж болно. Гэрээ байгуулах аргыг:

1. Нийтлэг журмаар
2. Үнэ хаялцуулах журмаар
3. Гэрээг заавал байгуулах журмаар
4. Интернэтээр гэж ангилж үзэж болно.

Эдгээрээс Интернэтээр гэрээ байгуулах арга нь сүүлийн жилүүдэд өргөн хүрээнд дэлгэрч байгаа бөгөөд манай улс 2011 онд цахим гарын үсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан иргэний хуулийн 42.1'[11] -д цахим хэлбэрээр гэрээ байгуулах тухай зааж өгсөн юм. Мөн цахим хэлбэрээр гэрээг байгуулахад иргэний хуулийн 43.2.4-д заасны дагуу цахим хэлбэрээр хэлцэл хийх бол талууд хүсэл зоригоо илэрхийлсэн цахим баримт бичиг үйлдэж, Цахим гарын үсгийн тухай хуульд заасан тоон гарын үсэг зурсан тохиолдолд хэлцлийг хийсэн гэж үзэх үндэслэлтэй юм.

Гэрээ нь дараах үе шатаар байгуулагдах бөгөөд үүнд:

1. Хэлэлцээ
2. Тохиролцоо
3. Гэрээний санал /оферт/
4. Саналыг хүлээн зөвшөөрсөн хариу / акцепт/
5. Гэрээг хуульд заасан хэлбэрээр байгуулах гэсэн үе шаттайгаар байгуулагдах бөгөөд интернэтээр гэрээ байгуулахад гэрээг хуульд заасан хэлбэрээр хийнэ гэдэг нь гэрээг бичгээр байгуулах бөгөөд цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу тоон гарын үсэг зурснаар гэрээг байгуулагдсанд тооцож байгаа юм.

5 Монгол улсын иргэний хууль УБ, 2002 он, 195-р зүйл

6 Монгол Улсын иргэний хууль, 1963 он, 110-р зүйлд: гэрээний гол чухал зүйлийн талаар зохиогчид харилцан тохиролцож, хуульд заасан буюу хэлэлцэн тогтсон хэлбэрээр гэрээ хийсэн байвал уг гэрээг хийсэн гэж үзнэ. Хууль ёсоор буюу гэрээний байдлаас уг гэрээнд зайлшгүй заасан, харилцан тохиролцсон байвал зохих зүйлүүд, мөн нэг этгээдийн хүсэл шаардлагын дагуу харин зөвшөөрөлцвөл зохих зүйлүүдийг гэрээний гол чухал зүйл гэнэ.

7 Монгол улсын иргэний хууль 1994 он. 161-р зүйл Гэрээний гол нөхцлийн талаар талууд харилцан тохиролцож хуульд заасан буюу хэлэлцэн тохирсон хэлбэрээр гэрээ хийсэн бол уг гэрээг байгуулсан гэж үзнэ.

8 Монгол улсын иргэний хууль 1994 он. 162-р зүйлд: үнэ хаялцуулах замаар гэрээг байгуулж болно. Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээг үнэ хаялцаж ялсан этгээдтэй байгуулна.

9 Монгол улсын иргэний хууль 1994 он. 164-р зүйл. Талуудын аль нэг нь гэрээг заавал байгуулахаар хуульд заасан бол тэр тал нь нөгөө талдаа гэрээний төслийг зөвшөөрсөн буюу татгалзсан хариуг, эсхүл гэрээний шинэ төсөл /гэрээг өөр нөхцлөөр байгуулах тухай хариу/-ийг хууль буюу гэрээнд өөр хугацаа тогтоогоогүй бол гэрээний төсөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор илгээх үүрэгтэй.

10 Д.Аюуш, Г.Амаржаргалан, Ц.Давхарбаяр. Гэрээний эрх зүй-1 / гарын авлага/. УБ 2007 он., 38 дахь талд

11 42'.1.Хуульд заасны дагуу бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих хэлцлээс бусад, хуульд бичгээр хийхээр заасан хэлцлийг цахим хэлбэрээр хийж болно.

42'.2.Цахим хэлбэрээр хийх хэлцэл нь хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурж илгээснийг гэрээний нөгөө тал нь хүлээн зөвшөөрч тоон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**2. Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалт, үр дагавар**

Олон улсын эрх зүйд гэрээнээс үүдэлтэй эсэхээс үл хамааран худалдаа арилжааны мөн чанартай харилцаа гэдэг нь аливаа бараа үйлчилгээг хангах, солилцох хэлцэл, агентын буюу худалдааны зуучлал, факторинг, лизинг буюу санхүүгийн түрээс, банкны холбогдолтой хэлцлүүд барилгын ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээний хэлцэл, инженерийн төрлийн хэлцэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хэлцэл, хөрөнгө оруулалтын хэлцэл, санхүүгийн болон даатгалын хэлцэл, концесс болон олборлолтын хэлцэл, хамтарсан үйлдвэр болон үйлдвэрлэл, эсвэл бизнесийн хамтын ажиллагааны хэлцэл, агаараар, далайгаар, төмөр зам болон газрын зорчигч болон бараа тээвэрлэлт зэрэг хэлцлүүдийг агуулах[12] боловч зөвхөн эдгээр хэлцлүүдээр хязгаарлаж болохгүй юм.

Цахим худалдах, худалдан авах гэрээ гэдэг нь ерөнхийдөө текст, дуу, дүрс зэрэг цахим өгөгдлийг боловсруулж дамжуулах ажиллагаан дээр үндэслэсэн байгууллага хэрэглэгч нарын хоорондын бизнесийн арилжааны бүх хэлбэрийг хэлнэ[13] хэмээн тодорхойлсон байхад Европын мэдээллийн технологийн шинжлэх ухааны хүрээлэнгээс «Цахим худалдаа нь цахилгаан холбоо харилцааны сүлжээг ашиглан өртөг шилжүүлэх бизнесийн үйл ажиллагаа явуулах талбар юм» хэмээн тодорхойлжээ. Энэ мэт тодорхойлолтуудаас харахад цахим худалдааны хэлбэрүүд нь цахим хэлбэрээр байгууллагууд бизнесийн болон арилжааны асуудлаа шийдвэрлэхийг хэлэх юм. Харин судлаачийн зүгээс цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтын асуудлыг дэлгэрэнгүй авч үзэх тул цахим хэлбэрийн бизнесийн үйл ажиллагааг цаашид дэлгэрүүлэн дурдахгүй болно.

Цахим хэлбэрээр худалдах худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын хувьд авч үзвэл, өмнөх хэсэгт дурдсанчлан цахим гэрээ, хэлцлийг байгуулахын тулд цахим гарын үсгийн тухай хуулинд зааснаар тоон гарын үсэг зурснаар байгуулагдана хэмээн заасан байна. Харин цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1 зааснаар «цахим гарын үсэг» гэж цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэг, тоо, тэмдэг, дүрсийг агуулсан цахим өгөгдлийг; 4.1.2.«тоон гарын үсэг» гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрлийг хэлнэ хэмээн заажээ. Тус хуулийн 6.2.Тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно[14] хэмээн заасан нь интернэтээр байгуулагдаж буй худалдах, худалдан авах гэрээг бүрэн гүйцэт тодорхойлон хуульчилж өгөөгүй байгаа юм. Бусад улс орнуудад цахим худалдааг зохицуулсан хэм хэмжээг авч үзвэл,

1. Бараа худалдах, худалдан авах тухай олон улсын Венийн конвенци

2. Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн конвенци

3. Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харъяаллын тухай Гаагийн конвенци

4. Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенци

5. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенциудийг нэрлэж болох юм.

Дээрх конвенциудад олон улсын худалдаа болон олон улсын худалдах, худалдан авах гэрээ, цахим хэлбэрээр байгуулагдах гэрээнүүдийг тусгаж өгсөн юм.

Эдгээрээс гадна цахим худалдах, худалдан авах гэрээнд олон улсын баримталж байгаа нэг том эрх зүйн зохицуулалт бол Цахим худалдааны олон улсын загвар хууль юм. 1996 онд НҮБ-ын Олон улсын

12 Uncitral Mode on Electronic Commerce. Цахим худалдааны тухай загвар хуулийн тодорхойлолтоос авав.

13 Монгол улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага. 1997 он

14 Цахим гарын үсгийн тухай хууль. УБ. 2011 он

худалдааны эрх зүйг хариуцсан комиссоос «Цахим худалдааны загвар хууль»-ийг батлан гаргасан юм.[15] загвар хуулийн гол зорилго нь цахим худалдааг зохицуулах явдлыг хялбар болгоход чиглэгдсэн, одоогийн үйлчилж байга хууль зүйн шаардлагуудад нийцүүлэх, эрх зүйн суурь үнэлэмж, үнэ цэнийг гаргаж тави, хууль зүйн хувьд тодорхой байдлыг бий болгох явдал юм. цахим худалдааны загвар хуулийн гол үзэл баримтлал нь

- Эх баримт бичгийг шаардах,
- Эх гарын үсгийг шардах
- Эх бичиг баримт буюу эх хувийг шаардах зэрэгт оршино.

**3. Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь**

Үндэсний болон олон улсын эрх зүй олон улсын худалдаанд цахим арилжааг гүйцэтгэхэд эх баримт бичгийг шаардах, эсхүл эх гарын үсгийг шаардах явадл нь цахим хэлбэрээр байгуулагдах гэрээг хөгжүүлэхэд гол бэрхшээлд тооцогдож байна.[16] Интернэтээр худалдан авч хүргэгддэг бараа бүтээгдэхүүний хувьд ДХБ-ийн барааны худалдаанд баримталж буй дүрэм журам үйлчлэх боловч энэ төрлийн худалдаанд тодорхойгүй байгаа зүйлүүд нилээд их байгаа юм. Жишээлэн авч үзвэл,

1. Цахим хэлбэрээр хийгдэж буй гэрээнд гэрээ байгуулагдах саналыг нөгөө тал хэзээ хүлээн авсанд тооцох вэ, жишээ нь иргэн Г интернэт сайтаас бараа худалдах тухай зар байгааг хараад авах тухай хариу өгснөөр гэрээ нийлэг журмаар байгуулагдсан гэж үзэх үү, эсвэл бараа бүтээгдэхүүнийг худалдан авч үнийг төлснөөр гэрээ байгуулагдсан гэж үзэх үү гэдэг асуудал байна.

2. Мөн гэрээнээс татгалзах болон цуцлах тухай асуудал эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа юм. жишээ нь, улс дамнан хийгдэж буй гэрээ хэлэлцээрийн хувьд тухайн барааг интернэтээр захиалж авчруулахад өөрт нь томдсон, багадсан, доголдолтой зэрэг байгаа тохиолдолд тухайн бараа бүтээгдэхүүнийг буцаах, гэрээнээс татгалзах, цуцлах асуудал гарахад хэн буруутай вэ гэдэг асуудал өнөөдрийн манай иргэний хуулиар шийдвэрлэгдэхэд хангалтгүй байгаа юм. Мөн гэрээ байгуулсан этгээд хугацаандаа бараа бүтээгдэхүүнээ шилжүүлээгүй бол яах вэ гэдэг асуудал тун бүрхэг байгаа юм.

3. Мөн гэрээний объекттой холбоотой доголдлыг хэрхэн зохицуулах, гэрээнээс гарсан маргааныг хэрхэн хянан шийдвэрлэх вэ гэдэг вэ гэдэг асуудал

Хэдийгээр гэрээний объекттой холбоотой болон гэрээний төлбөр, гэрээнээс татгалзах болон цуцлах, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг одоогийн манай хуулиар зоицуулж байгаа боловч эдгээр заалт нь зөвхөн гэрээ байгуулагдсан тохиолдолд л хэрэгжих юм. Гэтэл манай иргэний хуульд тодорхойлсноор цахим гарын үсгийн тухай хуульд зааснаар тоон гарын үсгийг зурсан тохиолдолд гэрээг байгуулагдсан гэж үзэх нь учир дутагдалтай байгаа юм. Жишээ нь, Америкийн нэгдсэн улс болон Канад улсуудад интернэтээр гэрээ байгуулахад зөвхөн Мэдээлэл, харилцаа холбооны салбараас хүлээн зөвшөөрч лицензлэгдсэн хэдэн худалдааны сайтууд л зөвхөн барааг интернэтээр худалдах, худалддан авах үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд эдгээр сайтууд нь тухайн мэдээлэл, харилцаа холбооны салбарт хянагдаж байдаг байна. Тухайн интернэтээр байгуулсан худалдах, худалдан авах гэрээнд аливаа эрх зүйн маргаан гарахад мэдээлэл, харилцаа холбооны газраас шууд зөрчлийг арилгах эрх хэмжээ байга нь цахим худалдах, худалдан авах гэрээг илүү боловсронгуй зохицуулж өгсөн хэрэг юм.

**ДҮГНЭЛТ:**

Манай улс нь ардчилсан улс болоод нилээд хэдэн жилийн нүүрийг үзэж байгаа бөгөөд даяарчлагдан хувьсахын хирээр эрх зүйн хувьд шинэчлэл хийгдэх шаардлага зүй ёсоор урган гарах юм. Хүмүүсийн өдөр тутмын амьдралд гэрээ байгуулах шаардлага урган гарах бөгөөд гэрээнээс үүдэлтэй

15 Г.Халиунаа. Цахим худалдааны загвар хууль батлах болсон шалтгаан нөхцөл. Хууль дээдлэх ёс, 2012 №02 /37/, хуудас 91-95

16 Цахим худалдаа: Хууль эрх зүйн асуудлууд. UNCTUD/SDTE/BFB/1 дугаартай1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар параграф дахь нийтлэлийг үзнэ үү.

маргаан шүүхийн практикийн дийлэнхи хэсгийг эзэлж байгаа юм. Гэрээг байгуулах, гэрээ нь хүчин төгөлдөр байх зэрэг асуудлууд нь тухайн гэрээг хэзээ байгуулагдсанд тооцох вэ, тухайн гэрээнээс үүдэлтэй аливаа харилцааг хэрхэн хянан шийдвэрлэх вэ гэсэн хэд хэдэн асуултуудыг өөртөө агуулна. Гэрээг манай улсын хууль тогтоомжийн хөгжлийн үе шатуудад хэд хэдэн хэлбэрээр байгуулж байсан бөгөөд харин сүүлийн жилүүдэд интернэтээр гэрээ байгуулах арга дэлхийн өнцөг булан бүрт өргөн дэлгэрээд байгаа юм. Интернэтээр гэрээ байгуулах арга нь манай улсад хэдийгээр хууль зүйн хувьд хуульчлаагдан өгсөн боловч төгс хуульчлаагүй гэж хэлж болох юм. Түүнчлэн интернэтээр байгуулах худалдах, худалдан авах гэрээнд тохиолдож буй хэд хэлэн маргаантай зүйлүүд байгаа билээ. Тиймээс цахим хэлбэрээр хийгдэж буй худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтыг сажйруулах үүднээс дараах хэдэн саналуудыг дэвшүүлж байна

1. Цахим хэлбэрээр байгуулагдах гэрээ хэлцлийн тухай бүлэг хуульчилж өгөх. Судлаачийн зүгээс энэ бүлэгт цахим хэлбэрээр ямар ямар гэрээ, хэлцлүүдийг байгуулж болох, тухайн гэрээг хэзээ байгуулагдсан гэж үзэх, цахим хэлбэрээр хийгдэх гэрээнүүдэд тавигдах шаардлага, гэрээнээс татгалзах, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох, гэрээг цуцлах зэргийг нэгдмэл байдлаар хуульчлах шаардлагатай байгаа зүйлүүдийг хуульчилж өгөх

2. Цахим хэлбэрээр хийгдэх худалдах, худалдан авах гэрээнд хяналтыг бий болгох. Судлаачийн зүгээс тухайн хяналтыг хийхийн тулд ХБНГУ, АНУ зэргийн жишигийг баримтлан цахим хэлбэрийн гэрээнд хяналт тавих байгууллагыг бий болгохын зэрэгцээ тухайн байгууллагар албан ёсны эрх авсан хэд хэдэн сайтууд, үйлчилгээний байгууллагууд л цахим худалдах, худалдан авах гэрээг хийх зэрэг

3. Цахим худалдах, худалдан авах гэрээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулах үүднээс цахим худалдаан дахь нууцын тухай хууль батлах. Судлаачийн зүгээс цахим хэлбэрээр хийгдэх гэрээнүүдэд нууцын болоод хамгаалалтын ямар ч зүйл байхгүй байгаа бөгөөд үүнийг хянан шийдвэрлэхийн тулд Франц, Австрали зэрэг улсуудтай адил цахим хэлбэрээр хийгдэх гэрээний нууцын хамгаалалтын асуудлыг шийдвэрлэсэн журам, хуультай болох

Аливаа төрлийн гэрээ нь хоёр талын хүсэл зоригийн илэрхийллээр хийгддэг бөгөөд гэрээний талууд гэрээний нөхцлүүдийг харилцан тохиролцон тогтоох боловч цахим хэлбэрээр хийгдэх гэрээнүүдэд хоёр тал нь тохиролцлийн үндсэн дээр хийгдэх тул гэрээний аливаа нөхцөл, журмууд нь хаалттай хэвээр үлддэг юм. Тиймээс энэ хэлбэрээр байгуулагдах гэрээний эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай.



# ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ БА ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ

*«Шихихутуг» хууль зүйн дээд сургуулийн Төр,эрх зүйн онол,түүхийн тэнхмийн ахлах багш,хууль зүйн ухааны магистр,докторант*

***Б.Минжуурдорж***

**1.Эрх зүйн философийн судлах зүйл.**

Эрх зүйн философийн судлах зүйлийг Оросын судлаач В.С.Нерсесянц ерөнхий байдлаар тодорхойлсон байдаг.Тэрээр «эрх зүйн философи эрх зүйн агуулга,мөн чанар;үндэс,дэлхийд эзлэх байр суурь;эрх зүйн үнэт чанар,төр,нийгэм,хүний амьдралд гүйцэтгэх үүрэг,ач холбогдлыг судалдаг» гэж үзсэн байна[1].Энэ утгаараа «эрх зүйн философийн судлах зүйл — эрх зүй,хуулийн ялгаа,төсөөт байдал,давхцал юм» гэж ойлгож болно.

Эрх зүйн философи — ерөнхий онолын,хууль зүйн бүх шинжлэх ухааны үндэс болох биеэ даасан салбар шинжлэх ухаан учраас эрх зүйг танин мэдэх дээд зэргийн хийсвэрлэл бүхий үйл ажиллагааны хэлбэр.

Гносеологи болон онтологи гэсэн хоёр хандлагын аль алинаар нь тодорхойлсон ч эрх зүйг судлах арга зүй — эрх зүйн философийн амин чухал хэсэг.Эрх зүйг судлах арга зүй — төр,эрх зүйн үзэгдлийг судлах логик арга,тусгай арга хэрэгсэл, онолын зарчим,тэдгээрийн нэгдэл юм[2].Зарим судлаачид эрх зүйг судлах арга зүйн хүрээнд «эрх зүйн хөгжлийн объектив зүй тогтлын талаарх онолын дүгнэлт»-ийг хамааруулдаг[3].

Орчин үеийн философи-эрх зүйн судалгаанд/арга зүйн талаас/ шинжлэх ухааны бусад аргатай адил харьцуулсан эрх зүйн аргад тийм ч их анхаарал хандуулахгүй байгаа тал бий.Энэ нь тухайн асуудлаарх харьцуулсан эрх зүйн бүтээл олон байдагтай холбоотой[4]. XIX зууны эхний хагаст «харьцуулсан эрх зүйн хандлага хамгийн чухал» гэсэн үзэл баримтлал дэвшүүлж байсан ч амжилт олоогүй байна.Энэ үед нийгмийн хөгжил,өөрчлөлтийн талаарх үзэл санааг дэвшүүлсэн, харьцуулсан эрх зүй судлалын түүхэн философийн хоёр чиглэл/Кантын үзэл /төлөөлөгч нь А.Фейербах;Гегелийн үзэл /төлөөлөгч нь Э.Ганс/ гарч ирсэн.

А.Фейербахын үзэл санааны философи үндэс: » хөгжил—эрх зүйг нэгтгэдэг,энэ байдал ард түмэн бүрийн эрх зүй дэх өвөрмөц ялгааг үгүйсгэхгүй» гэж үзээд «философи,түүх ба харьцуулалт адил тэгш хүлээн зөвшөөрөгдөх ёстой,тэдгээрийг үндэслэн хууль зүйн шинжлэх ухаан хөгжинө» гэсэн санааг дэвшүүлж,өөрийн бүтээлд«эрх зүйн цэвэр шинжлэх ухаан,нийтийн хууль цаазыг бий болгосноор бүх газар нутгийн,бүх цаг үеийн ард түмний эрх зүйн зан заншил,эрх зүйг харьцуулах[5]» тухай дурьджээ.

Э.Гансын үзэл баримтлалын хувьд тэрээр:нэгд,харьцуулсан эрх зүйг философи—түүхэн талаас томъёолохыг эрмэлзсэн. хоёрт,харьцуулсан эрх зүйн талаарх нийтлэг үзэл хандлагыг бий болгоход чиглэгдсэн

1 Нерсесянц В.С.Философия права. М.,1997.С.7
2 Сырых.В.М.Метод правовой науки.основные элементы,структура.М.,1980.С.6
3 Керимов.Д.А.Вступительная статья// Лукич Р.Методология права.М.,1981.С.12

4 Марченко.М.Н.Сравнительное правоведение.М.,2001; Марченко.М.Н.Курс сравнительного правоведения.М.,2002;Саидо в.А.Х. Сравнительное правоведение.М.,2002;Тихомиров.Ю.А. Курс сравнительного правоведения.М.,1996.
5 Feurbach A.Idee und Notwendig Keit einer Universal-jurisprudenz. Biographischer Nachlass.1953.Bd.II. S.378

олон бүтээлийг гаргасан.Тэрээр гегелийн философид тулгуурлан «үндэстэн бүрийн эрх зүйн түүх - эрх зүйн нийтлэг хөгжлийн тодорхой үе» гэсэн санааг дэвшүүлж,»эрх зүйн түүх—аргын хувьд харьцуулсан,зорилгоороо нийтлэг шинжлэх ухаан» гэж тодорхойлжээ.

**2. Харьцуулсан эрх зүй судлалын судлах зүйл.**

Харьцуулсан эрх зүй судлалын шинжлэх ухааны уг үндэс харьцуулсан эрх зүйн аргатай салшгүй холбоотой.Учир нь харьцуулсан эрх зүйн арга харьцуулсан эрх зүй судлалыг шинжлэх ухаан болон үүсэхээс өмнө хөгжлийн дараах хоёр үеийг дамжин харьцуулсан эрх зүй судлалыг «шинжлэх ухаан» гэж хүлээн зөвшөөрөхөд томоохон түлхэц өгсөн байдаг:эхний үе буюу харьцуулсан эрх зүйн арга үүссэн үе;хоёр дах үе буюу харьцуулсан эрх зүйн арга цаашид улам боловсронгуй болон хөгжиж,уг аргын тусламжтайгаар төр,эрх зүйн аливаа үзэгдэлд харьцуулалт хийж,түүний үр дүнд харьцуулсан эрх зүйн судалгааны цар хүрээ өргөжсөн үе[6].

Харьцуулсан эрх зүй судлаачдын онолын маргаантай асуудлын нэг бол харьцуулсан эрх зүй судлал шинжлэх ухаан уу эсвэл арга уу гэдэг асуудал.Барууны харьцуулсан эрх зүй судлалын бүтээлд харьцуулсан эрх зүй судлалын агуулгыг дараах гурван үзэл баримтлалын үүднээс тодорхойлж байна:

- харьцуулсан эрх зүй судлал-эрх зүйн тогтолцооны хөгжлийн зүй тогтлыг танин мэдэхэд чиглэгдсэн шинжлэх ухааны арга,техник,аргачлалын нийлбэр/**amalgam of different methodes,techniques and methodologies**/;
- харьцуулсан эрх зүй судлал өөрийн судлах зүйл,судалгааны аргатай биеэ даасан цэвэр шинжлэх ухаан/**a separate body of knowledge,an autonomous legal science**/;
- харьцуулсан эрх зүй судлал бол төр,эрх зүйн онолын шинжлэх ухааны салбар шинжлэх ухаан/энэхүү онолын чиг хандлагыг баримтлагчид «харьцуулсан эрх зүйн аргын онол —эрх зүйн ерөнхий онолын нэг бүрэлдхүүн хэсэг» гэж үздэг/

Оксфордын Их сургуулийн профессор,нэрт харьцуулсан эрх зүй судлаач Otto Kahn-Freund «харьцуулсан эрх зүй судлал бол эрх зүйг судлах олон төрлийн арга[7]» гэж тодорхойлсон бол Кембриджийн Их сургуулийн профессор H.C.Gutteridge «харьцуулсан эрх зүй зөвхөн арга төдий юм;харьцуулсан эрх зүйд өөрийн гэсэн тусдаа судлах зүйл байхгүй;харьцуулсан эрх зүй бол тодорхой хэм хэмжээний нийлбэр бус;харьцуулалтыг аргыг оновчтой хэрэглэх үйл ажиллагааны үр дүнд өөр өөр эрх зүйн тогтолцооны харьцуулалт бий болдог[8]» гэж өөрийн дүгнэлтийг гаргаж тавьсан.

ОХУ-ын харьцуулсан эрх зүй судлалын томоохон төлөөлөгч Ю.А.Тихомиров «харьцуулсан эрх зүй судлал харьцуулалтын аргыг өөрийн судалгааны арга зүй болгосон,өөрийн гэсэн судлах зүйлтэй шинжлэх ухаан» гэж санал дэвшүүлсэн байна. Ю.А.Тихомиров «харьцуулсан эрх зүй судлал»,»харьцуулсан эрх зүй» хэмээх ойлголтыг заагласан тодорхойлж,»харьцуулсан эрх зүй судлал бол цэвэр шинжлэх ухаан»,»харьцуулсан эрх зүй тухайн шинжлэх ухааны арга зүйг өөртөө багтаадаг[9]» гэж бичсэн байдаг.Профессор М.Н.Марченко өөрийн анхны бүтээлүүдэд «харьцуулалтын аргын онол эрх зүйн ерөнхий онолын бүрэлдхүүн хэсэг[10]» болно гэж үзсэн байдаг.

Харьцуулсан эрх зүй судлал хууль зүйн судалгааны тусгай хүрээ болохын хувьд дараах үндсэн чиглэлийг хамардаг.Үүнд:

- эрх зүй дэх харьцуулалтын арга зүйн асуудал
- орчин үеийн эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах
- хууль тогтоомжийн харьцуулалт
- функциональ харьцуулалт

6 Б.Минжүүрдорж.Даяаршиж буй дэлхий:харьцуулсан эрх зүй судлал.эрдэм шинжилгээ,судалгааны өгүүлэл I.УБ.,2010.5 тал

7 O.Kahn –Freund.Comparative law as an Academic Subject.82 Law Quarterly Rev. 40,41 /1966/

8 H.C.Gutteridge. Comparative law./Cambridge,reprint 1971/

9 Тихомиров.Ю.А. Курс сравнительного правоведения.М.,1996.С. 31

10 М.Н.Марченко. Общая теория государства и права.М.,1998.С.25-28

- түүхэн харьцуулалтын асуудлууд
- олон улсын эрх зүй бүтээх ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглах зэрэг болно.

**3. Харьцуулсан эрх зүй судлалын арга зүйн асуудал**

Хууль зүйн ном,сурах бичигт харьцуулалт харьцуулалтын аргатай холилдох явдал байдгийг онцгойлон тэмдэглэх нь зүйтэй.Гноселогийн мөн чанарын хувьд харьцуулалт,харьцуулалтын арга өөр хоорондоо нэн төсөөтэй.Харьцуулалтыг харьцуулалтын аргаас үл хамааруулан шинжлэх ухааны танин мэдэхүйн бүх салбарт хэрэглэж болно.Логик аргууд танин мэдэхүйн аргын агуулгад ямагт багтаж байдаг[11].

Харьцуулалт харьцуулалтын аргаар дамжин илэрч болохоос гадна харьцуулагдаж байгаа объектын ялгааг тогтооход тус дөхөм үзүүлдэг. Харьцуулсан эрх зүйн арга эрх зүйн үзэгдлийг судлах чухал арга хэрэгслийн нэг юм.Түүний тусламжтайгаар орчин үеийн эрх зүйн тогтолцооны нийтлэг,онцлог талуудыг нээн илрүүлэх боломжтой.

Харьцуулсан эрх зүйн аргын өвөрмөц онцлог дараах байдлаар илэрдэг.Үүнд:

- суурь шинжлэх ухааны аргатай холбогдох байдал;
- хууль зүйн салбар шинжлэх ухааны аргын тогтолцоонд эзлэх байр суурь зэрэг болно[12].

Суурь шинжлэх ухааны аргууд эрх зүйн тогтолцооны үүсэл,хөгжил,түүний зүй тогтлыг нээн илрүүлэхэд хэрэглэгддэг.Ганц харьцуулалтын аргаар эрх зүйн үзэгдлийг нээн илрүүлэх боломжгүй боловч энэ арга эрх зүйн судалгааны ерөнхий чиглэлийг тодорхойлдог.Шинжлэх ухааны судалгааны үйл явцд суурь,салбар шинжлэх ухааны аргын зохистой харилцан хамаарлыг хангах ёстой.Тиймээс харьцуулалтын арга тактикийн гэхээсээ илүү стратегийн үүрэг гүйцэтгэнэ. Шинжлэх ухааны танин мэдэхүйн практик суурь шинжлэх ухааны аргууд салбар шинжлэх ухааныхтай харилцан холбоотой байдгыг харуулна.Суурь шинжлэх ухааны аргууд салбар шинжлэх ухааны судалгааны зүйлийг судлахад уг салбар шинжлэх ухааны аргаар дамжин хэрэгждэг.Суурь шинжлэх ухааны аргууд салбар шинжлэх ухааны аргын бүтэцд үйлчилж байдаг төдийгүй суурь шинжлэх ухааны үр нөлөөг дээшлүүлэхэд салбар шинжлэх ухааны аргууд зайлшгүй шаардлагатай байдаг.Тиймээс харьцуулсан эрх зүй арга эрх зүйн үзэгдлийг судлахад суурь шинжлэх ухааны аргуудыг хэрэглэх тодорхой арга хэрэгслийн нэг юм.Энэхүү арга судалгааны ерөнхий чиглүүлэгч болж,эрх зүйн онолыг баяжуулж,шинжлэх ухааны цар хүрээг өргөжүүлж байдаг.Харьцуулсан эрх зүйн аргыг системтэй,тодорхой зорилго чиглэлтэй хэрэглэсэн тохиолдолд эрх зүйн үзэгдлийг судлахад үр нөлөөгөө өгч чадна.

**4.Эрх зүйн философи,харьцуулсан эрх зүй судлал,хоорондын харилцан үйлчлэл**

Дээрх хоёр шинжлэх ухааны хоорондын харилцан үйлчлэлийг дараах байдлаар тодорхойлж болох юм.Үүнд:

1. Эрх зүйн философи аливаа эрх зүйн судалгааны суурь үндэс болдог бол харьцуулсан эрх зүй судлал олон эрх зүйн тогтолцоог харьцуулдаг.Ийм байдлаар хоёр шинжлэх ухаан бодитойгоор оршин буй орчин үеийн эрх зүйн тогтолцоонд үндэслэдэг.Энэхүү төсөөтэй байдал уг шинжлэх ухаануудын хэрэглэж буй судалгааны аргын ялгаатай талд хамааралгүй.

2. Эрх зүйн философи харьцуулсан эрх зүй судлалд арга зүйн болон шинжлэх ухаан судлалын талаасаа нөлөө үзүүлдэг.Арга зүйн талаасаа эрх зүйн философи харьцуулалтын аргын танин мэдэхүйн боломжийг ойлгох, үнэлэх,тухайн аргын шинжлэх ухааны бусад аргатай хэрхэн холбогдох хүрээ хязгаарыг тогтоох зэрэгт нөлөөлдөг бол шинжлэх ухаан судлалын талаасаа орчин үеийн эрх зүйн тогтолцоог системтэй судалж,уг судалгааг онолын дээд түвшинд хүргэх боломжийг бүрдүүлдэг.

11 А.Х.Саидов.Сравнительное правоведение.М.,2000.стр. 34

12 Б.Минжүүрдорж.Даяаршиж буй дэлхий:харьцуулсан эрх зүй судлал.эрдэм шинжилгээ,судалгааны өгүүлэл I.УБ.,2010.11дэх тал.

3. Үндэсний эрх зүйн философи үндэс бусад улсын эрх зүйн талаарх ойлголтыг өөрийн улсынхтай харьцуулахад харьцуулалтын объект болдог бол нөгөө талаас эрх зүйн талаарх суурь ойлголтууд/эрх зүйн үндэс,түүний заавал биелэгдэх шинж,эрх зүйн үнэт зүйлс,эх сурвалж,тогтолцоо гэх мэт/ харьцуулсан эрх зүй судлалын маргааны объект болдог.

4. Эрх чөлөө,шударга ёс,энэрэнгүй ёс,эрх зүйн хэм хэмжээний заавал биелэгдэх шинж,хууль зүйн хариуцлага зэрэг ойлголтыг эрх зүйн философийн хүрээнд төдийгүй харьцуулсан эрх зүй судлалын хүрээнд харьцуулах нь илүү үр дүнтэй.

# БУСДЫГ АМИА ХОРЛОХОД ХҮРГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

*Шихихутуг ХЗС-ийн Салбар эрх зүйн тэнхмийн багш, магистр*

***Б.Цэрэнчимэд***

Амиа хорлох нь хувь хүний шийдвэр гэхээсээ илүү нийгмийн үзэгдэл байдаг. Тухайн нийгмийн хөгжил ямар байгаагаас үл хамааран амиа хорлох үзэгдэл газар авсаар дэлхийн бүхий л улс оронд их бага хэмжээгээр үйлдэгдэн, тоо нь жил ирэх тутам өсөн нэмэгдэж байна.

Амиа хорлолтыг зарим улс оронд гэмт хэрэг гэж үздэг бол зарим улс оронд гэмт хэрэг гэж үздэггүй . Амиа хорлолтын талаар эрдэмтэн судлаачид янз бүрийн онол сургаалиуд дэвшүүлсэн байдаг.

Тухайлбал: ***1. Absurdism-Абсурдизмийн онол:*** Энэ онол нь амиа хорлолтыг эсэргүүцдэг онол бөгөөд шашин шүтлэг, сэтгэлийн гутрал, өвчин зовлонгоос болж амиа хорлох нь утгагүй, байж боломжгүй зүйл гэж үздэг. Гол төлөөлөгч нь Альберт Гамис.

***2. Классикал либерализмын онол:*** Үхэлийг сонгож байгаа нь эрх чөлөө биш, хүн үхэх эрхгүй, харин амьд явах эрхтэй. Төлөөлөгч нь Жонн Стуарт Милл.

*3. **Deontology**-*Ёс суртахууны хэм хэмжээний онол. Төлөөлөгч нь Иммануэл Кант. Амиа хорлох нь хүн төрөлхтөний ёс суртахуунд нийцэхгүй,энэ замыг тэвчиж үл болно гэж үздэг.

***4. Utilitariniasm***-Амиа хорлогсод нь ард үлдэж буй гэр бүлийн гишүүд, найз нөхөдөө уй гашуудалд автуулдаг учир энэ нь хууль бус юм гэж үздэг.

***5. Right-to-die***-Үхэх эрхийг хүлээн зөвшөөрдөг онол. Хүн өөрөө бодгаль учир амьдралын төгсгөлөө яаж сонгох нь тухайн хүний эрхийн асуудал. Гол төлөөлөгч нь Леонард Пейкорр.

***6. Idealism***-Амиа хорлох нь хулчгар, зориггүй хүмүүсийн хийдэг үйлдэл юм. Энэ ертөнцөөс өөр дараагийн амьдрал байхгүй.

***7. Hinduism, Jainism***-Үхэх эрхийг хүлээн зөвшөөрдөг. Хэн нэгэн удаан хугацаагаар өвдөх, тэдэнд амьдрах хүсэл төрөхгүй бол үхэж болно.[1]

***Амиа хорлолтын төрөл:***

1. Дүүжлэх
2. Хордох / эм болон хортой бодис/
3. Галт зэвсэг хэрэглэх /халуун зэвсэг хэрэглэх/
4. Дэлбэлэх
5. Хүйтэн зэвсэг хэрэглэх
6. Өндрөөс үсрэх гэх мэт.

***Амиа хорлолт нь дараахь хэлбэрээр үйлдэгддэг:***

1. ***Copycat suicide*** буюу бусдыг даган дууриаж амиа хорлох. Энэ нь залуус кино болон бусад мэдээ, мэдээллийн хэрэгслээр амиа хорлох үйлдлийг даган дууриах замаар эсвэл нэр хүнд бүхий хүмүүсийг дууриаж амиа хорлохыг хэлнэ.
2. ***Cult suicide*** *буюу бурханыг шүтэж амиа хорлох.* Энэ нь нэгэн ижил газар , нэг цагт олноороо бурханыг шүтэж шашины зан үйлийг гүйцэтгэх замаар амиа хорлохыг хэлнэ. Жишээ нь: 1978 оны 1-р сарын 18-нд АНУ-д сүмд явдаг 918 хүнээс 909 нь дээрхи шалтгаанаар амиа хорлосноос 303 нь хүүхэд байсан.
3. ***Familicide** буюу гэр бүлийн гишүүд харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр амиа хорлох.* Энэ нь нэг төрлийн гэмт

1 http://www.bbc.co.uk/news/uk

хэрэг бөгөөд эхнэр нь нөхрөө, эсвэл хүүхдээ, ахан дүүс, эмэг эх, өвөг эцгээ алах гэх мэтчилэн төрөл садангийн холбоотой хүмүүсийн дунд ямар нэгэн шалтгаанаар бие биеэ алах буюу амиа хорлодог.

4. ***Forced suicide*** *буюу бусдад учирсан зовлон шаналалаас болж амиа хорлох.* Тухайлбал: Гэр бүлийн гишүүд нь амиа алдах, удаан хугацаагаар хоригдох гэх мэт сэтгэл санаанд нь учирсан гашуун зовлонг даван туулж чадахгүй амиа хорлох.

5. ***Honor suicide*** *буюу Хүндэтгэн, дээдлэх замаар амиа хорлох.* Жишээ нь: Япон улсад дэлхийн 2-р дайны үед Самурайн үхэл буюу эрэлхэг зоригтойгоор үхэх үхлийг даган дууриаж амиа хорлодог байжээ.

6. ***Internet suicide:*** Сүүлийн үед интернэтээр танилцан амиа хорлох явдал дэлхийн хэмжээнд тухайлбал Япон,Канад, Норвеги, АНУ, Швед болон бусад хөгжингүй орнуудад түгээмэл дэлгэрч байна.

7. ***Traditional suicide*** *буюу уламжлал, ёс заншлыг даган амиа хорлох.* Тухайн гэр бүлд тогтсон уламжлалыг даган өндөр настай хүмүүс сэтгэл санаа нь гутарсан буюу зовж шаналсан үедээ гэр бүлийн гишүүддээ төвөг удахгүйн тулд амиа хорлодог нэг хэлбэр юм.

8. ***Murder suicide.*** Нэг эсвэл хэд хэдэн хүний амийг нэг дор хөнөөгөөд дараа нь өөрийнхөө амийг хорлох. Тухайлбал: олон нийтийн газар олон хүнийг дэлбэлэх болон буудаад дараа нь өөрийгөө буудах, гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа ялаас зугатах зорилгоор эсвэл өөрийгөө буруутгах замаар амиа хорлодог.

9. ***Suicide-Attack*** буюу довтлох болон алан хядах үйл ажиллагаа явуулах замаар амиа хорлох: Энэ төрлийн амиа хорлолт нь Иран, Ирак, Афканистан, Пакистан зэрэг улс орнуудад түгээмэл гардаг.

10. ***Parasuicide*** буюу өөрийгөө зовоон тарчлаах замаар амиа хорлох: Ямар ч шалтгаангүйгээр өөрийгөө зовоон тарчлааж тухайлбал өөрийгөө зүсэж цус алдуулах, их хэмжээгээр хордох, өөртөө гэмтэл учруулах замаар амиа хорлох. Ихэвчлэн өсвөр бага насныхан үйлддэг байна.

11. ***Euthanasia***-Амьдралаас сайн дураар татгалзах буюу **right to die** - үхэх эрх

12. ***Suicide Pact***-гэрээ хэлэлцээр байгуулах, тангараг тавих замаар амиа хорлох.[2]

**Амиа хорлолтын шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс:**

1. Сэтгэл мэдрэлийн өвчин
2. Сэтгэл гутралын хүнд хэлбэр /depression/
3. Хүүхэд насны дарамт, шахалт
4. Гэрлэлт, гэр бүл салалт, хайр дурлалын асуудал
5. Эдийн засгийн байдал
6. Ажилгүйдэл
7. Архидалт
8. Хар тамхины хамаарал
9. Нийгэмшээгүй зан суртахуун
10. Амьдралаас уйдах
11. Шашны үзэл номлол гэх мэт.

Дэлхийн хэмжээнд амиа хорлогсдын 80 хувь нь эрэгтэйчүүд байдаг ба эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс 4-5 дахин их хувиар амиа хорлодог байна. Амиа хорлогсдын 80-85 хувь нь эрүүл саруул ухаантай хүмүүс байдаг. Амиа хорлогчдыг насны байдлаар нь авч үзвэл 70 хувь нь 16-25 насны, 26.2 хувь нь 26-50 насны, үлдсэн хувь нь 50-иас дээш насныхан байдаг аж. 16-25 насныхны амиа хорлох гол шалтгаан нь хайр дурлалаас болж өөрийгөө егүүтгэдэг байна. Харин 26-50 насныхны хувьд гэр бүлийн хэрүүл маргаан, салалт зэргээс болдог байна.

Амиа хорлолтыг зарим улс оронд гэмт хэрэгт тооцдог бол зарим улс оронд гэмт хэрэг гэж үздэггүй. Тухайлбал: Канад улсын эрүүгийн хуулийн 241-ийн Б хэсэгт «Хэн нэгэн этгээд бусдыг амиа хорлоход өдөөн түлхсэн буюу амиа хорлоход тусласан нь шүүхээс тогтоогдсон бол 14 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж заасан. Тус улсад 100,000 хүнд 20 эрэгтэй,5 эмэгтэй амиа хорлодог байна. 2006 онд Бельги улсад этиазийг хүлээн зөвшөөрсөн байна.

2 From Wikipedia, the free encyclopedia

- БНХАУ-д амиа хорлоход хүргэсэн буюу завдсан этгээд аль аль нь эрүүгийн хариуцлага хүлээдэг. Этназийг хүлээн зөвшөөрдөггүй. Эмч хүн бол хүнийг эмчлэх үүрэгтэй. Жилд дунджаар 100,000 хүнд 22,23 хүн амиа хорлодог бөгөөд эмэгтэйчүүд 14,8 хувийг эзэлдэг байна. Жилд ойролцоогоор 300,000 амиа хорлолт үйлдэгддэг байна.

- Япон улс нь дэлхийд амиа хорлолтын түвшингээрээ дээгүүр байрыг эзэлдэг. 71 хувь нь эрэгтэйчүүд, 29 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг.

- Колумба-д 1997 оны 5-р сард этназийг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь тухайн үед маш хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан боловч Колумбын Дээд шүүхээс этназийг хүлээн зөвшөөрсөн байна.

- Франц, Люксенбург, Нидерланд зэрэг улсуудад этназийг хүлээн зөвшөөрсөн.

- Герман улсад өөрөө өөрийнхөө амиа хорлосныг гэмт хэрэг гэж үздэггүй харин Этназийг гэмт хэрэг гэж үздэг. Германд үүнийг Mercy killing гэж нэрлэдэг.

- Шинэ зеланд улсын эрүүгийн хуулийн179-р зүйлд «Хэн нэгэн этгээд бусдыг амиа хорлоход өдөөн түлхсэн буюу амиа хорлоход тусласан нь бол 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж заасан.

- ОХУ-д амиа хорлолтын дийлэнхи хувь нь архидалтаас болж гарсан байдаг. 1990 онд 100,000 хүнд 40 хүн амиа хорлодог байсан бол 2012 онд 27,1 болж буурсан.

- АНУ-ын 3 мужид этназийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Oregana, Washington DC болон Montana мужууд. Oregana мужид 2010 оноос хойш 58 хүн хүсэлтээ гаргасны 15 хүнийг хүлээн зөвшөөрсөн байна. Судалгаагаар эмнэлгийн практикт эдгэрэх боломжгүй өвчтөнүүдийн 60 хувь нь /Physician – Aided dying/ PAD-ийг хүсдэг байна.[3]

***Г**эмт хэрэггүй нийгэм гэж байдаггүйтэй адил амиа хорлох үзэгдэл гарч байгаагүй нийгэм, түүхэн үе ч гэж байгаагүй. Энэ үзэгдэл нь нийгмийн үзэгдэл боловч нийгэм хөгжихийн хэрээр гаралтын тоо нь өсөж байдаг. Монгол улсын эрүүгийн хуулинд гадны нөлөөллөөр буюу субъектив хүчин зүйлээр , өөрийн дураар бус харин түүнийг зориуд санаатайгаар амиа хорлоход хүргэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцоохоор хуульчилсан.

1961 оны Эрүүгийн хуулийн 79-р зүйлд « Эрхшээлдээ байгаа хүнтэй хатуу хэрцгий хандах» гэмт хэргийг хуульчилж өгсөн. Тус хуулийн 79-р зүйлийн 79.1-д «Аж амьдралын ба бусад талаар өөрийн эрхшээлдээ байгаа хүнтэй үргэлж хатуу, хэрцгий харилцах буюу байнга басан доромжилбол 3 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл нэг жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ».[4]

Мөн хуулийн 79.2-т «Энэ гэмт хэргийн улмаас хохирогч амиа хорлосон буюу хорлоход хүрсэн бол 6 жил хүртэл хугацаагаар хорино» гэж хуульчилсан байдаг.

1987,1994 оны Эрүүгийн хуулийн 102-р зүйлд «Эд материалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнтэй хэрцгий харьцсан буюу алдар хүндийг нь байнга басан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон буюу хорлохоор завдсан бол 6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж заасан. [5]

2002 оны Эрүүгийн хуулийн 95-р зүйлийн 95.1-д »Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ» гэж хуульчилсан байдаг.[6]

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүн амьд явах эрхтэй гэж хуульчилсан байдаг. Хүний амьд явах эрх нь субьектив эрх биш , харин объектив эрх юм.

Монгол улсын практикт хохирогчийг өөрийн нь хүсэлтээр алах үйлдлийг ЭХ-ийн 91-р зүйлийн 91.1-ээр зүйлчилж байгаа. Энэ субъектив талын хувьд хүнийг санаатай алж байгаа асуудал биш юм . Хохирогчийн ***туйлын хүсэл*** энэ гэмт хэргийг үйлдүүлэхэд хүргэсэн байдаг.

2010 онд Монгол улсад нийт 19825 гэмт хэрэг үйлдэгдсэнээс амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 727 буюу нийт гэмт хэргийн 4 хувь, 2011 онд нийт 19197 гэмт хэрэг үйлдэгдсэнээс

3 From Wikipedia, the free encyclopedia

4 Эрүүгийн хууль., 1961 он,
5 Эрүүгийн хууль., 1987, 1994 он
6 Эрүүгийн хууль., 2002 он,

314 буюу 2 хувь энэ төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Дээрхи хэргүүдийн гаралтын байдлыг харьцуулж үзэхэд 2011 онд амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 413-аар буюу 56,8 хувиар буурсан . 2012 оны эхний 9 сарын байдлаар нийт 16160 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 134 нь амиа хорлоход хүргэх гэмт хэрэг байсан ба энэ нь өмнөх оныхоос 180 хэргээр буюу 42,6 хувиар буурсан байна.[7]

Хэдийгээр дээрхи судалгаанаас харахад амиа хорлоход хүргэх гэмт хэргийн тоо буурч байгаа ч гэсэн цаашид гарахгүй байх, өсөхгүй байх баталгаа байхгүй юм.

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн гаралтыг бууруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дараах саналуудыг дэвшүүлж байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 95-р зүйлийн 95.1-д »Эд хөрөнгө, албан тушаалын болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа болон өөр бусад хүмүүстэй харгис хэрцгий харьцсан буюу нэр төр, алдар хүндийг нь байнга гутаан доромжилсны улмаас хохирогч амиа хорлосон буюу амиа хорлохоор завдсан.......» гэж нэмэлт оруулах.

- Өөрөө сайн дураар амиа хорлохоор завдсан этгээд сэтгэлийн гутралаас болж амиа хорлохоор завдсан үйлдэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч амиа дахин хорлох үйлдэлээс урьдчилан сэргийлэх. Эдгээр хүмүүст эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч эмчлэх нь тухайн төрлийн гэмт хэрэг дахин гарах, амиа хорлолтыг бууруулах нэг хүчин зүйл болно гэж үзэж байна. .

- Этаназийг эрүүгийн хуулиндаа гэмт хэрэгт тооцохгүй байх. Хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн энэрэнгүй , ардчилсан нийгмийг байгуулсан өнөөгийн нөхцөлд өвчин зовлондоо шаналж, эдгэрэх боломжгүй удаан хугацаагаар хүнд байдалд байгаа хүмүүсийг өөрийн хүсэлтээр үхэх эрхийг хүлээн зөвшөөрөх цаг болсон гэж үзэж байна. Үхэх эрхийн тухай асуудал нь ихээхэн маргаантай асуудал байдаг боловч зовж шаналсан нэг хэсэг хүмүүсийн хувьд хүлээлтийн байдалтай байгааг харгалзан эрүүгийн хуулиндаа энэ асуудлыг хуульчилж болох юм.

- Этаназийг хуульчилж өгөхдөө тодорхой шалгуураар, тодорхой тохиолдолд хэрэглэж болохоор хуульчилж болох юм. Тухайлбал: Өвчтөн удаан хугацаагаар /3 жилээс дээш / эдгэрэх боломжгүй өвчин тусаж өөрөө үнэхээр тэр өвчиндөө зовж шаналж байгааг эмчлэгч эмч болон бусад мэргэжлийн 2-оос доошгүй эмчийн тодорхойлолтоор тодорхойлсон, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хүсэлтийг харгалзан эмч болон прокурорын хяналтан дор гүйцэтгэж болох юм.

- Зөвшөөрч болох өвчнүүдийн жагсаалтыг хуульчлан тогтоох замаар гаргах нь энэ хэлбэрийг ашиглан эмч нар гэмт хэрэг үйлдэх боломжийг хязгаарлаж байгаа юм.

- Амиа хорлохоор завдаж буй хүмүүст тусламж дэмжлэг үзүүлж,санаа сэтгэлийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг сайн дурын, ашгийн төлөө бус байгууллага байгуулах, үйл ажиллагааг нь төрөөс дэмжих, амиа хорлох гэмт хэрэгтэй тэмцэх тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх зэрэг нь энэ төрлийн үйлдэл болон гэмт хэргийн тоо ихсэж газар авахаас өмнө урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой юм.

7 ЦЕГ-ын Мэдээлэл судалгааны төвийн 2010, 2011, 2012 оны гэмт хэргийн нөхцөл байдлын тухай мэдээлэл



# СЭДЭВ: «ЯПОНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ НЬ ХОСОЛСОН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БОЛОХ НЬ »

/ Харьцуулсан эрүүгийн эрх зүйн хүрээнд /

*М.Түвшинжаргал*
*Шихихутуг ХЗДС-ийн Төр, эрх зүйн онол, түүхийн тэнхмийн багш*

**Илтгэлийн товч агуулга:**

**ОРШИЛ**

1. ХОСОЛСОН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ ТҮҮНИЙ ОНЦЛОГ
2. ЯПОНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ НЬ ХОСОЛСОН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БОЛОХ НЬ

**ДҮГНЭЛТ**
**АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

## 1. ХОСОЛСОН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Дэлхийн улс орон бүр өөрийн орны онцлог, уламжилж ирсэн зан заншил, соёлын өвөрмөц шинжээс хамааран харилцан адилгүй эрх зүйн тогтолцоог бүрдүүлж иржээ. Тэр дундаа гэмт явдал түүнтэй тэмцэх, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн эрх зүйн тогтолцоог дэлхийн улс бүр харилцан адилгүй хөгжүүлж ирсэн байна.

Энэ талаар олон эрдэмтэн судлаачид улс бүрийн нийтлэг шинж, эрүүгийн хуулийн бүтэц, үнэт зүйлийг нь харьцуулан судлаж дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн системийг дараах байдлаар ангилан үзсэн байна. Үүнд:

1. Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн систем
2. Эх газрын эрүүгийн эрх зүйн систем
3. Мусальманы эрүүгийн эрх зүйн систем
4. Хосолсон ба холимог эрүүгийн эрх зүйн систем гэж тус тус ангилан үзсэн байна[1].

Хөгжингүй ба хөгжиж буй улс орнууд, тэрчлэн шинэ тутам болон хот улс, жижиг арлын орнуудад эрүүгийн эрх зүйн тогтолцооны хосолсон буюу холимог хэлбэр илэрч байна. Эдүгээ системүүдийн харилцан шилжсэн, зээлдсэн, нутагшсан зэрэг хамааралт холбогдлын шинж байдлаар нь:

1. Хосолсон Эрүүгийн эрх зүйн тогтолцоо

2. Холимог Эрүүгийн эрх зүйн тогтолцоо гэж ангилж болно[2].

Хосолсон эрүүгийн эрх зүйн тогтолцоо гэдэг нь өөрийн үндэсний соёл уламжлал эрх зүйн үнэт зүйлсийг бие даан хадгалж, олон жилийн турш хөгжүүлэх явцад Англи-Америкийн болон Эх газрын эрх зүйн системийн аль алиных нь хэв шинжийг бүгдийг нь биш, харин зарим зүйлийг нь хослуулан авч, хэрэглэсэн байдлыг хэлнэ. Энэ системийг дараахь чиглэлээр ангилж болно. Үүнд:

- Скандиновын хосолсон эрүүгийн эрх зүй
- Япон, Филиппины хосолсон эрүүгийн эрх зүй гэж ангилан үзэж болно[3]. Дараагийн хэсэгт хосолсон эрүүгийн эрх зүйн системийн гол төлөөлөл болох Японы Эрүүгийн эрх зүйн системийг товч авч үзье.

## 2.ЯПОНЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ НЬ ХОСОЛСОН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СИСТЕМ БОЛОХ НЬ

Японы эрүүгийн эрх зүй систем:

1. Засгийн газар, цагдаа, прокурор, шүүх болон зөвлөх байгууллагууд хамтран нэгэн

[1] Д.Баярсайхан. "Харьцуулсан эрүүгийн эрх зүй" УБ.2011 он, 40 дахь тал

[2] Мөн тэнд

[3] Мөн тэнд

байгууллага шиг ажиллаж эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрхэн ямар оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд өөр хоорондоо байнга зөвлөгөө өгч ажиллах;

2. Нийгмийн хэв журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг баривчлах болон гэмт этгээдийг сахилгажуулах, саатуулах ажилд иргэдийн тусламж дэмжлэгийг өргөнөөр оролцуулах;

3. Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэгч албаны хүмүүс гэмт этгээдтэй ихээхэн хянуур болгоомжтой ажиллах зэргийг заасан 3 үндсэн хэсгээс бүрддэг[4].

1868 оноос хойш шүүн таслах ажиллагаа хурдтайгаар өөрчлөгдсөн. 1880 онд Эрүүгийн төрөлжсөн хууль, Эрүүгийн үндсэн (ерөнхий) хуулиудыг шинээр зохион гаргаж олон нийтэд зарлан тунхагласан. Эдгээр хуулиуд нь Франц загвар дээр үндэслэгдсэн зохиогдсон. Тус хуулиар гэмт хэргийн зөрчлийг тодорхой зааж, зарим гэмт хэргийн ял шийтгэлийг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөхөөр хатуу чанга хуульчлан тогтоосон. Дээрх 2 хууль нь бүх ард түмэнд нэгэн ижил үйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх захирганы төв байгууллагаар хангагдсан (баталгаажсан) ба Пост Факто хуулийн ял шийтгэлийг хэрэглэхийг хориглосон.

Япон улсад Германы хуулийн нөлөө нэмэгдсэнээр 1907 онд Эрүүгийн төрөлжсөн хуулийг үндсэндээ бүрэн шинэчлэн найруулаж, өмнөх Франц загварын 3 үндсэн хэсгийг хүчингүй болгосон.

Мэйжийн /*Meiji*/ эрин үед гарсан Японы төрөлжүүлсэн эрүүгийн хуулиудын хамгийн анхных нь 1878 онд батлагдсан /*1882, 1973* онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан/ эрүүгийн төрөлжүүлсэн хууль байлаа[5]. Эрүүгийн хэргийн хувьд мөрдөн байцаалт явуулах албан ёсны гол арга нь урьдын адил эрүү шүүлт байсан атал гагцхүү Г.Буассонад Японы засгийн газарт шаргуу хандсаны дүнд 1879 онд дээрх заалтыг хүчингүй болгосон аж. 1882 онд Г.Буассонадын удирдлагын дор францын хуулиудын загвараар боловсруулсан Эрүүгийн төрөлжүүлсэн хууль, эрүүгийн процедурын тухай хууль зэрэг акт гаргасан нь Японы эрүүгийн эрх зүйн урагшлах хөгжилд шинэчлэлт олсон ахиц байсан[6].

Жишээ нь:

1882 оны Японы Эрүүгийн төрөлжүүлсэн хууль /**Penal code of japan**/ нь «Хуульд заагаагүй гэмт хэрэг болон ял үгүй» гэсэн зарчмыг Японы шүүхийн практикт анх удаа оруулж ирсэн. Мөн эрүүгийн хариуцлагыг бий болгосон буюу чангатгасан хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон байна[7]. Хэрэв гэм буруутай этгээд тухайн гэмт явдалд оролцсон тухайгаа хууль сахиулагчдад сайн дураараа мэдээлсэн нөхцөлд бүхий л гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг заавал хөнгөрүүлэх тухай заалт зэрэг хуучны Японы эрх зүйн хэд хэдэн энэрэнгүй заалтыг энэ хуульд оруулсан нь тус хуулийн нэг томоохон онцлог юм[8]. Мөн энэ хуулиар бие махбодийг тарчлаан зовоох болон нэр төрийг баалан гутаах ял ногдуулах, тэрчлэн хүндрүүлэх нөхцөлтэй гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулахыг бүрмөсөн хоригложээ.

1907 оны Японы төрөлжсөн эрүүгийн хуульд[9]: Аливаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтооход ч, санкцын хэмжээг тодорхойлоход ч шүүхийн үзэмжийг ихээхэн өргөн хүрээтэй болгож өгсөн. Японы хууль тогтоомжид цаазаар авах ялыг хэд хэдэн төрлийн гэмт хэрэгт ногдуулахаар заасан боловч үнэн хэрэгтээ сүүлийн жилүүдэд зөвхөн хүн амины хүнд хэрэгт ногдуулж, маш цөөхөн тохиолдолд гүйцэтгэдэг байна. Японы Эрүүгийн материаллаг эрх зүй нь Үндсэн хуулиас хойш шинэчлэлт өөрчлөлтөд бага өртсөнөөрөө байцаан шийтгэх ажиллагааны институтээс ялгаатай. Тодорхой өөрчлөлт орсон боловч (1947 онд Эзэн хаан ба түүний гэр бүлийн эсрэг өдүүлсэн халдлагатай

4 http://en.wikipedia.org/w/index.php?title=Special%3ASearch&search=criminal+law+of+japan

5 http://www.isc.meiji.ac.jp/~sumwel_h/Codes/comp-crim.htm

6 С.Нарангэрэл. "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо". УБ, 2001 он. 128 дахь тал

7 http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf

8 http://web.tuj.ac.jp/newsite/main/law/lawresources/TUJonline/Crime/boryokucrime.html

9 この刑法の翻訳は、平成十八年法律第三六号までの改正（平成１８年５月２８日施行）について、「法令用語日英標準対訳辞書」（平成１８年３月版）に準拠して作成したものです。なお、この法令の翻訳は公定訳ではありません。法的効力を有するのは日本語の法令自体であり、翻訳はあくまでその理解を助けるための参考資料です。この翻訳の利用に伴って発生した問題について、一切の責任を負いかねますので、法律上の問題に関しては、官報に掲載された日本語の法令を参照してください。

холбогдсон хэт хуучирсан өөр бусад үндэслэл заалтыг эрүүгийн хуулиас хассан)

1907 онд батлагдсан батлагдсан Эрүүгийн төрөлжүүлсэн хуулийг (1947 онд нэмэлт өөрчлөлт оруулсан) өнөөдөр Японд дагаж мөрдөж байна. Японд одоо мөрдөж Эрүүгийн хууль нь 1907 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр / №45/ батлагдаж, 1995 оны 5 сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон.

Энэ хууль нь 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Нэгдүгээр хэсэг нь. Нийтлэг үндэслэл. Уг хэсэг нь 13 бүлэг 72 зүйлтэй.

2. Хоёрдугаар хэсэг нь: Гэмт хэрэг. 40 бүлэг, 264 зүйлтэй[10].

Эрүүгийн хууль тогтоомжийг бүхэлд нь шинэчлэх гэсэн өөрөөр хэлбэл энэхүү хуулийг өөр хуулиар халах гэсэн оролдлого нэг бус удаа гарч (1927, 1947, 1972 оны төсөл болон бусад) байсан боловч тухай бүрдээ ямар нэг шалтгааний улмаас үр дүнгүй өнгөрч байжээ. Эдүгээ иймэрхүү оролдлого нь шинэчлэлт хийгдсэнээр эрүүгийн хууль тогтоомжид харгис хатуу шинжтэй өөрчлөлт оруулж, иргэдийн эрхийг хязгаарлахад хүргэж болзошгүй хэмээн болгоомжилсон ардчилсан олон нийтийн эсэргүүцэлтэй тулгарч байна[11].

Япон улсын Эрүүгийн эрх зүйн эх сурвалжид дараах хуулиуд байна.

1. Японы эрүүгийн төрөлжсөн эрүүгийн хууль **(1970)**

2. Ялимгүй гэмт хэргийн тухай хууль **(1948)**,

3. Насанд хүрээгүй хүмүүсийн тухай хууль **(1948)** болон нэлээд өөрчлөгдөж, нэмэлт хийгдсэн бусад акт хамаарна.[12]

Эрүүгийн хууль үг хэллэг, бүтэцийн хувьд хэтэрхий хуучирсан учраас ойлгох, хэрэглэхэд түвэг учруулж байсныг харгалзан 1995 онд хэрэглэгчид хүртээмжтэй, ойлгомжтой болгон шинэчлэн боловсруулж баталсан.

Японы Эрүүгийн эрх зүйн номлолд гэмт хэргийг хэлбэр, агуулгаар нь: материаллаг, хэлбэрийн, дуусаагүй, төгссөн, хүндрүүлэх нөхцөлтэй, нийлмэл, нийгэмд аюултай хохиролтой, нэг хүний үйлдсэн, хамтран үйлдсэн, гэм буруугийн хэлбэрээр: санаатай болон санаатай болон болгоомжгүй, хүнд хөнгөн зэрэглэлээр нь: хүнд биш, хүнд, цагдаагийн зөрчил, халдаж буй объектын шинжээр нь: төрийн эсрэг, байгууллагын эсрэг, хүний эсрэг гэж ангилсан байдаг[13]. 1907 оны Эрүүгийн хууль нь Германы 1871 оны эрүүгийн хуулийн загвараар хийгдсэн ч өөрийн орны онцлогийг шингээсэн. Дэлхийн 2 дугаар дайны төгсгөл хүртэл Германы нөлөө хэвээр байсан.[14]

1947 онд Эрүүгийн төрөлжсөн хууль нь ерөнхийдөө 1907 оныхтой төстэй хэлбэрээр шинэчлэгдэн найруулагдсан. Энэ хуулиар шүүгч гэрчийг байцааж хэргийг гэрчийн мэдүүлгийг үндэслэн гэм буруугтоггоох болсон. Урьдчилсан мөрдөн байцаалтыг хориглосон байна. Улсын яллагч болон батлан хамгаалах зөвлөлийн гишүүн шүүгчийн адил түвшинд суухаар заасан. Дайны дараах жилүүдэд гэм буруугийн нөхөн төлбөр болон насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, тэнсэн харгалзах мөн жижиг гэмт хэргүүдийг эрүүгийн хэрэг эрхлэх ерөнхий газар луу шилжүүлсэн.

**Японы үндсэн хууль ба эрүүгийн төрөлжсөн хууль**

**/constitution law and penal code/:**

Дэлхийн хоёрдугаар дайнд Япон улс ялагдал хүлээж тус арлууд Америкийн цэргийн бүрэн эзэмшилд орсны дараа Японы шинэ Үндсэн хуулийг боловсруулах ажил эрчимтэй явагдаж Японы парламент Үндсэн хуулиа 1946 оны 11 сарын 3-нд баталсан бөгөөд 1947 оны 3 сарын 3-наас хүчин төгөлдөр үйлчилж буй бөгөөд өдийг хүртэл нэг ч удаа нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.[15] Япон улс нь Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хамаарах зарчмын шинжтэй заалтыг Үндсэн хуулиар тунхаглаж өгсөн байдаг нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд чухал ач холбогдолтой юм. Японы Эрүүгийн хуульд зарчмуудыг хуульчлаагүй

10 http://constitutions.ru/archives/407/3

11 http://www.npa.go.jp/sosikihanzai/jafic/horei/Lawptcp.pdf

12 С.Нарангэрэл- Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. 2001 он. 432-435-р тал

13 С.Жанцан. "Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол". УБ, 2009 он 165 дахь тал

14 http://www.pravo.vuzlib.net/book_z1410_page_177.html

15 Т.Доохуу, Ч.Энхбаатар. "Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй". УБ, 2009 он. 82-83 дахь тал

боловч эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмууд Үндсэн хуульд тусгагдсан байна.

Жишээ нь:

***Article-31*** Хуулиар тогтоосон журмыг дагаж мөрдөхгүйгээр ял шийттэхийг хориглоно[16],

***Article-32*** Хэний ч хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх эрхийг хасахгүй байх[17],

***Article-37*** Хууль бусаар баривчлахыг хориглох, өмгөөлүүлэх эрхтэй байх, эрүү шүүлт болон харгис хэрцгий ял хэрэглэхийг хориглох, хууль бусаар нэгжлэг хийхийг хориглох, эрүүгийн хэргээр яллагдаж буй этгээд хэргээ шударга нээлттэй шүүхээр шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах[18] зэргийг дурьдаж болох юм.

Сэжигтний хамгийн наад захын эрхийг зөрчиж, шүүхийн хууль бус таслан шийдвэрлэх тогтоол гаргадаг ихэд дэлгэрсэн практикийг харгалзан Үндсэн хуульд **/chapter III: rights and duties of the people/:** «Хэнийг ч албадаж өөрийнх нь эсрэг мэдүүлэг гаргуулж болохгүй. Албадлага, эрүү шүүлтийн улмаас сүрдүүлэг заналхийлэх, удаан хугацаагаар хууль бусаар баривчилсан буюу цагдан хорьсны дараа хэрэг хүлээсэн мэдүүлгийг нотлох баримт гэж үзэж үл болно гэсэн хэм хэмжээг оруулжээ[19]. Эрх мэдлийг хуваарилах онолын дагуу Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг бүхэлд нь дээд шүүх буюу доод шатны зохих шүүхэд олгож «Бүх шүүгчид хараат бус байх бөгөөд хүнлэг чанараар үйл ажиллагаагаа явуулна, шүүгч зөвхөн Үндсэн хууль болон хуультай холбогдоно» гэж тунхагласан байна [20].

Энэ салбарт Үндсэн хуулийг зөрчсөн жишээ Японы дараа дараагийн хуульд олонтаа гарсан боловч энэ бүхнийг тунхагласан тэрхүү явдал дангаараа гэхэд л ихээхэн дэвшилтэт үүрэг гүйцэтгэсэн.

Японы эрүүгийн шүүн таслах ажиллагааны тухай хууль:

Япон улс 1946 онд Үндсэн хуулийг баталсаны дараа Эрүүгийн шүүн таслах ажиллагааны болон салбарын хууль тогтоомжуудыг дахин хянан үзэж шинэчилж ирсэн. 1947 онд батлагдсан «Цагдаагийн тухай хууль» нь урьд өмнө байсан дээд зэргээр төвлөрсөн цагдаагийн механизмыг үгүй хийн орон нутгийн эрх баригчдын хяналтанд оруулжээ.

1948 онд Эрүүгийн байцаан шийтгэх шинэ төрөлжүүлсэн /Procedur Penal Code of Japan/ хууль хүчин төгөлдөр болсон нь Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн хэд хэдэн үзэл санаа институтыг дотроо багтаасан бөгөөд сэжигтэн, яллагдагчийн эрхийн хамгаалалтыг улам хүчтэй болгосон. Энэ үед салбарын олон хуулиуд мөн адил батлагдан гарч байсан.

Жишээ нь:

1. Шүүхийн байгууламжийн тухай /**1947** он /
2. Прокурорын байгууллагын тухай /**1947** он/
3. Өмгөөлөх байгууллагын тухай /**1949**/ зэрэг хуулиудыг нэрлэж болно.

Эдгээр хуулиуд олон удаа өөрчлөгдсөн боловч бүгд хүчинтэй хэвээр үйлчилж байна. Дээд шүүхээс Үндсэн хуулиар олгосон өргөн эрхийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх хуулийн олон заалтыг нарийвчлан цааш хөгжүүлж «Эрүүгийн байцаан шийтгэх журам» **/1948** он**/** гэдэг нэртэй баримт бичгийг гаргажээ. Энэхүү журмыг иргэний шүүн таслах ажиллагаанд ч, гэр бүлийн маргааныг авч үзэхэд ч, шүүхийн удирдлагын илээд асуудлыг шийдвэрлэхэд ч хэрэглэх зорилгоор дээд шүүхээс батлан гаргасан байна. Японы шүүн таслах ажиллагааны тогтолцооны шинэчлэлт нь бүхэлдээ тус орон дахь ардчилсан хүчний байр суурийг бэхжүүлж, харгислалтай хийх дараа дараачийн тэмцлийн эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна[21].

16 http://www.servat.unibe.ch/law/icl/ja00000_.html
17 http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html
18 http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html
19 http://www.kantei.go.jp/foreign/constitution_and_government_of_japan/constitution_e.html
20 Article 76: Chapter judiciary
The whole judicial power is vested in a Supreme Court and in such inferior courts as are established by law. 2) No extraordinary tribunal shall be established, nor shall any organ or agency of the Executive be given final judicial power. 3) All judges shall be independent in the exercise of their conscience and shall be bound only by this Constitution and the laws.
21 http://en.wikipedia.org/w/index.php?title=Special%3ASearch&search=criminal+law+of+japan

Дагаж мөрдөж буй шүүхийн процедурт яллагдагч хэргээ хүлээх явдал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байдаг «инквизаци шүүн таслах ажиллагаатай» эн түрүүнд холбоотой өнгөрсөн үеийн элемент ба шүүх хуралдааны явц, гадна талдаа чин шудрага мэт харагдах шүүгчийн байр суурь хоёр тэмцэлдсэн шинжтэй байдаг нь шүүн таслах ажиллагааны Англи-Америкийн тогтолцооноос зээлдсэн элементүүд харилцан холилдож сүлжилдсэнийг харуулна.

## ДҮГНЭЛТ

Японы эрүүгийн эрх зүй систем нь материаллаг ба процессын талаасаа харьцангуй хосолсон шинжтэй байдаг бөгөөд шүүхийн прецендент үйлчилдэггүй онцлогтой юм. Япон улс нь өөрийн уламжлалт өвөрмөц эрх зүйн тогтолцоотойн дээр төрөлжсөн эрүүгийн хуультай төдийгүй, зэрэгцсэн эрүүгийн 30 гаруй эрүүгийн хууль үйлчилж байна. Эрүүгийн эрх зүйн систем нь Герман болон Францын эрүүгийн төрөлжсөн хуулийн үзэл санаа, зарчим, үнэт зүйлийг эрх зүйн рецевци хийх журамаар нутагшуулж чадсан мөн эрүүгийн процессын үндсэн зарчим Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системыг хослуулан авсан нь хосолсон эрүүгийн эрх зүйн системтэй гэж үзэх үндэслэлтэй байна. Японы Эрүүгийн эрх зүйн системийг судлан үзхэд дараах онцлог шинжүүд илэрч байна. Үүнд:

- Япон улс нь 1882 онд Г.Буассонадын удирдлагын дор Францын хуулиудын загвараар боловсруулсан Эрүүгийн төрөлжүүлсэн хууль, эрүүгийн процедурын тухай хууль зэрэг акт гаргасан нь Японы эрүүгийн эрх зүйн цаашид урагшлан хөгжихд түлхэц болсон байна. Уг хуулиар гэмт хэргийн зөрчлийг тодорхой зааж, зарим гэмт хэргийн ял шийтгэлийг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөхөөр хатуу чанга хуульчлан тогтоосон байна. Мөн 1882 оны Японы Эрүүгийн төрөлжүүлсэн хууль /Penal code of japan/ нь «Хуульд заагаагүй гэмт хэрэг болон ял үгүй» гэсэн зарчмыг Японы шүүхийн практикт анх удаа оруулж ирсэн нэг томоохон онцлог болжээ.

- Япон улсад Германы хуулийн нөлөө нэмэгдсэнээр 1907 онд Эрүүгийн төрөлжсөн хуулийг үндсэндээ бүрэн шинэчлэн найруулаж, өмнөх Франц загварын 3 үндсэн хэсгийг хүчингүй болгосон байна.

- Үүний дараагаар Мэйжийн */Meiji/* эрин үед гарсан Японы төрөлжүүлсэн эрүүгийн хуулиудын хамгийн анхных нь 1878 онд батлагдсан */1882, 1973* онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан/ эрүүгийн төрөлжүүлсэн хууль байлаа[22]. Эрүүгийн хэргийн хувьд мөрдөн байцаалт явуулах албан ёсны гол арга нь урьдын адил эрүү шүүлт байсан ба Японы засгийн газарт шаргуу хандсаны дүнд 1879 онд дээрх заалтыг хүчингүй болгосон байна.

- Японы Эрүүгийн материаллаг эрх зүй нь Үндсэн хуулиас хойш шинэчлэлт өөрчлөлтөд бага өртсөнөөрөө байцаан шийтгэх ажиллагааны институтээс ялгаатай байна.

- 1907 онд батлагдсан батлагдсан Эрүүгийн төрөлжүүлсэн хуулийг /1947 онд нэмэлт өөрчлөлт оруулсан[23]/ өнөөдөр Японд дагаж мөрдөж байна. Японд одоо мөрдөж Эрүүгийн хууль нь 1907 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр / №45/ батлагдаж, 1995 оны 5 сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон нь Японы нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдалтай шууд холбоотой юм.

- Япон улс хэдий Германы эрүүгийн хуулийн үзэл санааг тусгасан ч өөрийн орны онцлогыг мөн тус хуулинд тусгаж өгсөн байна. Германы загвараар шинэчлэн тогтоосон Японы Эрүүгийн хууль нь 2 хэсгээс бүрдэж байна. Үүнд:

Нэгдүгээр хэсэг нь. Нийтлэг үндэслэл. Уг хэсэг нь 13 бүлэг 72 зүйлтэй.

Хоёрдугаар хэсэг нь: Гэмт хэрэг. 40 бүлэг, 264 зүйлтэй байна.

- Эрүүгийн хууль тогтоомжийг бүхэлд нь шинэчлэх гэсэн өөрөөр хэлбэл энэхүү хуулийг өөр хуулиар халах гэсэн оролдлого нэг бус удаа гарч (1927, 1947, 1972 оны төсөл болон бусад) байсан болович тухай бүрдээ ямар нэг шалтгааний улмаас үр дүнгүй өнгөрч байжээ. Эдүүгээ иймэрхүү оролдлого нь шинэчлэлт хийгдсэнээр эрүүгийн хууль тогтоомжид харгис хатуу шинжтэй өөрчлөлт оруулж, иргэдийн эрхийг хязгаарлахад хүргэж болзошгүй хэмээн

22 http://www.isc.meiji.ac.jp/~sumwel_h/Codes/comp-crim.htm

23 Японд 1947 онд Эрүүгийн хуулиа Германы загвараар шинэчлэн тогтоосон ба хэд хэдэн эрүүгийн хууль тогтоомжийн актаар зохицуулагдсан байдаг. Герман улс 1871 онд "Эрүүгийн хууль цаазын журам" нэртэй анхны эрүүгийн хууль батлагджээ.

засгийн газрын зүгээс болгоомжилж байгаа нь эрүүгийн хууль өөрөө тухайн нийгмийн харилцааны гол үндэс суурийг зохицуулж байдаг гэдэг харагдаж байна.

- Япон улс нь Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд хамаарах зарчмын шинжтэй заалтыг Үндсэн хуулиар тунхаглаж өгсөн байдаг нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд чухал ач холбогдолтой юм. Японы Эрүүгийн хуульд зарчмуудыг хуульчлаагүй боловч эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмууд Үндсэн хуульд тусгагдсан байдаг.

- Япон улс 1946 онд Үндсэн хуулийг баталсаны дараа Эрүүгийн шүүн таслах ажиллагааны болон салбарын хууль тогтоомжуудыг дахин хянан үзэж шинэчилж ирсэн. 1947 онд батлагдсан «Цагдаагийн тухай хууль» нь урьд өмнө байсан дээд зэргээр төвлөрсөн цагдаагийн механизмыг үгүй хийн орон нутгийн эрх баригчдын хяналтанд оруулж өгсөн байна. 1948 онд Эрүүгийн байцаан шийтгэх шинэ төрөлжүүлсэн */Procedur Penal Code of Japan/* хууль хүчин төгөлдөр болсон нь Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн системийн хэд хэдэн үзэл санаа институтыг дотроо багтаасан бөгөөд сэжигтэн, яллагдагчийн эрхийн хамгаалалтыг улам хүчтэй болгосон.

- Дээд шүүхээс Үндсэн хуулиар олгосон өргөн эрхийн дагуу эрүүгийн байцаан шийтгэх хуулийн олон заалтыг нарийвчлан цааш хөгжүүлж «Эрүүгийн байцаан шийтгэх журам» /1948 онд/ гэдэг нэртэй баримт бичгийг гаргажээ. Энэхүү журмыг иргэний шүүн таслах ажиллагаанд ч, гэр бүлийн маргааныг авч үзэхэд ч, шүүхийн удирдлагын нилээд асуудлыг шийдвэрлэхэд ч хэрэглэх зорилгоор дээд шүүхээс батлан гаргасан байна. Дагаж мөрдөж буй шүүхийн процедурт яллагдагч хэргээ хүлээх явдал шийдвэрлэх ач холбогдолтой төдийгүй өнгөрсөн үеийн элемент ба шүүх хуралдааны явц, гадна талдаа чин шударга мэт харагдах шүүгчийн байр суурь хоёр тэмцэлдсэн шинжтэй байдаг нь шүүн таслах ажиллагааны Англи-Америкийн тогтолцооноос зээлдсэн элементүүд харилцан холилдож сүлжилдсэнийг харуулаж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

### НОМ СУРАХ БИЧИГ:


1. **Д.Баярсайхан «Харьцуулсан эрүүгийн эрх зүй» УБ, 2011 он**
2. С.Нарангэрэл- Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. 2001 он.
3. С.Жанцан. «Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол». УБ, 2009 он
4. Т.Доохүү, Ч.Энхбаатар. «Гадаад орнуудын үндсэн хуулийн эрх зүй». УБ, 2009 он


### ЦАХИМ ХУУДАС:


- http:// www.penal.org /
- http:// www.suprem.justia.com /
- http:// www.legislationline.org/
- http:// www.en.wikipedia.org/
- http:// www.apsu.ed/occonort /
- http://www.unodc.org/unodc/en/legal_library/jp/legal_library_1994-07-15_1994-35.html
- http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/oeur/lxwejap.htm
- http://www.npa.go.jp/sosikihanzai/jafic/horei/Lawptcp.pdf
- http://www.servat.unibe.ch/law/icl/ja00000_.html
- http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html
- http://www.kantei.go.jp/foreign/constitution_and_government_of_japan/constitution_e.html
- http://Law for Prevention of Transfer of Criminal Proceeds (Law No. 22 of 2007)
- http://Penal Code of Japan (extract - provisions relating to Cybercrimes or computer crimes)
- http://Penal Code ( act 45 of 1907)
- http://www.cas.go.jp/jp/seisaku/hourei/data/PC.pdf
- http://en.wikipedia.org/w/index.php?title=Special3ASearch&search=criminal+law+of+japan
- http://www.npa.go.jp/sosikihanzai/jafic/horei/Lawptcp.pdf



# ИНТЕРНЭТИЙН ОРЧИН ДАХЬ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

***Магистрант: Ч.Жадамба***

Өмч нь бидэнд үнэхээр үнэ цэнэтэй гэж хэлэгдэхэд хүргэж буй тэрхүү хүчин зүйлсийн тухайд энэ нь яагаад тийм үнэ цэнэтэй болохыг лавлах, түүнийг танин мэдэх зүйн хэрэг юм. Ийнхүү сайтар ухан ойлгох ёстой өмчийн нэг төрөл бол оюуны өмч билээ. Оюуны өмч гэсэн ойлголтыг 1845 оны 10-р сард АНУ-ын Массачусеттын тойргын шүүх Дэволл болон Брауны хооронд үүссэн патентын хэргийг шүүх хэлэлцэх үеэр албан ёсоор хэрэглэсэн гэх мэдээ бий.[1] Шүүгч Чарльз Л.Вудбюри шүүхийн шийдвэр бичихдээ *«хэн нэгэн улаан буудай тарьж, түүнийг ургуулдаг шиг, хүний ашиг сонирхол, оюуны хөдөлмөр гэх мэт оюуны өмчийг бид мөн адил энэ арга замаар хамгаалж чадах байна ...»* гэсэн байдаг. Мөн энэ ойлголтыг Европт анхлан түгээн дэлгэрүүлсэн хүн бол Францын зохиолч А.Нион, тэрээр 1845 онд хэвлэгдсэн Droits civils des auteurs, artistes et inventeurs буюу Зохиолч, зураач, зохион бүтээгч зэрэг иргэдийн хууль ёсны эрх хэмээх номондоо «оюуны өмч» гэсэн нэр томъёог оруулжээ. Гэхдээ оюуны өмч гэх ойлголт 1967 онд Дэлхийн оюуны өмчийн байгууллага үндэс суурна тавих хүртэл маш явцуу хүрээнд хэрэглэгдэж байжээ.

Даяаршиж буй дэлхийн нэгээхэн тусгал нь цахим ертөнц юм. Цахим ертөнц өөрөө хил хязгааргүй асар том ойлголт юм. Үндэс угсаа, хэл соёл, орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр хэн боловч интернэтийн хязгааргүй орон зайд ажлаа явуулж, суралцаж, мэдээлэл солилцож, арилжаа наймаа эрхэлж, танилын хүрээгээ өргөжүүлэх зэргээр бүхнийг хийж байна. Тиймээс ч «интернэт»-ийг хүн төрөлхтний бүтээсэн технологийн хамгийн том дэвшил гэж хэлж болно. Ийнхүү бидний өдөр тутмын амьдрал цахим ертөнцөөс хамааралтай болохын хирээр интернэт орчинд хүний эрх, «зохиогчийн эрх»[2]-ийн зөрчил түгээмэл байна. Манай улсад гарч байгаа оюуны өмчийн эрх зүйн зөрчлийн дотор зохиогчийн эрхийн зөрчил багагүй хувийг эзэлж, жилээс жилд түүний эзлэх хувийн жин нь нэмэгдсээр байна. Өнөөдөр бусдын бүтээл болон тэдгээрийн хэсгийг хулгайлан хөнгөн ашиг хонжоо олох, контрафакц[3] /англ. counterfeiting/ бүтээгдэхүүнээр ихээхэн ашиг орлого ологчид буй болсон нь нууц биш юм. Иймд цахим ертөнц дахь зохиогчийн эрхийн асуудал нь зохиогчийн эрхийн үндсэн зарчим дээр суурилах ёстой.

Зохиогчийн эрхийн салбарын хувьд тухайн бүтээл биет байдлаар бүтээл болсон тохиолдолд эзэнд нь зохиогчийн эрхийг автоматаар үүсгэх хуулийн зохицуулалттай байна. Холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, конвенцийг харвал:

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зохиогчийн эрхийн бүтээл /объект/-ийг «зохиогчийн эрхийн бүтээлд

1 Агар-Эрдэнэ Г. Хувийн өмчийн онол. УБ., 2009 он.74х

2 "Зохиогчийн эрх" анх сэхэгдэж эхэлсэн цаг үе бол 15 дугаар зууны дунд үед буюу хэвлэлийн машин зохион бүтээсэн үе юм. Өмнө нь ном зохиолыг хувилж олшруулахад түвэгтэй, ихэвчлэн гар бичмэлээр цөөн хувь тараадаг байсан нь зохиогчийн эрхийн тухай асуудал байсны гол шалтгаан болж байлаа. Харин автомат хэвлэлийн машинаар бүтээлийг хэдэн зуун хувь олшруулах боломжтой болсноор эрх зүйн хувьд ямар нэгэн зохицуулалт хийх шаардлагатай болжээ.

3 Контрафакц нь нэгдүгээрт: зохиогчийн эрх зүйд зохиогчийн эрх буюу түүнд хамааралтай эрхийг зөрчих, хоёрдугаарт: зарим фирм нь шударга бус өрсөлдөх ба худалдан авагчдыг төөрөгдүүлэх зорилгоор бусад фирмийн олны танил болсон барааны тэмдгийг ашиглах явдал юм. /С.Нарангэрэл: Эрх зүйн эрх толь бичиг "Dictionary of Law". УБ.,2007 он. 263х./

агуулга, зориулалт, үнэ цэнэ, ач холбогдол, илэрхийллийн аргаасаа үл шалтгаалан оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг тооцно» гэж заажээ. Мөн Оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлаарх хэлэлцээрт «Зохиогчийн эрхийн хамгаалалт нь биелэлээ олсон онцлог зүйлд үйлчлэх бөгөөд санаа, арга, ажиллагаа, ажлын арга барил буюу математикийн ойлголтод үл хамаарна»,[4] Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцийн[5] 2 дугаар зүйлийн 2.1-д «утга зохиол, уран сайхны бүтээл» хэмээх нэр томъёонд бүтээсэн арга, хэлбэрийн үл хамааран утга зохиол, шинжлэх ухаан, уран сайхны бүх бүтээл хамааруулахаар заах *2.2-д* «... гэхдээ бодит хэлбэрээр илэрхийлээгүй аливаа нэгэн утга зохиол, уран сайхны бүтээл буюу түүний ямар нэгэн тодорхой хэсгийг хамгаалалтад авахгүй байхаар гэрээнд оролцогч улсууд дотоодын хууль тогтоомжоороо тогтоох эрхтэй» байна.

Колумбын их сургуулийн профессор Джейн С.Гинсбург /Jane C. Ginsburg/ зохиогчийн эрх зүйн амин сүнс нь зохиолч, уран бүтээлчид гэжээ.[6] Зохиогчийн эрх зүйн амин сүнс болсон зохиолч, уран бүтээлчид оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээлийнхээ хувьд эдийн /бүтээл ашиглах онцгой эрх/ болон эдийн бус баялгийн эрх[7] эдэлдэг. Бүтээл ашиглах онцгой эрх нь бүтээлээ гуравдагч этгээд ба түүнийг ашиглагчид нээлттэй болгохтой холбогдсон бүх асуудлыг бие даан шийдвэрлэх зохиогчийн боломж.[8] Энэ нь зохиогч бүтээлээ нийтийн хүртээл болгох тухай асуудлыг шийдвэрлэх төдийгүй ямар үеэс, ямар арга хэрэгслээр, ямар хэмжээ хязгаарт бүтээлийг нээлттэй, хүртээмжтэй болгох асуудлыг шийдвэрлэх явдал. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12-р зүйлийг авч үзвэл «Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ»,[9] мөн хуулийн 12.2-т заасны дагуу зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхэд зохиогч дараах үйл ажиллагааг зөвшөөрөх болон хориглох онцгой эрхийг хамруулсан. Энэ нь бүтээлийг хуулбарлах,[10] бүтээлийг нийтлэх,[11] бүтээлийг нийтэд түгээх,[12] үүсмэл бүтээл[13] болгон өөрчлөх, түрээсээр ашиглуулах зэрэг юм. Мөн хуулийн 12.3-т «зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг зөвшөөрлөөр, гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлнэ ...» хэмээн заасан. Хуулийн агуулгаас харахад зохиогчийн зөвшөөрлөөр л гагцхүү түүний бүтээлийг интернэтэд байршуулж болох нь харагдаж байна.

Оюуны бүтээлийг зохиогчийнх нь зөвшөөрөлгүй ашиглаж болох тохиолдлыг ДОӨБ-ын гишүүн улс болгон[14] өөр өөрийн үндэсний онцлогт тохируулан зохицуулалтыг хийсэн бөгөөд ДОӨБ-ын Утга зохиол уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенци болон Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар дараах гурван алхамаар шалгахыг зөвлөмж болгосон байдаг. Үүнд:

1. ашиг олох зорилгогүй байх;

2. бүтээлээс ашиглах хэмжээ болон ашигласан хэсгийн ач холбогдолтой шинж чанар;

3. ашигласан бүтээлийн үнэ цэнэ, ашигласан хэсгийн зах зээл дэх үр нөлөөг тооцох замаар зохиогчийн эрхийг зөрчсөн эсэхийг тогтоодог байна.[15]

4 Оюуны өмчийн эрхийн худалдааны асуудлаарх хэлэлцээрийн II хэсэг 9 дүгээр зүйл 9.2 дахь заалт

5 Монгол улс тус конвенцид 1997 онд нэгдэн орсон бөгөөд манай улсын хувьд 1998 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

6 http://ssrn.com/abstract_id=36848. *The Concept of Authorship in Comparative Copyright Law: Professor Jane C. Ginsburg, Columbia law School research paper.*

7 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 10.1 дэх заалт.

8 Нарангэрэл С. Тэмүүлэн Н. Зохиогчийн эрхийн тулгуур асуудал. УБ., 2008 он. 126х

9 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 12.1 дэх заалт.

10 "бүтээлийг хуулбарлах" гэж бүтээл, бүтээлийн хэсэг, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг нэг буюу түүнээс дээш тоогоор шууд буюу шууд бусаар, аливаа арга, хэлбэрээр олшруулах.

11 "нийтлэх" гэж бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг эрх эзэмшигчийн зөвшөөрлөөр, олон нийтийн хэрэгцээг хангахуйц хэмжээгээр олшруулж, нийтийн хүртээл болгох.

12 "нийтэд түгээх" гэж бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг хэрэглэгч өөрийн сонгосон цаг, газраас хүртэх боломжтой байдлаар утсан болон утасгүй холбоогоор нийтэд тараах.

13 "үүсмэл бүтээл" гэж өмнө бүтээгдсэн бүтээлд тулгуурлаж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, найруулах, орчуулах, хөрвүүлэх, хураангуйлах, эмхтгэх болон бусад хэлбэрээ өөрчилж, шинээр бий болгосон бүтээл юм.

14 АНУ-д Fair use, Европын холбооны гишүүн улсууд Limitation, exemption, Канадад fair dealing гэх мэт янз бүрийн нэр томьёо хэрэглэдэг боловч бүгд зохиогчийн бүтээлийг зөвшөөрөлгүй ашиглаж болох тохиолдлыг хуульчлан зохицуулсан байна.

15 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 24.2 дахь заалт.

Ийнхүү зохиогчийн зөвшөөрөлгүйгээр, түүнд хөлс төлөхгүйгээр ашиглаж болох тохиолдлыг хуульчилан баталгаажуулсан уламжлалт системийн гол зорилго нь зохиогч өөрийн бүтээлийг өмчлөх эрх болон тухайн бүтээлийг ашиглах нийтийн ашиг сонирхолыг тэнцвэржүүлэх явдал юм.

Интернэтээр зохиогчийн эрхийн зөрчил гардагийн тухайн үедээ хамгийн тод жишээ бол www.napster.com вэб сайтын үйлчилгээ байв.[16] Напстер (Napster нь P2P файлын төрөл бүхий мэдээллийн баазын систем. Энэ нь ямар нэгэн үнэ төлөлгүйгээр дуу хөгжмийг солилцох үйл ажиллагаанд тулгуурласан үйлчилгээ байв. Ингэж мэдээллийг цацахын онцлог нь аливаа хуулбар нь эх хувиасаа ялгагдахгүй, чанарын өндөр түвшинд хийгдэх боломжтой бөгөөд ямар нэгэн цаг, орон зайны хязгаар байхгүйд оршиж байна. Түүнээс гадна тэр хуулбар нь мянга ч биш, хэдэн арван мянга ч биш, хэдэн саяар тарах бололцоотой. Анх Ш.Фэннинг / Shawn Fanning /, Ж.Фэннинг / John Fanning /, С.Паркер / Sean Parker / нарын хамтрагчид АНУ-д 1999 оноос энэхүү сүлжээг ажиллуулж эхэлжээ.)-ын сүлжээнд бичигдсэн нэгэн мэдээлэлд «Материал баялагт хүрэх зам нь тохиромжтой, ямар нэг эндэл байхгүй бөгөөд уг материалыг далд хийн цоожилчхоогүй, эсвэл түүнийг хэрэглэхэд хэцүү л биш байвал маш олон хүмүүс зохиогчийнх нь хүсэл сонирхлыг дагаж мөрдөх хүсэл бага байдаг. Олж хэрэглэх явц нь хялбархан байгаа цагт зохиолчийн хүслийг нэг их ойшоодоггүй» гэжээ. Энэ нь оюуны өмчийн харилцаанд оролцогчдын эрхийг хамгаалах явдлыг юуны түрүүнд ёс суртахуунтай холбон авч үзэх явдал юм. Өмчийн харилцаанд оюуны өмчийн эрхийг зөрчих явдлын гол шалтгаан нь хүмүүс юмсыг хэрхэн бодож төсөөлөхөд, юу нь ёс суртахуунлаг болохыг тогтоох, шийдвэрлэхэд оршдог. Хүмүүс яагаад хулгай хийхээс татгалздаг вэ? Цагдаагаас, эсвэл хуулиас айсандаа болоод хулгай хийдэггүй гэвэл учир дутагдалтай. Хулгай хийдэггүйн учир нь хүмүүс ээжийнхээ өвөр дээр суудаг байсан балчир цагаасаа эхлэн нийгмийн ёс зүйн үндсэн зарчмуудад суралцаж эхэлдэг. Бидний ихэнх нь хүүхэд байхдаа оюуны өмч бол жинхэнэ өмч юм гэж заалгадаггүй учраас хожим түүнд анхаарлаа хандуулдаггүй байж болох юм.

Напстер хэмээх компьютерийн программыг зохиосон нь маш олон хөгжмийн зохиолч болон дуу бичлэгийн студийг шүүхэд нэхэмжлэл гаргахад хүргэсэн томоохон хэмжээний маргааныг үүсгэсэн юм.[17] Уг программ нь их хэмжээтэй файлыг нягтруулж хуулах технологийг бий болгосон гайхалтай оюуны бүтээл байлаа. Шүүх хурлын явцад Напстэр программыг зохиогч нь ашиг олох зорилго байгаагүй бөгөөд ямар ч үнэ хөлс аваагүй мөн амины хэрэгцээнд зориулан ашиглаж байсан хэмээх мэдэгдлийг хийсэн байна. Энэ нь зохиогчийн бүтээлийг түүний зөвшөөрөлгүй ашиглахыг зөвшөөрсөн уламжлалт зохицуулалтад хамаарах ёстой хэмээн тайлбарласан байна. Гэхдээ шүүхээс бусдын өмчлөх эрхэд халдаж зохиогчийн эрхээр хамгаалагдсан хөгжмийн бүтээлийг зөвшөөрөлгүй олон дахин хуулах боломжийг бүрдүүлж өгснөөрөө зохиогчийн бүтээлээ хувилах, олшруулах эрхийг зөрчиж байна хэмээн үзэж шүүхээс уг программыг ашиглахыг хориглосон байдаг. Энэхүү шүүхийн шийдвэр нь хуульч, судлаач, эрдэмтдийн дунд цахим хэлбэрт байгаа оюуны бүтээлд бидний уламжлалт зохиогчийн эрхийн зохицуулалт бус харин тусгайлсан эрх зүйн зохицуулалт, бие даасан хууль хэрэгтэй хэмээх маргааныг дэгдээсэн байна.

Үнэндээ интернэт орчинд зохиогчийн эрхийг Утга зохиол, уран сайхны бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенци; ДОӨБ-ийн Зохиогчийн эрхийн гэрээ; Тоглогч, дуу авиа бүтээгчдийн ДОӨБ-ийн гэрээгээр зохицуулдаг боловч зохицуулалтгүй үлдсэн харилцаа их байгаагийн улмаас зарим улс орон бие даасан хуулийг батлан хэрэгжүүлж эхэлсэн байна.[18] Тухайлбал, Унгар, Ирланд, Сингапур, Япон болон АНУ зэрэг улс орныг нэрлэж болох юм. Ялангуяа АНУ-ын 1998 оны «Мянганы цахим зохиогчийн эрхийн тухай хууль» буюу Digital Millenium Copyright Act /DMCA/, Европын холбооноос 2001 онд баталсан «Зохиогчийн

16 Монгол төр, эрх зүй /залуу судлаачдын индэр/ тусгай дугаар. 147х, Г.Сарнай "Зохиогчийн эрх зүйн зохицуулалтын үүсэл хөгжил" илтгэлээс ишлэв.

17 Дэлгэрэнгүй: A&M RECORDS, Inc. v. NAPSTER, INC., 239 F.3d 1004 (9th Cir. 2001

18 "Бизнесийн үйл ажиллагаа – Хүний эрх" сэдэвт хэлэлцүүлэг: Д.Эрдэнэчимэг Интернэт ба зохиогчийн эрх илтгэлээс ишлэв.

эрхийн директив»[19] нь ДОӨБ-ын зохиогчийн эрхийн гэрээ болон Тоглогч, дуу авиа үйлдвэрлэгчийн эрхийн гэрээг хэрэгжүүлэх үүднээс батлагдсан томоохон эрхийн актууд юм.

Эдгээр улсуудын интернэтийн орчинд зохиогчийн эрхийг хамгаалж буй хуулиуд нь оноосон нэрийн хувьд ялгаатай боловч агуулга нь дараах харилцаануудыг хамарсан байна. Үүнд: цахим ертөнц дэх зохиогчийн эрхийн хамгаалалт; цахим ертөнц дэх уран бүтээлчдийн эрхийн хамгаалалт; интернэт телевиз, нэвтрүүлэг, кино зохиогчдийн эрхийн хамгаалалт; интернэт үйлчилгээ үзүүлэгч компаниудын хариуцлагын асуудал; зохиогчийн эрхийн мэдээлэл; мэдээллийн нууцын асуудал; файл солилцох зэрэг асуудлууд юм.

Дээр дурдсан харилцаануудаас хамгийн их маргаантай асуудлын нэг нь интернэтэд байршуулсан зохиогчийн эрхийн зөрчилтэй бүтээлийн хувьд хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуудал юм. Зохиогчийн бүтээлийг олон нийтэд нээлттэй байршуулахдаа нэг сайтаас нөгөө сайтад дамжуулах, эсвэл хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн зүгээс контент байршуулах, бусад сайтын контентийг линкээр холбох явдал ихээр гардаг. Энэ нь интернэт үйлчилгээ түгээгчийн[20] тусламжтайгаар дамжуулагддаг байна. Ийнхүү интернэтээр оюуны бүтээлийг дижитал хэлбэрт оруулан нэгээс нөгөөд дамжуулах, хуулбарлах, түгээх, байршуулах, холбоход олон этгээд оролцдог тул интернэтийг «агуу том хувилах машин» гэж тодорхойлох явдал ч бий.

Интернэтэд оюуны бүтээлийг ашиглах явцад тухайн зохиогчийн эрхийн зөрчилтэй бүтээлийг байршуулсан этгээд хариуцлага хүлээх үү, эсвэл тухайн бүтээлийг байршуулах боломж олгосон этгээд хариуцлага хүлээх үү, эсвэл интернэтийн үйлчилгээ түгээгч этгээд хариуцлага хүлээх үү гэдэг асуудал тулгардаг. Энэхүү хариуцлагын асуудал нь олон шинжтэй юм. Учир нь интернэтэд хил хязгаар гэж үгүй бөгөөд энэ дэлхий нийтийг хамарсан асуудал болоод байна. Улс орон бүрийн өөр өөрийн онцлог болон уламжлал, заншлаас хамааран үүнийг зохицуулах эрх зүйн актууд өөр өөр байж болох боловч электрон худалдаа болон глобал сүлжээг хөгжүүлэхийн тулд хамтдаа нэг зарчмыг барих нь зүйтэй юм гэсэн хандлага давамгайлж байна.

Манай улсын хувьд интернэт орчинд зохиогчийн эрхийг хамгаалах асуудлаар ч юм уу интернэт үйлчилгээ түгээгчид хариуцлага тооцох тухай ямар нэгэн тусгайлсан хууль, хуульчилсан акт байдаггүй байна. Харин Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хуульд «интернэтийн үйлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан вэб хуудсанд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй»-г заажээ.[21] Түүнчлэн мэдээлэл, технологийн газрын даргын тушаалаар батлагдсан Цахим хуудасны агуулгын загварт «Цахим хуудасны сайтын агуулгыг ашиг орлого олохоос бусад зорилгоор үнэ төлбөргүй хэрэглэж болно. Вэб сайт дээр тавигдсан материалыг бусад мэдээллийн хэрэгслээр бүтнээр нь болон хэсэгчлэн хэвлэх тохиолдолд сайтын нэр ба зохиогчийн эрх эзэмшигч байгууллагын нэрийг дурдаж агуулгын утга санаа, судалгааны дүн зэргийг өөрчлөхгүй байна ....»[22] гэсэн байна.

Үнэндээ эдгээр заалтууд нь практикт хэрэгжих боломжтой юу гэдэг асуулт эндээс урган гарна. Жишээ нь интернэтэд тавигдсан оюуны бүтээлийн зохиогчийг тодорхойлоход хэцүү, түүнээс зөвшөөрөл авах боломж хаалттай /orphan works/[23] нөхцөлд тухайн бүтээлийг хэрхэн зохиогчийн зөвшөөрлөөр ашиглах вэ, цаасан хэлбэрээр гардаг аливаа сэтгүүл электрон хэлбэрээр дахин худалдагдахаар сайтад байршуулсан байх тохиолдолд интернэтэд байршуулахаар зохиогчийн зөвшөөрлийг аваагүй бол зохиогчийн эрхийн зөрчил гэж үзэх үндэстэй эсэх гэх мэт олон асуулт тулгарна.

19 Директив /directive/ Европын холбооноос батлан гаргасан бусад гишүүн улсууд заавал дагаж мөрдөх үүрэгтэйгээр батлагдсан хэм хэмжээ юм.

20 Интернэт үйлчилгээ түгээгч (online service provider) гэж и-мэйл үйлчилгээ, мэдээ, мэдээлэл, зугаа цэнгээний контент түгээгч, электрон худалдаа, электрон банк, электрон засгийн газар гэх мэт интернэт үйлчилгээ түгээгчийг ойлгоно.

21 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 25.1 дэх заалт.

22 Мэдээлэл, технологийн газрын даргын тушаалын хавсралт 1, Цахим хуудасны агуулгын загвар.

23 Өнчин бүтээл (orphan works) гэж зохиогчийн зөвшөөрлөөр уг бүтээлийг ашиглахыг хүссэн боловч тухайн бүтээлийн зохиогч болон байршлыг тодорхойлж чадахгүй байх нөхцөлийг ойлгоно. Дэлгэрэнгүйг www.law.berkekeley.edu.bclt

Дээр дурьдсан Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай хуулийн зохицуулалтаас харахад зөрчилтэй бүтээлийг байршуулсан сайтад уг бүтээлийг зөрчилтэй болохыг сануулахад арга хэмжээ аваагүй тохиолдолд уг хуульд заасан хариуцлага болох үйл ажиллагааг зогсоох хариуцлагыг хүлээлгэдэг байна. Үнэндээ зохиогчийн эрхийн зөрчилтэй бүтээлийг сайтад нэг цаг байршуулахад хэдэн мянган хувиар татаж, хувилах боломжтой. Тухайн сайтад арга хэмжээ авч арилгуулсан ч өөр өөр сайтуудад дараа нь тавигдах хэлбэрээр хэдэн саяар хуулбарлагддаг байна. 2012 оны 10 дугаар сард Оюуны өмчийн газар болон Харилцаа Холбооны Зохицуулах хороо хамтран «Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль»-ийн 12 дугаар зүйл, Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцуудыг зөрчсөн хууль бус үйлдэл гаргагасан гэж нэр бүхий 19 сайтын үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар хаасан арга хэмжээ[24] нь хир үр дүнтэй болох нь тодорхойгүй байна. Мөн зохиогчийн эрхийг хамгаалах уламжлалт зохицуулалтын улмаас Напстерийг хаасан нь технологийг дэмжих, оюуны бүтээлийг хүртэх хэрэглэгч буюу нийтийн ашиг сонирхлыг зохиогчийн эд хөрөнгийн эрхтэй тэнцвэржүүлэх зорилготойгоо хир нийцсэн бэ гэдэг нь мөн л тодорхойгүй байна.

24 Дэлгэрэнгүй: Харилцаа Холбооны Зохицуулах хороо, http://www.crc.gov.mn



# ҮНДСЭН ХУУЛИЙГ ШҮҮХЭД ХЭРЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

*Шихихутуг Хууль зүйн дээд сургуулиас уламжлал болгон зохион байгуулагддаг Багш, оюутны эрдэм шинжилгээний бага хуралд тэргүүн байранд шалгарсан илтгэл*

*Илтгэгч: Г.Гантогтох*
*Шихихутуг ХЗДС-ийн Бизнесийн эрх зүйн 4б ангийн оюутан*

## ИЛТГЭЛИЙН ТОВЧ АГУУЛГА

## СЭДЭВ: ҮНДСЭН ХУУЛИЙГ ШҮҮХЭД ХЭРЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

### ОРШИЛ ХЭСЭГ

1. Сэдвийг судлах шаардлага
2. Судалгааны зорилго
3. Судлагдсан байдлын хувьд
4. Уг илтгэлийн судалгааны арга нь
5. Судалгааны объект буюу судалгааны зүйлийн хувьд
6. Судалгааны практик ач холбогдол

### ҮНДСЭН ХЭСЭГ

1. Төрийн эрх мэдэл хуваарилалтын тухай ойлголт
2. Үндсэн хуулийн хяналтын загвар түүний ойлголт
3. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хоорондын хяналт

3.1 Гүйцэтгэх эрх мэдлийг шүүх эрх мэдэл хянах нь:

3.2 Хууль тогтоох эрх мэдлийг шүүх эрх мэдэл хянах нь:

4. Монгол улсын Үндсэн хууль-шүүх эрх мэдэл
5. Шүүхэд Үндсэн хуулийг хэрэглэх хууль зүйн боломжууд

### ДҮГНЭЛТ ХЭСЭГ

1. Дүгнэлт
2. Санал

### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## ОРШИЛ

**СЭДВИЙГ СУДЛАХ ШААРДЛАГА:** Аливаа хуулийг зөв хэрэглэх нь хэрэг маргааныг зөв зүйлчлэх хийгээд эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой ойлголт юм. Энэ үүднээс үндсэн хуулийг яаж хэрэглэх, хэн хэрэглэх хууль хэрэглэх ажиллагаанд эрх зүйн баталгаат орчин ямар байгаа талаар судлах Үндсэн хууль болоод бусад нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээнд дүн шинжилгээ хийж хуулийн маргаан бүхий зүйл заалтыг зөв хэрэглэх нь сонирхлыг татсан асуудал юм. Мөн хүний эрх, эрх чөлөө, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд байгаа хуулийн хэм хэмжээг улам төгөлдөржүүлэх, цаашлаад холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийг шүүхийн шатанд яаж хэрэглэх нь эрх зүйн тулгамдаж буй томоохон асуудал юм.

**СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:** Энэ үүднээс судлаач оюутны зүгээс дараах зорилгыг тавин судалсан болно. Үүнд:

1. Үндсэн хуулийг хэн хэрэглэх

2. Түүнийг шүүхийн шатанд яаж хэрэглэх

3. Холбогдох хуулинд дүн шинжилгээ хийж гаргалгаанд хүрэх

4. Цаашид ердийн шүүх Үндсэн хуулийг яаж хэрэглэх талаар чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон болно.

**СУДЛАГДСАН БАЙДЛЫН ХУВЬД:** онол болон практикийн хувьд шинэлэг судлагдсан байдал бага байгаа нь судлах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа юм.

**УГ ИЛТГЭЛИЙН СУДАЛГААНЫ АРГА НЬ:** Шинжлэх ухааны судалгааны микро харьцуулалтын хийгээд логикийн үндсэн арга, мөн структурализм /системчлэх/ болон дескриптив арга зүйг ашигласан болно.

**СУДАЛГААНЫ ОБЪЕКТ БУЮУ СУДАЛГААНЫ ЗҮЙЛИЙН ХУВЬД:** Үндсэн хууль болон шүүхийн тухай хууль, ИХШХШ тухай хуулийн 10 дугаар зүйл болно.

**СУДАЛГААНЫ ПРАКТИК АЧ ХОЛБОГДОЛ:** шүүгч, шүүхийн хараат бус байдал бүрэлдэх нь хүний эрх, эрх чөлөө хамгаалагдах гол нөхцөл мөн. «Шүүхийн хаалга» татах «шүүхэд дуудуулах»-аас айж эмээх, нэр алдар хугарсан мэт байсан үзэл сэтгэлгээнээс монголчууд өнөөдөр ангижирч «шүүхэд хандана» «шүүхээр заргалдана» гэж бардамхан бас элгэмсэг сэтгэлээр шүүгч, шүүхэд хандах болсон нь шүүхийг ойлгох, хүндэтгэх, эрх, эрх ашгийг нь хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг ухаарч мэдэж, хүртэж мэдэрсэн нь монголын эрх зүйн сэтгэлгээний том ялалт, асар их дэвшил мөн гэхээс өөр аргагүй. Шүүхийн үйл ажиллагааны дутагдал, доголдлыг өнөөдөр дээр дооргүй шүүмжилж байгаа нь нэг талаас түүний үнэ цэнийг мэдэрч улам сайжруулах гэсэн сэтгэлгээний илрэл гэж бас үзэж болно. Хараа хяналтанд өртөөгүй «хэн» болохоо харуулаагүй зүйлийг хүмүүс бас тийм амархан «оролдоод» байдаггүй.

Тийм ч учраас шүүхийн хэрэглэж буй хуулийг үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах түүнийг яаж хэрэглэх нь практик ач холбогдлыг илэрхийлнэ.

## НЭГ: ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ ХУВААРИЛААЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Францын соён гэгээрүүлэгч, философич, их сэтгэгч, хуульч Шарль Луи де Монтескье /1689-1755/ «Хуулиудын амин сүнс» номондоо «Засаглалын эрх мэдэл эртний ба дундад зууны үед байнга нэг гарт төвлөрч байснаас хүмүүсийн улс төрийн эрх чөлөөг хязгаарлаж байсан учир эрх мэдлийг хуваарилах ёстой»[1] гэж тэмдэглээд эрх мэдлийг: а) хууль тогтоох б) гүйцэтгэх в) шүүх эрх мэдэл хэмээн хуваах үзсэн нь «Засаглалын эрх мэдлийг хуваарилах онол» хэмээн нэрлэгдэх болж, 1787 оны АНУ-ын, 1791 оны Францын Үндсэн хуульд тусгалаа олсон төдийгүй, манай 1992 оны шинэ Үндсэн хуулийн гол тулгуур үзэл баримтлал болсон билээ.

Төр хүний эрхийг тогтоох бус хамгаалахад үйл ажиллагаа чиглүүлсэн, нийтлэг ашиг сонирхлыг эрх зүйт хуулиар зохицуулсан нийтийн /ард түмний/ чөлөөт сонголтоор тогтсон төрийг бий болгох нь хүн төрөлхтний туйлийн мөрөөдөл байсан, өдгөөч тийм л байна. Энэ зүгт хийсэн нэг том алхам бол «Төр дэх эрх мэдлийн хэт төвлөрлийг хүний эрхийг үндэс болгон сааруулах, хүний эрхийг хязгаарлагч улс төрийн байгууллагуудад ард түмний оролцоог хангах» буюу төрийн эрх мэдлийг хуваарилах /разделение властей/, /separation division of powers[2]/ онолыг боловсруулсан явдал юм.

Манай Улсын Үндсэн хуулийн 20-р зүйлд: *«Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална»*, мөн Үндсэн хуулийн 38-р зүйлийн 1-д: *«Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн»* Үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-д: *«Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ»*[3] . гэсэн заалтуудаас харахад ард түмнээс эх сурвалжтай төр нь ардчилсан, шударга ёсны зарчмыг агуулсан байх хувьдаа түүнээс салгаж болшгүйгээр сэтгэгддэг төрийн эрх мэдэл үндсэн хуулийн төвшинд хуваарилагдсан байна гэж хэлэх үндэстэй юм.

## ХОЁР: ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТЫН ЗАГВАР ТҮҮНИЙ ОЙЛГОЛТ

Үндсэн хуулийн хяналтын байгууллага нь Үндсэн хуульт ёсны чухал институт бөгөөд ардчилал, хүний эрх, үндсэн хуулийн баталгаа

1 Монтескье.Ш. О духе законов. Избранные произведения". Ном, М, 1985 он 289-р тал

2 Л.В. Тихомирова, М.Ю Тихомиров. Юридическая энциклопедия. М.2001.ст730. Д.Лундээжанцан.Монгол улс дахь төрийн эрх мэдэл хуваарилалт,2001,11дэх тал

3 Монгол Улсын үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн. www.legalinfo.mn

юм. Дэлхийн улс орнуудад Үндсэн хуулийн хяналтын 3 загвар оршдог[4]. Үндсэн хуулийг хэн хэрэглэх вэ? Хяналтын ямар загвараар хэрэгжүүлж буйгаас шууд хамаарна.

1. **Америкийн нэгдсэн улсын загвар** буюу ердийн шүүх. Дээд шүүх нь Үндсэн хуульд хяналт тавих. 1803 онд АНУ-ын дээд шүүхийн дарга /Жон Маршал/ нэгэн маргаантай хэргийг шийдвэрлэхдээ конгрессын баталсан ямар ч хууль, Үндсэн хуулийг зөрчин гарч болохгүй[5] гэж шийдвэрлэснээр энэхүү загвар бий болсон байна.

2. Австрийн загвар буюу Үндсэн хуулийн шүүх. Австри улс Үндсэн хуулиа 1920 онд боловсруулан батлахдаа Үндсэн хуульд хяналт тавьдаг, Үндсэн хуулийн шүүхийг баталсан. Хожим энэхүү загварыг 1951 онд ХБНГУ улам боловсронгуй болгон хөгжүүлсэн нь **Европын загвар болон хөгжжээ.**

3. Үндсэн хуулийн зөвлөл буюу Францын загвар. Францын загварын нэг гол онцлог нь хуулийн төсөлд урьдчилан хяналт тавьж, дүгнэлт гаргадаг байна. Австрали, АНУ, Канад зэрэг Англо-саксоны орнуудад ердийн шүүх нь Үндсэн хуульд тавих хяналтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн тусгай байгууллага оршдоггүй. Ийм загварын хяналт төдий л үр дүнтэй биш бөгөөд батлан гаргасан хууль Үндсэн хуультай нийцэж байгаа эсэхэд хяналт тавих ажиллагаа Дээд шүүх хүртэл олон үе шатыг дамжиж, багагүй хугацаа зардаг учраас энэхүү хяналт хууль зүйн практикт өргөжихгүй байна.

Үндсэн хуульт төр - хууль тогтоогчоос батлан гаргаж байгаа хууль, эрх зүйн актууд Үндсэн хуулинд нийцсэн эсэхийг хянадаг, тэдгээрт иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаар, иргэд болон төрийн байгууллагуудын хооронд гарсан маргааныг авч үзэх үндсэн хуулийн шүүхийн институттэй байх явдлыг шаардана.

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульт төр, Үндсэн хуульт ёсны дээд илэрхийлэл болж байдаг ба үүнийхээ улмаас зөвхөн үндсэн хуулийг мөрдөж байгаа байдлыг хянадаг төдийгүй, мөн хамгийн тулгуур эрх зүйг хуулийн үг хэллэгийн оноолтын илэрхийллээс нь үл хамааран тайлбарлаж байдаг болохоороо амьд Үндсэн хуулийн эрх зүйг бүтээгч болж байдаг[6].

Үндсэн хуульт ёсны европ маягийн хэлбэр нь үндсэн хуулийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг тусгай шүүхэд илүү ач холбогдол өгдгөөр тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, үндсэн хуулийг болон түүний эрх зүйг тусгай байгууллага, эрх баригчдын батлан гаргаж байгаа актуудаар түүнийг зөрчихөөс хамгаална.

1803 оноос эхлэн АНУ-ын дээд шүүх ердийн хуулиудыг үндсэн хуулинд нийцэж буй эсэхийг хянаж эхэлснээр хүн төрөлхтний төр ёсны түүхэнд том ялалт, агуу дэвшил бий болсон билээ[7]. Ийнхүү үндсэн хуульт төр ёсны анхны загвар илэрсэн түүхтэй. Энэ түүхэн нөхцөлд төв европт үндсэн хуульт төр ёсны үзэл санаа дэлгэрсэн хэдий ч улс төрийн практикт хэрэгжсэн нь харьцангуй хожуу юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиа хамгаалж, бусад ердийн хуулиудыг түүнд нийцэж байгаа эсэхийг албан ёсоор хянан шийдвэрлэдэг субъект төрж гараагүй байв.

Харин манай улсын хувьд 1992 оны шинэ Үндсэн хуулийн Тавдугаар бүлэгт Үндсэн хуулийн хяналтын институтыг /цэцийг/ төрийн эрх мэдлийн тогтолцоонд байршуулж, улмаар Монгол улсын «Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг» батлан гаргаснаар Үндсэн хуулийн хяналтын бие даасан байгууллагын улс төр, эрх зүйн статусыг албан ёсоор анх бий болгосон байна. Үндсэн хуулийн тэргүүлэх ач холбогдлыг улс төр, хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлдэг дагнасан шүүхийн тогтолцоотой болж, парламентын дур зоргоос хүний эрх, эрх чөлөө, үндсэн хуулийн үзэл санааг хамгаалах явдал мөн.

4 www.legaledu.mn
5 Marbury v. Madison 1 Granch 137, 177-2.law.Ed.U.S.60.73 zit nach: Velassungsgerichtsbarkeit in Westeuropa T. 1.S.30.-31 /дам ишлэв/
6 Н.Лүндэндорж Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага 2002 он, 126 дахь тал
7 Н.Лүндэндорж Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага 2002 он, 128 дахь тал

## ГУРАВ: ХУУЛЬ ТОГТООХ, ГҮЙЦЭТГЭХ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХООРОНДЫН ХЯНАЛТ

Төр ба хүний эрхийн тэнцлийг хангах үндсэн хуульт ёс өдгөө нэгэнт түгэн тархжээ. Тодруулбал, үндсэн хуульт ёсны агуулга болсон эрх зүйт ёсны үзэл баримтлал ёсоор хүний эрхийн зааг хязгаараар төрийн үйл ажиллагаа өрнөж, хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хуулийн журамд, гүйцэтгэх эрх мэдэл нь хуульд, шүүх эрх мэдэл нь эрх зүйд захирагдаж ажиллах учиртайг чухалчилдаг[8].

Учир иймээс Үндсэн хуульд дахь хэн ч өөрчилж зөрчиж боломгүй дэг журамд парламент захирагдаж, хууль тогтоож, тэр хүү хуульд үндсэн хуулийн шүүх дээд хяналтыг хэрэгжүүлж, парламентын хуулийн биелэлтийг засгийн газар хангуулж, парламентийн болон засгийн үйл ажиллагааг шүүх хууль хэрэглэж хянах болсон нь эрх зүйт ёсны тод илрэл мөн.

Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлүүд нь харьцангүй бие даасан байхаас гадна төрийн засгийн эрхийг урвуулан ашиглах, дураар авирлахаас сэргийлэх үүднээс бие биеээ тогтоон барих, харилцан хяналт тавих, хамтран ажиллах эрмэлзэл бүхий байхаар хуваарилагдсан байдаг нь эрх зүйт ёсны үүднээс харахад бүрэн биелэлээ олсон гэж үзэж болохоор байна.

### 3.1 Гүйцэтгэх эрх мэдлийг шүүх хянах нь:

Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т «...эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно.» гэж заасны дагуу Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдаж «Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль бус шийдвэрт хяналт тавих механизм бий болсон байна»[9].

1994 оны 5 дугаар сарын 9-ний өдөр «Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль» батлагдаж, шинэ Үндсэн хуулиар тодорхойлогдсон «ерөнхий харъяалал»-ын шүүхийн иргэний хэргийг хянан шийдвэрлэх журам тогтлоо. Энэ хуулийн 12 дугаар бүлэгт «Гомдлоор авч хэлэлцэх хэрэг»-ийг тодорхойлсон байх бөгөөд ингэснээр зарим талаар нийтийн захиргаанд тавих шүүхийн хяналтыг шинэчлэн тогтоосон төдийгүй захиргааны байгууллага, албан тушаалтан бус захиргааны «акт»-аар баримжаа болгон шүүхийн хяналтанд оруулжээ.

Улмаар эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу шүүх эрх мэдлийн салбарт тодорхой хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлага бий болж 2000 оны 5 дугаар сарын 4-ний УИХ-н 39 дүгээр тогтоолоор «Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө» батлагдан гарав. Мөнхүү төлөвлөгөөний стратеги зорилтуудын нэгд «Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль бус шийдвэрт хяналт тавих хяналтын механизм бий болгох» зорилтыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнд Захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулж үйл ажиллагааг нь төлөвшүүлэх ажил багтжээ.

Ийнхүү дагнасан шүүх хууль зүйн үндэслэл, үндэсний эрх зүйн тогтолцоог шинэтгэх хөтөлбөр, шүүх эрх мэдлийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр «Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль» батлагдан гаржээ. Ингэж шүүх нь шинэ Үндсэн хуулиар парламент болон засгийн явуулж буй үйл ажиллагааг хянах эрх зүйт төрийн загварт зайлшгүй оршин байх «өөрийн» жинхэнэ эрхээ олж авсан байна. Дараах захиргааны байгууллага, албан тушаалтанд хяналт тавих боломжийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд зохицуулсан байна[10]

8 Монголын шүүхийн товчоон 2011 он (Эрдэм шинжилгээний өгүүллүүд) / Шүүх Монгол улсын дөрөв дэх удаагийн үндсэн хуульд туссан нь Ж.Наранпүрэв/

9 УИХ-н 2000 оны 5 дугаар сарын 4-ны 39 дүгээр тогтоол / "Монгол улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө" / 1998 оны 1 дүгээр сарын 22 ны өдрийн УИХ-н 18 дугаар тогтоолоор "Монгол улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр" батлагдаж, түүний 27 дугаар зүйлд "Захиргааны хэргийн шүүхийн тогтолцоог шинээр байгуулах үүргийг УИХ, УДШ, Засгийн газарт хариуцуулжээ." Мөнхүү тогтоолд эрүү, иргэний салбар эрх зүй болон тэдгээрийн процесст хамаарах зарим хэм хэмжээг шинэтгэх тухай заасан бөгөөд үүнтэй уялдуулан дагнасан шүүхийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх тохироо бүрджээ.

10 4.1.2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн / Ерөнхий сайд, сайд/;
4.1.3.Монгол Улсын яам;
4.1.4.Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
4.1.5.Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
4.1.7.Монгол банк;
4.1.8 Санхүүгийн зохицуулах хороо;
4.1.9.аймгийнхарьяаболонхарьяабусзахиргааныакттаргадагбиедаасанагентлаг, түүнтэйадилтгахгазар, зөвлөл, товчоо, төв, сангэрэгбайгууллага;

Ийнхүү гүйцэтгэх засаглалд шүүхийн хяналт тавих боломж хуульчлагдсан боловч хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эд хөрөнгө, эрх мэдэл, нэр төр захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас хохирсоор байхуу аль эсвэл?.....гэдэг асуулт зүй ёсоор урган гарна.

Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл үйл ажиллагааныхаа үр дүнг ард түмэнд болон түүний төлөөлөгчдийн байгууллагад тайлагнадаг бол шүүх эрх мэдэл шударга ёсны үнэт зүйл, өндөр стандартад тулгуурлан хариуцлагаа өөрөө хүлээдэг[11].

Монгол Улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг шүүхээс өөр ямарч субъект эрхлэх ёсгүй гэдгийг тогтоосноор шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс бүрэн тусгаар гэдгийг заасны зэрэгцээ ямарч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглож, шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулахаар заасан нь шүүх эрх мэдэл, шүүхийн бие даасан байдлын амин сүнс мөн.

Үндсэн хуулийн дагуу бие дааж бусад эрх мэдлээс хараат бус байх төдийгүй тэдгээрийг хуулийн хүрээнд хянах, эрх мэдлийн хувьд тэнцвэртэй, аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх бүрэн эрх бүхий эрх мэдлийн зохион байгуулалт, тогтолцоо болсон юм.

### 3.2 Хууль тогтоох эрх мэдлийг шүүх эрх мэдэл хянах нь:

Монгол улсын Үндсэн хууль цэц ба хууль тогтоох эрх мэдэл / Улсын их хурал/

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ч Улсын Их Хурлын хууль болон бусад шийдвэрийг хянадаг бөгөөд 1992 онд байгуулагдсанаас хойш 2011 хүртэл нийт 1425 өргөдөл[12], мэдээлэл, хүсэлт, гомдол хүлээн авсан авсны 711 нь буюу 49% нь Улсын Их Хурлын гарсан хууль, тогтоолтой холбоотой байсан. Үүнээс маргаан үүсгэн дүгнэлт гаргасан 102 буюу 83%, тогтоол гаргасан 38 буюу 95% байна[13].

Энэ тоо баримтаар «шүүх» (УДШ, Ердийн харьяалалын шүүх) яаж хянаж байна гэдгийг анхаарч судлахад:

Үндсэн хуулийн цэц байгуулагдсан цагаас хойш 2012 оны хугацаанд нийт 129 маргаан шийдвэрлэсэн бөгөөд эдгээрээс зөвхөн 5 маргааныг төрийн байгууллага, албан тушаалтын хүсэлтээр /УДШ-3, Ерөнхийлөгч 2/ үлдэх 124 хэргийг иргэдийн өргөдөл мэдээллээр хянан шийдвэрлэсэн байна. (Иргэнд: Ламжав, Лхагважав, С.Нарангэрэл гэх мэт цөөн тооны иргэд хамаарна.)

Нийт шийдвэрлэсэн хэрэг маргааны 20 нь буюу 19.3 хувь нь ИХШХШ тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зүйл заалт Үндсэн хууль зөрчсөнтэй холбоотой маргаан эзэлж байх бөгөөд эдгээрээс 9 нь Үндсэн хууль зөрчсөн нь Үндсэн хуулийн цэцээр тогтоогдсон байна. Энэдээс дүгнэхэд Төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа Үндсэн хуулийг дээдлэх зарчмыг чанд мөрдөж ажиллах алдаа дутагдлыг олж харах нь: Эрх зүйт ёсыг цаасан дээр биш, харин бодит байдал болгоход томоохон алхам хийх болно.

## ДӨРӨВ: МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ-ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ

Эрх зүйн үндэслэлийг дэлгэрүүлбэл,

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.-т «Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.» Монгол Улс нь өнөөдрийн байдлаар шүүгчийн хараат бус байдлыг субъектив буюу хүний хүчин зүйлээс

4.1.10.аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
4.1.11.аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
4.1.12.улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
4.1.13.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
4.1.14.төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
4.1.15.сум хийдийн захиргаа;
4.1.16.шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

11 Монголын төр эрх зүй сэтгүүл 2006/2 Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал Монгол улсын дээд шүүхийн шүүгч Л.Еэмбаа

12 Үндсэн хуулийн цэцийн архивийн баримтаас шүүлтэж авав.

13 Монгол улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд ( эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл ) 2011 он / "Монгол улсын үндсэн хуулийн процессын эрх зүйн хөгжлийн чиг хандлага" Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Ханнс-Зайдлын Сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн Шинжлэх ухааны доктор Ц.Сарантуяа/

хамаарах, түүнд автах, өртөж болзошгүй талаас нь тодорхойлж баталгаажуулсан байх агаад харин бусад хүчин зүйлүүдийг төдий л тодорхой «Үндсэн хуульчлаагүй» байна. Энэ нь судлаачийн зүгээс авч үзвэл дараах учир шалтгаантай байхыг үгүйсгэхгүй Үнд: Үндсэн хуульд шүүгчийн хараат бус байдлыг «баталгаа» төдийгөөр тодорхойлсон нь цаашид түүнийг «парламент Үндсэн хуульд нийцүүлэн хууль батлах арга замаар мөнхүү зарчмыг дэлгэрүүлэх» хандлагатай байхыг үгүйсгэхгүй. Тодруулбал, Үндсэн хууль нь хэдийгээр хоёрдмол утга агуулгагүй, энгийн ойлгомжтой үг хэллэгээр бүтээгдэх хууль зүйн техникийн шаардлага тавигддаг хэдий ч үндэсний эрх зүйн тогтолцоог өөр хооронд нь нэгдмэл байдлаар бүрдүүлэх, Үндсэн хуулийн зорилгыг бодит байдал болгох, маргааныг эцэслэх зэрэг шаардлагын үүднээс түүнийг тайлбарлах шаарлага үүсдэг. Эрх зүйт төрийн загвар бүхий улс орнуудад дээрх ажиллагааг үндсэндээ дараах хоёр аргаар шийдвэрлэж байна[14]. Дээрх зарчмын баталгааг Шүүхийн тухай болон процессийн хуулиуд, өөр бусад хууль тогтоомжуудыг дараа дахин шинэчлэн найруулах, нэмэлт өөрчлөлт оруулах явцдаа дэлгэрүүлэн тодорхойлно гэдэгт эргэлзэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.3.-т «Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй» гэжээ.

Энэхүү заалт нь үндсэн хуульд тусгагдаагүй байсан бол Монгол Улсад өнөөдөр эрх зүйт төр бус харин хуульт төр оршин тогтнох байлаа. Учир нь хуулийг бүхнээс ариун дээд үзэж, түүнийг ямар ч шалтгааны үл харгалзан биелүүлэх байсан агаад энэ нь үндсэндээ хуулиар далайлгаж дээрэм тонуул хийхтэй «агаар» нэг юм.

Шууд хэлбэл, Парламентийн хууль тогтоох эрх хязгааргүй үйлчилж, «бүхнийг хуулийн аргаар» гэх зарчим хэрэгжих аюултай юм.

14 НЭГДҮГЭЭРТ: Парламент Үндсэн хуульд нийцүүлэн хууль тогтоох арга замаар тухайн үндсэн хуулийн заалтыг нэмэн дэлгэрүүлж тайлбарлах
ХОЁРДУГААРТ: Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, тэрхүү шийдвэрээрээ Үндсэн хуулийн тухайн заалтыг тайлбарлах гэсэн аргууд нийтлэг оршиж байна.

Дээрх заалтууд нь шүүх, шүүгчийн үйл ажиллагааны хараат бус байдлын эрх зүйт ёсны шаардлагыг баталгаажуулсан байх төдийгүй «хууль дээдлэх» зарчмаас ч ангид байлгах Үндсэн хуулийн баталгаа юм. Нөгөөтэйгүүр дээрх заалт нь парламентыг Үндсэн хуулийн дэг журамд захируулах, түүнд шүүх хяналт тавьдаг байх боломжийг бүрдүүлж өгснөөрөө шүүх, шүүгчийг мэргэжлийн үүднээс хууль хэрэглэдэг байх мэргэжилтний өндөр үүрэг хариуцлагыг давхар нэмэгдүүлсэн хэрэг мөн.

## ТАВ: ШҮҮХЭД ҮНДСЭН ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН БОЛОМЖУУД

Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д «Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийг хэрэглэнэ» мөн хуулийн 12.3.-д «Тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүх тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, саналаа Улсын дээд шүүхэд оруулна»

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д: «Шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр бусад хуулийг хэрэглэнэ».

10.2.-д: «Хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана».

10.4.-д: «Тухайн маргаантай харилцааг зохицуулсан хууль байхгүй бол шүүх төсөөтэй харилцааг зохицуулж байгаа хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ. Хэрэв тийм хууль байхгүй бол шүүх Үндсэн хуулийн агуулга, ерөнхий үндэслэл, үзэл санаанд нийцүүлэн шийдвэрлэнэ» гэсэн нь дээр дурьдсанчлан шүүх, шүүгчийн үйл ажиллагааг «хуульт төрөөс» хараат бус байхыг баталгаажуулж,

Үндсэн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-д: заасчаар «Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр бүрнээ нийцсэн байвал зохино» гэсэн төрийн эрх

мэдлийг Үндсэн хуулиас хараат болгох агуулгын бодит илрэл юм. Мөн шүүгчийн хэрэглэх хууль дээрх Шүүхийн тухай хуулийн холбогдох заалт болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтаар тодорхой харагдаж байна.

Эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхээс тодорхой хэрэг маргааныг хянан хэлэлцээд гаргаж гарж байгаа шүүхийн шийвэрийн тогтоох хэсэгт хуулийн нэр болон тодорхой зүйл заалтыг удирдлага болгон заасан байдаг. Энэ удирдлага болгосон зүйл заалт Үндсэн хуулийг зөрчсөн байдаг бол парактикт энэ асуудлыг анзаарахгүй хэрэг маргааныг хянан хэлэлцэж иргэдийн эрх, ашиг сонирхол болоод хууль тогтоох эрх мэдэлд хяналт тавих арга зам сул байгааг харуулж байна.

**Тохиолдол 1**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл. Хурлын тогтоол 25.4.Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, *Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно. 25.5.Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй.* Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хавсаргав (Дүгнэлт 2009.03.11: Тогтоол 2009.05.20)

***Жишээ нь: 2005 онд баталсан Баянгол дүүргийн ИТХ-ийн тогтоолыг Засгийн газрын шийдвэрт нийцээгүй гэсэн үндэслэлээр Нийслэлийн ИТХ-аас хүчингүй болгосон. Дүүргийн ИТХ-ын шийдвэрийг дээд шатны хурал хүчингүй болгосон нь үндэслэлгүй хэмээн Баянгол дүүргийн ИТХ маргалдсан.***

Үндсэн хуулийн цэц байгууллагдан үйл ажиллагаа явуулсанаас хойш Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлийн 1-д заасан эрхийн дагуу Иргэний хуулийн 154.3., 154.4., 174.2., 174.3., Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11.6., 19.8[15].,Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225.5., 233.2., 302.4., 304.4., 309.4., 346.4.,-т заасан заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байгаа эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасныг Үндсэн хуулийн цэц хүлээн зөвшөөрөн дээрх хуулийн заалтуудыг хүчингүй болгосон.[16]

**Идэвхгүй хяналт хэрэгжиж буйн шалтгаан нөхцөл нь:**

- Үндсэн хуулийн шууд бус хяналт нь тухайн тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэрэглэх хуулийн хүрээнд яригддаг тул нийгмийн харилцааны объектив нөхцөл бүрдээгүй байж болно.
- Шүүх тодорхой төрлийн хэрэг, маргааныг тухайн тохиолдолд амжилттай, үнэн зөв шийдвэрлэхэд анхаарч хэм хэмжээний шууд бус хяналт хэрэгжүүлэх талаарх Үндсэн хуулийн чиг үүргээ орхигдуулсан байж болох
- Шүүхэд хэвшин тогтсон хуулийг төсөөтэй хэрэглэх практикийн нөлөөлөл хүчтэй байгаа зэрэг болно

**Нийгмийн харилцааны объектив нөхцөл:**

2007 онд Улсын дээд шүүхээс хэвлэн гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар /албан бус/-т хуулийн 10 дугаар зүйлийг тайлбарлахдаа «Шүүх нь өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлж, иргэний хэргийг хянан шийдвэрлэхдээ эрх зүйн хэм хэмжээний актуудын хууль ёсны байдлыг хянах үүрэгтэй. *Шүүх нь тэдгээрийн Үндсэн хууль, хуульд нийцээгүй байдал илэрвэл, хууль зүйн дээд хүчин чадалтай актыг хэрэглэнэ. Хэрэв шүүхийн хэрэглэж буй хуулиас өөр тухайн хэрэг, маргааныг зохицуулсан хууль байхгүй* тохиолдолд уг хууль Үндсэн хуультай нийцэхгүй бол шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана» хэмээжээ. Хэрэв хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж үзвэл шүүгч энэ талаар Улсын дээд шүүхэд санал гаргах нь шүүгчийн хувьд эрх үү, эсхүл үүрэг үү?

15 ИХШХШт хуулийн тайлбар 2007 он
16 www.conscourt.gov.mn

Ц.Амарсайхан: Шүүх засаглал:Онол практикийн зарим асуудал өгүүлэл

Эрх зүй, хууль хоёрын харилцан шүтэлцээ буюу эрх зүйн төрийн агуулгын шинж нь эрх зүйн онолын гол асуудал бөгөөд шүүх засаглалын зарчмын асуудалтай салшгүй холбоотой юм. Учир нь хуулиудын эрх зүйн агуулгыг хянах үүргийг эрх зүйт төрд гагцхүү шүүх засаглалд эдлүүлдэг билээ.[17]

Бидний туулж ирсэн түүхэн замналын үр хөврөл болон шүүхийн ажиллагаан дахь зарим дутагдалаас шалтгаалан шүүгчдээс аливаа хуулийн сайн муу, давуу ба сул талыг ялгаж салгахгүй хууль бүхэн ариун нандин шүтээн байх ёстой гэсэн зарчмыг баримтлахыг шаардах болжээ.

Үүнийг тодруулбал RULE OF LAW-эрх зүйт ёс

RULE BY LAW-хууль дээдлэх зарчим хоёрыг ижил утгаар ойлгож тайлбарлах явдалтай салшгүй холбоотой юм. Энэ хоёр ойлголт нь асар ялгаатай ойлголт юм.

Тухайлбал: хууль дээдлэх зарчим нь: 1. Харилцааг хуульчилна. 2. Маргааныг шийдвэрлэх эх сурвалж нь хууль байна. 3. Хүчин төгөлдөр хуулийг бүх нийтээр, албадлагын арга хэрэгслийн дор хэрэгжүүлдэг байдлаар илэрдэг.

## ДҮГНЭЛТ

Илтгэлийнхээ зорилготой уялдуулан эцэст нь дүгнэхэд, Монгол Улсын Үндсэн хууль нь Монгол Улсад анх удаа Үндсэн хуульт ёсны үнэт зүйлс болох хүний эрх, эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёс жинхэнэ утгаараа хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлж өгчээ. Гэхдээ дээр дурдсан зарим үзэл баримтлал, хэм хэмжээний алдаанаас болж Эрх зүйт ёсны цаашдын хөгжил, төлөвшилд бэрхшээл учирч болох юм.

1. Үндсэн хуулийн дархлаа хамгаалалтыг бий болгох талаар Үндсэн хуулийн цэцийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж, нэвтрүүлэх

2. Төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа Үндсэн хуулийг дээдлэх зарчмыг чанд мөрдөж ажиллаваас бид Эрх зүйт ёсыг цаасан дээр биш, харин бодит байдал болгоход томоохон алхам хийх болно.

3. Шүүхийн үйл ажиллагааг тунгалаг болгох аливаа хэрэг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэх хуулийг зөв хэрэглэх, тайлбарлахад шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг маш тодорхой болгох шаардлагатай байна.

4.Шүүхийн шүүн таслах ажиллагааны алдаа зөрчлийг цаг тухайд нь илрүүлэн арилгах, шүүхийн алдаанаас шүүгдэгч, хохирогч, зохигчид болон бусад иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хууль бус хохирол учрах боломжийг хаах

Ердийн шүүхийн Хэрэглэх хууль нь Үндсэн хууль болон тухайн улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг сэтгэхүйн түвшинд шалгах шүүгчдийн мэдлэгийг дээшлүүлэх

5.ИХШХШ тухай хуулийн 10 дугаар зүйлийн *10.2-т «Хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж шүүх үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргана» гэж заасны дагуу анхан болон давж заалдах шатны шүүх хүчин төгөлдөр аливаа нэг хууль Үндсэн хуультай нийцэхгүй байна гэсэн үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тохиолдол гараагүй байгаа нь хууль тогтоох эрх мэдэлд шууд бус хяналт тавих шүүгчдийн мэдлэг чадвар сул байгаа тул үүнийг судлаж сургалт, семнар зохион байгуулах шаардлага байна.*

**«Сайн үйлс дэлгэрэх болтугай»**

17 Ц.Амарсайхан: Шүүх засаглал:Онол практикийн зарим асуудал өгүүлэл "Хууль дээдлэх ёс" сэтгүүл 2004 он №4 (07)

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ:


**Хууль, тогтоомж:**

1. Монгол улсын үндсэн хууль 1992 он
2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
3. ИХШХШ тухай хууль 1994 он
4. ИХШХШ тухай хууль 2002 он
5. Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2002
6. Шүүхийн тухай хууль 2002
7. Монгол улсын засгийн газрын тухай хууль 1993 он
8. Монгол улсын их хурлийн тухай хууль 2006 он
9. УДШ-н тогтоол 2006 он №12
10. УДШ-н тогтоол 1993 он №55

**Ашигласан ном, сурах бичиг:**

1. Лүндэндорж. Н Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага 2002 он
2. Лүндээжанцан.Д Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт 2001 он
3. Монгол улсын үндсэн хуулийн тайлбар 2009 он
4. ИХШХШ тухай хуулийн тайлбар 2007 он
5. Сарантуяа. Ц Үндсэн хуулийн процессийн эрх зүй 2005 он

**Сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүлэл:**

1. Монголын шүүхийн товчоон ( эрдэм шинжилгээний өгүүлэлүүд) 2011 он
2. Монгол улсын эрх зүйн хөгжлийн асуудлууд ( эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл) 2011 он
3. Үндсэн хуулийн цэц: илтгэл өгүүлэлийн эмхэтгэл 2007 он
4. «Шихихутуг» сэтгүүл 2004 он

*ОХУ-ын Шинжлэх ухааны Академийн Социологийн институтад тавьсан илтгэл*

# О ПРАВОВОМ РЕГУЛИРОВАНИИ СОЦИОКУЛЬТУРНЫХ ПРОЦЕССОВ В УСЛОВИЯХ МОДЕРНИЗАЦИИ МОНГОЛЬСКОГО ОБЩЕСТВА

*Д. Лундээжанцан (Монголия)*
*доктор юридических наук, профессор*

Прежде всего хочу поблагодарить организаторов симпозиума и руководство Института социологии Российской академии наук за приглашение на столь представительный научный форум.

Я хотел бы присоединиться к обсуждению темы цивилизационных проблем модернизации переходного общества, формирования новой социальной культуры, нового образа жизни и новых социальных ценностей и идентичностей в России и Монголии, а также в других постсоциалистических странах Европы и Азии. И выделить в этой теме, прежде всего, вопросы правового регулирования при формировании новой социальной структуры и социокультурной идентичности в условиях модернизации монгольского общества.

Мне хотелось бы обратить ваше внимание на наш совместный труд, изданный буквально на днях на монгольском языке под названием «Переходное общество: вопросы модернизации и цивилизации (на примере России и Монголии)»[1]. Этот труд является результатом исследовательской работы совместного творческого коллектива российских и монгольских ученых по вопросам идентичности и особенностей модернизационных процессов монгольского и российского обществ, формирования их новой социальной структуры и социальной культуры.

Хочу выразить благодарность всем российским и монгольским ученым — членам совместного проектного «экипажа» этого коллективного фундаментального труда. Хотелось бы особо отметить заслугу российской стороны, прежде всего - многоуважаемых Горшкова Михаила Константиновича, Голенковой Зинаиды Тихоновны и Александра Сергеевича Железнякова.

Наш творческий коллектив рассмотрел проблемы модернизации и некоторые проблемы цивилизационной идентичности монгольского и российского общества. Проанализированы характерные особенности содержания и сущность процесса социального обновления на основе социологической теории и практики, раскрыты тенденции и взаимозависимость всех элементов целостной системы общества в условиях его кардинального обновления.

Как юристу, мне особенно близка тема обоснования целесообразности и даже необходимости совместного использования методов социального и юридического анализа в процессе социальной модернизации общества. Это возможно при четком определении некоторых основных понятий и категорий, основных характеристик социологического и юридического анализа, касающихся социокультурных аспектов развития социальной структуры нынешнего общества.

Эти характеристики тесно связаны с задачей рассмотреть эффект сохранения и преобразования отдельных элементов общества при его социокультурной и социоструктурной трансформации. Тем более, что в процессе развития существуют составляющие с устойчивым канонизированным типом

1 Шилжилтийн нийгэм: шинэтгэл, соёл иргэншлийн асуудлууд (Орос, Монголын жишээгээр авч үзэх нь).Тослийн багийн ахлагчид М.К. Горшков, Д. Лундээжанцан. Эмхтгэгч, редакторууд А.С. Железняков, Ч. Даваадаш. Улаанбаатар, 2012.

старой структуры. Они обладают свободой видоизменения.

Авторы вышеупомянутого нашего труда это доказывают и рассматривают общие положения и теоретический материал, а точнее теорию стратификации, социальные классы, социальные слои, проблемы стратификации и дают определения понятий, соответствующих целям и задачам выбранной темы.

Авторы считают, что формирование новых социальных слоев, их отношений в целом имеют обьективный характер и являются целенаправленным (в социальном и политическом смысле) явлением. В этой связи одним из важнейших способов познания общества является описание его структуры.

Социальная структура - своего рода каркас всей системы общественных отношений, распространяющийся на совокупность экономических, социальных и политических институтов, организующих общественную жизнь.

С одной стороны, эти институты задают некоторую сеть ролевых позиций и нормативных требований по отношению к конкретным членам общества. С другой стороны, они представляют собою определенные достаточно устойчивые пути социализации индивидов.

Проработанный монгольско-российским научным коллективом теоретический подход к обоснованию основных задач социальной модернизации общества, позволяет вплотную подойти к почти неизведанной теме - философскому осмыслению развития социальной стуктуры современного монгольского общества. Получается, что и здесь, на монгольской земле, происходят глубокие социальные изменения в связи с глобализацией всех отраслей общества.

На основе анализа изменения социальной структуры Монгольского общества нами сделано сравнение этого изменения по годам и тем самим наглядно прослежен процесс социализации общества, который должен развиваться по сетевой модели, которой свойственны синергетические, диалогические и коммуникативные эффекты.

Главное достоинство новой модели - открытость этого процесса к коммуникации и возможности самоорганизации. В рамках этой модели переживающее и далее при необходимости стратификацию общество сталкивается по мере своего усложнения (структурирования) с параллельным процессом - встраиванием социальных позиций в определенную социальную иерархию. Так появляются к, с, к, политико-финансовые олигархии и т. д.

Научная ценность этого подхода заключается в том, что сложившаяся в обществе стратификационная модель представлена как достаточно сложная и многослойная (полихотомическая), многомерная (осуществляется по нескольким осям) и вариативная (допускает порой существование множества стратификационных моделей со своими цензами, квотами, аттестациями, определениями статуса, рангами, льготами, привилегиями, другими преференциями).

По моему убеждению особое внимание для сравнительного анализа заслуживают теоретико-методологические проблемы модернизации и обновления российского многонационального общества, выраженные в очень содержательных, интересных и порой даже дерзких по смыслу тезисах, которые присутствуют в работах Горшкова Михиала Константиновича и Голенковы Зиниады Тихоновной.

Несомненно большой научно-теоретический интерес вызывает концепция Александра Сергеевича Железнякова о «полюсности» демократической Монголии в современном мире, особенно в контексте колоритной, своеобразной и многонациональной цивилизации Внутренней Азии, которой он дал название «монгольская цивилизация» по имени ее древнего кочевого ядра, а ныне единственного суверенного государства в регионе.

Я считаю делом чести свое участие в этом труде наряду с известными и крупными

российскими и монгольскими учеными. В своем разделе я затронул особенности формирования монгольской цивилизации, ее влияния на социализацию нашего общества.

Монголия, отвергая бюрократический, централизованный социально-экономический принцип, вплотную подходит к новому этапу интенсификации развития всех отраслей нашего общества.

Особенности социального обновления и социокультурного развития современного монгольского общества определяются своеобразием формирования и развития цивилизации и истории монгольского народа, монгольской государственности, неповторимым и своеобразным обликом жизни и мировозрения степного свободомысляшего кочевника.

Кроме того на социальное обновление Монголии несомненно воздействуют глобальные процессы, происходяшие в современном мире, такие как глобализация всех сфер общественной жизни больших и малых народов и наций, природное потепление и связанные с ним ухудшение экосреды, другие глобальные явления.

Поэтому руководство Монголии во имя коренных интересов своего народа по новому определяют цель и задачу дальнейшего развития - на научной основе, с учётом внутренних и внешних условий и тенденций их изменения.

Основными задачами социального обновления, модернизации социальной структуры и социальной культуры Монголии считаем:

- Стабильным экономическим развитием обеспечить улучшение качества жизни народа, дать современной семье достойный постоянный источник дохода и главное, надежные и перспективные рабочие места. Ныне мы в Монголии выдвинули целостную программу социального развития, в которой ставится задача: обеспечить надежной работой каждого гражданина, чтобы работать и жить в условиях общественной безопасности, быть духовно богатым, физически и психологически здоровым, иметь стабильный доход и достойное образование мирового уровня, быть уверенным в своем будущеем;
- Обновление системы общего, высшего образования путем внедрения инноваций и менеждмента качества во всех циклах образовательного процесса, качественного улучшения преподавательского состава, совершенствования учебно-материальной среды и.т.д. Прежде всего предполагается совершенетвование правовой системы регулирования образования с целью обсепечения свободы научной творческой деятельности, либерализация деятельности высших учебных заведений уменьшение влияния на них государства.
- Все социальные процессы (объективные и субъективные), связанные с формированием и обновлением социальной структуры и социальной культуры должны отвечать интересам национальной безопасности страны, государства, общества и его членов и укреплению национального единства народа. Монголия страна почти мононациональномая и моноконфессиональная, но это не исключают заботы государства и его должностных лиц об обеспечении равноправия и уважения и на словах и на деле национально-культурных интересов всех народов, населяющих территорию страны, свободы их вероисповедения.
- Монголия очень богата природными ресурсами. Одновременно природа Монголии очень уязвимая. В последные годы в Монголии стремительно развиваются горно-добывающая, в особенности золото-добывающая, угольная, металлургическая промышленность. Порою жадность иных бизнесменов и граждан, недальновидность государственних органов и их чиновников ведет к катастрофическому ухудшению экологии. Потому срочное и фундаментальное обновление правого регулирования в области экологии и горнодобывающей промышленности - это веление времени.

- Первостепенными задачами обновления и совершенствования правого регулирования в области социальных процессов в Монголии считаем:

- Создание надежной правовой и социальной гарантии свободы личности граждан и обеспечение их равноправия перед зоконом;

- Обеспечение равноправия национальных меньшинств, свободы вероисповедания всех граждан и использования ими источников информации;

- Обновление правовой системы в области экологии, законодательства горнодобывающей промышленности, использования иностранных калиталовложений и рабочей силы и т.д.

- Совершенствоваие правовой системы в области образования, здравоохранения, в особенности создание системы правового регулирования государственной поддержки малоимущей части населения в получении доброкачественного государственного социального обслуживания;

Я затронул ключевые проблемы социальной модернизации и обновления монгольского общества. Огромные природные ресуры, количественный и качественный рост населения страны, его адаптация к новым социальным условиям, возрождение его самосознания, приток иностранных капиталовложений, эффективное использование плодов других положительных сторон глобализационных процессов позволяют нам смотреть на перспективы обновления монгольского общества оптимистично.

В заключении мне хотелось бы выразить свою уверенность в успехе дальнейшего сотрудничества ученых, исследователей Института социологии Российской Академии Наук и Института «Шихихутуг» во имя успехов социальной модернизации и обновления Монголии и России.

# ШИХИХУТУГ ХЗДС БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ ДЭЭР ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР Д.ОЮУНЦЭЦЭГИЙН ХЭЛСЭН ҮГ

**Эрхэм хүндэт зочид оо,**

**Профессор багш нар, төгсөгчид, оюутан, ажилтнуудаа**

**Хатагтай, ноёд оо**

**Та бүхний энэ өдрийн түмэн амгаланг айлтгаяа**

Их Монгол Улсын төрийн Их заргач хүмүүний алдраар овоглосон эрдмийн өргөө маань үүд хаалгаа нээсэн тэр цаг мөчөөс хойш бид хорин хавар, хорин намрыг үджээ. Эрдмийн гэгээн өргөөнийхөө 20 жилийн ойн энэ өдөр сургуулийн тулгын чулууг тавилцсан санаа зорилго нэгт анд нөхөддөө, анхны багш нартаа, бидний анхны уриа дуудлагаар сургуульд элссэн ууган шавь нартаа, үе үеийн бүх төгсөгч нартаа, өнөө суралцаж буй оюутан, ажиллаж буй багш, ажилчид та бүхэндээ баярын мэнд дэвшүүлье.

Он цагийн хэлхээнд 20 жил богинохон хугацаа хэдий ч бидний хувьд амжилт бүтээл дүүрэн он жилүүд байлаа. Бид хувийн хэвшлийн дээд боловсролын тулгын чулууг тавилцсан анхны сургуулийн нэг нь болсон маань мартагдашгүй бахархал, төр, түмэндээ өргөж байгаа эрхэм үйлс мөн билээ. Энэхүү бахархлыг Отгонтэнгэр Их Сургууль, Монгол Бизнес, Оточ манрамба, Үндэсний биеийн тамирын дээд сургууль хуваалцах учиртайг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй биз ээ.

Бид мэргэжлийн боловсролын дан ганц төрийн өмч ноёрхсон төвлөрсөн тогтолцоог халж, өмчийн олон хэвшилд тулгуурласан чөлөөт өрсөлдөөн, хүний сурч боловсрох өргөн эрхийг хангасан ардчиллын их үйл хэргийн мөрийг гаргагчид гэдгийг түүх гэрчилнэ.

Аливаа бүхний анхны мөрийг гаргах тийм ч амаргүй даваа гэдгийг Та бүхэн сайн мэдэх билээ. Туршлага дутах, хөрөнгө мөнгөөр гачигдах, хувийн гэдэгт үл итгэх зэрэг бэрхшээлтэй тулгарч байсан ч шантралгүй даван туулаа. Хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд өнөөдөр улс, үндэстнийхээ дээд боловсролын тогтолцоонд байр сууриа баттай эзэллээ.

Боловсролын хөгжлийн чиг хандлагыг ч тодорхойллоо. Энэ бол улс орны маань хөгжлийн сүүлчийн 20 жилийн нэг үзүүлэлт, нэг томоохон алхам гэж үзэж байна.

Шихихутуг ХЗДС-ийн 20 жилийн ойг тохиолдуулан хувийн өмчийн бүх их, дээд сургуулийн эрдэмтэн багш, судлаачид, ажилтан, оюутан нарт баярын халуун мэндчилгээ өргөн дэвшүүлье.

Эрхэм хүндэт профессор, багш, шавь нараа, хатагтай, ноёд оо.

Хорин жилийн хөгжлийн гол үр дүн бол сургууль маань орчин үеийн менежментийн алхаанд орж, чадварлаг багштай, сургалт,

даддагын тохилог орчинтой, санхүүгийн найдвартай эх үүсвэртэй болсонд оршино. Түүнчлэн үндэсний түүх, уламжлал, соёлын үнэт зүйлс, хууль зүйн шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололтод түшиглэсэн сургалтын өөрийн гэсэн өвөрмөц дэг жаягийг бүрдүүлж чадлаа гэж хэлж болно.

Манай сургууль дээд боловсролын байгууллагын анхан шатны болон ахисан түвшингийн магадлан итгэмжлэлүүдийг амжилттай хийлгэлээ. Мөн хууль эрх зүйн их, дээд сургуулиудаас анх удаагаа эрх зүйн бакалаврын сургалтын хөтөлбөрөө 2011 оны 6 дугаар сард магадлан итгэмжлүүлж, цаашдын ажил үйлсийн чиг хандлага, зорилго, зорилтоо тодруулж авлаа.

Бидний ололт амжилт бол оюутнуудаа оролцуулсан нийт хамт олны нөр их хичээл зүтгэлийн үр дүн билээ.

Баярын энэ өдөр сургуулийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн эрдэмтэн багш нар, дотоод, гадаадын хамтран ажилладаг түнш байгууллага, хувь хүмүүст чин сэтгэлийн талархалаа дэвшүүлье.

Бид хоёр арван жилийн хугацаанд 1200 гаруй эрх зүйч мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэжээ. Төгсөгчид маань эх орныхоо өнцөг булан бүрт сургуулийнхаа нэр төрийг ажил үйлс, бүтээл зүтгэлээрээ өндөрт өргөж явна. Тэдний дундаас олноо танигдсан шүүгч, прокурор, төрийн түшээ, эрдэмтэн, судлаачид байнга төрсөөр байна. Энэ бол бидний бас нэгэн бахархал билээ. Бүх төгсөгч нартаа баярын мэнд дэвшүүлж сайн сайхны ерөөл дэвшүүлье.

Манай сургууль сургалттайгаа зэрэгцүүлэн үндэснийхээ хууль зүйн шинжлэх ухааны их сан хөмрөгт хувь нэмрээ оруулах ажил үйлс бүтээхийн төлөө хүчин чармайлт гаргасаар байна. Бидний зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, чуулган сургуулийн маань «бренд» боллоо. Манай сургуулийн эрдэмтэн, багш нарын онол, арга зүйн бүтээлүүд эрдэмтэд, судлаачдын хүлээн зөвшөөрөгдсөн судлагдахуун болон ашиглагдаж байна. Оюутнуудын авъяас, чадвараар бүтсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил ирэх цагийн цэцэг ногоо лугаа дэлгэрэн хөгжих үндэс тавигдаж байна.

Бид сургуулийнхаа бүтцэд төр ёсны соёл, түүх, уламжлал, хүний эрх, эрх зүйн сэтгэлгээний онол, арга зүйн тулгамдсан асуудлуудын суурь болон хавсарга судалгаа хийх «Шихихутуг» судалгааны төвийг өнгөрсөн жил байгууллаа. Энэ бол сургалтыг судалгааны ажилтай хослон чанарыг сайжруулахад чиглэсэн нэг алхам гэж үзэж байна.

Багш, судлаач нарынхаа сургалт, эрдэм шинжилгээний эрэл хайгуулын ажил хийгээд хамт олныхоо үйлс бүтээлийн бат бэх ар тал нь болж байдаг санхүү, аж ахуй, үйлчилгээний ажилтан нарынхаа хүчин зүтгэлийг өндрөөр үнэлж явдагаа цохон тэмдэглэж байна. Тэд нартаа аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхний ерөөл дэвшүүлье.

Нийгэмд эзлэх байр суурьнараа хүндтэйд тооцогддог хуульч мэргэжлийн эзэн нь болох гэж хичээл, зүтгэл, соёл, оюун ухаанаа дайчлан чармайж яваа оюутан та нартаа багш нь энэ хүндэтгэлтэй индрээс халуун баяр хүргэж, эх орныхоо хөгжил, цэцэглэлийн гал цогтой ирээдүй болж явахын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж байна.

Хатагтай, ноёд оо

Бидний зорилго, зорилт тодорхой билээ. Ололт амжилтаа улам бататгаж, шинэ шинэ ажил үйлсийн эзэд нь байхын төлөө урьд урьдаас илүү хүчин чармайлт гаргацгаая аа. Эрдмийн ач буяны ажил үйлс өөдрөг байхыг чин сэтгэлээсээ хүсье.

Бидний урилгыг хүлээн авч, эрдмийн хамт олны маань баярыг хуваалцахаар хүрэлцэн ирсэн бүх зочид, гийчид, байгууллага, хамт олон, анд нөхөд, хамтран зүтгэгч нартаа хамгийн сайн сайхан, эрүүл энх, аз жаргалын дээдийг өргөн дэвшүүлье.

***Баярлалаа, та бүхэндээ.***

# МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## ЭКОЛОГИЙН ЭРХ ЗҮЙН ДУУДЛАГА: ОРШИХУЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Экологийн эрх зүйн дуудлага: Оршихуйн эрх зүйн баталгаа сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал амжилттай зохион байгуулагдлаа. Тус хуралд Монголын байгаль орчин, экологийн салбарт ажиллаж байгаа болон энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг эрдэмтэн, доктор, профессор нар экологийн салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг дэлгэн тавьж, гарах арга замыг тодорхойлсон өргөн хүрээ бүхий илтгэлүүд хэлэлцэгдлээ. Уг олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн урилгаар Эрхүүгийн улсын их сургуулийн хууль зүйн сургууль, Францын Совайн их сургуулийнийн хүндэт декан нар хүрэлцэн ирж экологи, байгаль орчны салбар дахь хоёр улсын хууль тогтоомжийн ялгаатай болон давуу талуудыг илтгэсэн илтгэлүүдийг хэлэлцүүллээ. Экологийн эрх зүйн дуудлага: Оршихуйн эрх зүйн баталгаа сэдэвт олон улсын зэрдэм шинжилгээний бага хурлын материалуудыг Шихихутуг хууль зүйн дээд сургуулиас нийт эрдэмтэн багш нар, оюутан суралцагчид болон байгаль орчны салбарт ажиллаж, эрдэм бүтээлээ туурвиж буй хүмүүст зориулан ном болгон хэвлэгдэн гаргалаа.

# ХУУЛЬЧ ЗӨВЛӨЖ БАЙНА.

***АСУУЛТ:** Иргэн М би 2000 онд нөхөр болох Г-тэйгээ гэр бүл болсон бөгөөд удалгүй хүү болох Т, охин болох Ц нар нь төрсөн юм. Хэдийгээр бид нар сайхан амьдарч байсан боловч нөхөр маань удаа дараа согтуу ирж хүүхдүүдээ болон намайг зодох болсон. Уг нь архинаас гарна гэж өөрөө байнга уучлалт гуйдаг болохоор нь удаа дараа итгэж байсан боловч энэ байдал үргэлжилсээр байгаа тул цаашид энэ хүнээс гэрлэлтээ цуцлуулж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгомоор байна. Хуул зүйн зөвлөгөө өгөхийг хүсье.*

Сайн байна уу. Танд тулгараад байгаа асуудалтай танилцлаа. Та гэр бүлээ цуцлуулахаар нэг мөсөн шийдсэн бол ИХШХШт хуулийн 126-р зүйлд зааснаар хариуцагч буюу нөхрийнхөө оршин байгаа газрын шүүхэд нэхэмжлэлээ гаргана. Нэхэмжлэлдээ гэр бүлээ цуцлуулах болсон шалтгаан, мөн дундын өмч байгаа бол түүнийгээ тогтоолгох, хүүхдүүддээ тэтгэмж тогтоолгох тухайгаа бичээрэй. Гэр бүлийн тухай хуулийн 10.3-т зааснаар гэрлэгчид нь хоёул үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүрэгтэй бөгөөд гэр бүлийн тухай хуулийн 38.1-т зааснаар эцэг, эх нь үр хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараахь хэмжээгээр тогтооно:

40.1.1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;

40.1.2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр тогтооно. Нэмэлт тайлбар шаардлагатай буюу гэр бүл цуцлуулах тухай нэхэмжлэлийг бичүүлэх хүсэлтэй байгаа бол Шихихутуг ХЗДС-ийн эрх зүйн туслалцаа үзүүлэх клиник сургалтанд хандаж болох юм. Та бүхэнд хууль зүйн зөвлөгөө өгөхдөө бид баяртай байх болно.

Хууль зүйн зөвлөгөө өгсөн: П.Түвшинтөгс

/Шихихутуг ХЗДС-ийн салбар эрх зүйн тэнхмийн багш,

Хууль зүйн магистр

***АСУУЛТ: Намайг Х гэдэг. Нэг компани байгуулах гэсэн юм. Компани байгуулах, бүртгүүлэхэд юу юу хэрэгтэй болох, хаана хандах вэ? Эрх зүйн туслалцаа үзүүлнэ үү.***

**Хуулийн зөвлөгөө:** Бидний мэдэх бизнесийн байгууллагын эрх зүйн зохицуулалт, түүн дотроо компанийн хууль тогтоомж нь олон зуун жилийн түүхийн үр дүнд бий болсон бөгөөд энэ түүхэн хугацаанд компанийн эрх зүйн шинэ зохицуулалт олон нугачаа, хүндрэлүүдийг даван туулсан байдаг. Манай улсын хувьд бизнес эрхлэх хэлбэрийг хуулийн төвшинд зохицуулсан баримт бичиг 1987 онд анх батлагдсанаар энэ талаарх эрх зүйн зохицуулалтын орчин бий болсон. Харин компанийн хэлбэрийг анх 1991 оы Аж ахуйн нэгжийн тухай хуулиар хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүнээс хойш 1995 онд Нөхөрлөл, компанийн тухай хууль, 1999 онд Компанийн тухай хууль, 2011 онд Компанийн тухай / шинэчилсэн найруулга/ хууль батлагдсан түүхтэй.

1999 оны Компаний тухай хуулиар ХХК-г үүсгэн байгуулахад шаардагдах хөрөнгийн доод хэмжээ 1 сая, ХК-ын хувьд 10 сая төгрөг байхаар заасныг 2011 оны Компаний тухай /шинэчилсэн найруулга/ хуульд «хуульд өөрөөр заагаагүй бол компанийг үүсгэн байгуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хязгаар тавихгүй» гэжээ. Харин даатгал, банк, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа салбарын хувьд өөр зохицуулалттай. Дээрх хөрөнгийн доот хязгаар тавихгүй гэсэн нь аль болох хялбар, зардал багатай, хязгаарлалтгүйгээр байгуулах хандлага дэлхий даяар зонхилж байгаатай холбоотой юм.

Компанийг шинээр, эсхүл хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болдог. Компанийн үүсгэн байгуулагчийн тухайд Монгол улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байгуулж болно. Компани нэг үүсгэн байгуулагч байгуулж болно.

Компанийг шинээр үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг байгуулдаг. Үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулах бөгөөд уг хурлаар компани байгуулах тухай, компанийн дүрэм, зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчдын худалдан авах үнэ, төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Компанийг үүсгэн байгуулах хурлын даргыг үүсгэн байгуулагчдаас сонгоно. Компанийг байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

Бүрдүүлэх баримт бичигт:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-03/
2. Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хуудас
3. Хуулийн этгээдийн дүрэм /3 хувь/
4. Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр /3 хувь/
5. Хуулийн этгээдийн харилцах данс нээсэн тухай мэдэгдэл
6. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
7. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчийн анкет /3 хувь/ иргэн бол иргэний

үнэмлэхний хуулбар, хуулийн этгээд бол гэрчилгээний хуулбар

8. Эхлэлтийн тайлан тэнцэл /3 хувь/
9. Бусад холбогдох баримт бичиг /хөрөнгийн жагсаалт, бэлэн мөнө тушаасан баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар гэх мэт/
10. Баримт бичгийг хийж хадгалах, архивын шаардлага хангасан хавтас /1 ширхэг/

*Хууль зүйн зөвлөгөө өгсөн: Салбар эрх зүйн тэнхмийн багш Ч.Жадамба*

***АСУУЛТ: Би энэ жил 55 настай, эрэгтэй. Улсад нийт 25 жил ажилласан. Тэтгэвэр тогтоолгох гэсэн чинь нас хүрээгүй гэдэг шалтгаанаар тогтоолгож чадаагүй. Хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох боломж надад байгаа юу. Хууль зүйн туслалцаа үзүүлээч.***

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох асуудал нь «Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль», «Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль»-иар зохицуулагдах асуудал юм.

Өндөр насны тэтгэврийг ердийн нөхцөлд ажил хөдөлмөр эрхэлснээс гадна газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан түүнчлэн сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр хэдэн жил ажилласнаас нь шалтгаалан хүйс болон насны шалгуур нь өөр өөр байх тохиолдол байна. Тухайлбал, Ажилласан хугацаа, хүйсийн байдлаас нь шалтгаалан 45 нас, 50 нас, 55 нас, 60 нас хүрсэн гэсэн тухайн тэтгэврийн насны шалгуур байна. Түүнчлэн ажилласан жил харгалзан нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоох асуудал ч байна. Үүнд: Цэргийн албан хаасны тэтгэвэр хамаарах юм.

Таны хувьд ажилласан жилийн хувьд 25 жил байгаа нь ажилласан хугацаа хангалттай буюу өндөр насны бүрэн тэтгэвэр авах ажилласан жилийн шалгуурыг хангасан байна. Ажилласан хугацааг тодорхойлохдоо улсад байна уу, хувийн хэвшилд байна уу хамааралгүйгээр нийт ажилласан хугацаан дээр ажилласан хугацаанд оруулан тооцох хугацаагаар тодорхойлдог. Харин насны шалгуурын хувьд ямар нэгэн байдлаар хортой, халуун ...гэх мэт нөхцөлд ажилласан гэсэн нөхцөл асуултад байхгүй байгаа учраас өндөр насны тэтгэвэр авах нас хүрээгүй гэдэг шалтгаан нь хууль зүйн үндэслэлтэй юм. Өөрөөр хэлбэл та өндөр насны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх нь нас /60 нас/ болон ажилласан жилийн /20-иос доошгүй, 10-20 хүртэл жил/ шалгуураа зэрэг хангаж байж авах боломжтой.

Мөн «Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль»-ийн 4-р зүйлийн 1, 5 дахь хэсэгт заасанаар: Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Түүнчлэн Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй гэж хуульчлагдсан. Бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн гол ялгагдах шинж нь ажилласан хугацаагаар тодорхойлогдох асуудал юм. Өөрөөр хэлбэл насны шалгуур нь бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн хувьд ижил байдлаар /60 нас/ хүрсэн байхыг шаарддаг.

Та одоогийн байдлаар нас нь шалгуураа хангахгүй байгаа учраас бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийг аль алийг нь тогтоолгох боломжгүй юм. Цаашид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөө зогсоосон байхад таны 60 насанд хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгон авах эрх нь хуулиар хадгалагдана.

Ер нь НДШ төлж ажилласан жил нэмэгдэх тусам танд илүү төлсөн жил тутамд 1,5 %-ийн нэмэлт тэтгэвэр тогтоолгох боломж нээгдэнэ.

*Хууль зүйн зөвлөгөө өгсөн: Шихихутуг ХЗДС-ийн Салбар эрх зүйн тэнхимийн багш Е.Болормаа*

*/Хууль зүйн магистр, хуульч, өмгөөлөгч/*



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд Батаагийн Батцэрэн, Баттогоогийн Цогт, Готовдоржийн Цагаанцоож, Дамдины Ганзориг, Дашдоржийн Мөнхтуяа, Дашхүүгийн Цолмон, Мишигийн Батсуурь, Хуушааны Эрдэнэсувд нарыг томиллоо. Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон М.Батсуурь нь 1999 онд Шихихутуг хууль зүйн дээд сургуулийг төгссөн, манай тэргүүний оюутнуудын нэг юм.

Шинэхэн үнэмлэхээ гардан авсан шүүгч М.Батсуурьдаа цаашдын ажил, амьдралд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Шихихутуг ХЗДС-ийн хамт олноос....

Хууль зүйн их, дээд сургуулиудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг захиргааны эрх зүйн МОСК TRAIL шүүхийн мэтгэлцээний тэмцээнд амжилттай оролцож, багаараа дэд байр эзэлсэн Г.Гантогтох ахлагчтай «ХИЙДЛИЙН АНГУУЧИД» багийнхандаа баяр хүргэе.

Тэмцээнийг МУ-ын Шүүхийн тухай хуулийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон Захиргааны хэргийн шүүгчид шүүж дүгнэдэгээрээ ихээхэн онцлогтой байдаг. Энэ удаагийн тэмцээний шүүгчдээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Д.Батбаатар, П.Соёл-Эрдэнэ, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч Д.Баатархүү, Ц.Сайхантуяа нар шүүгчээр оролцсон юм.

Тэмцээнд:

1. МУИС-ийн Хууль зүйн сургууль
2. «Отгонтэнгэр» их сургуулийн ХЗС
3. Орхон» их сургууль ХЗС
4. «Их засаг» ОУИС-ХЗС
5. «Шихихутуг» Хууль зүйн дээд сургууль



6. «Билиг» Хууль зүйн дээд сургууль
7. Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн салбар
8. «Сутай» дээд сургууль
9. Хууль сахиулахын их сургууль гэсэн хууль зүйн их, дээд сургуулийн оюутнууд оролцов.

Тэмцээн 4-н үеийн турш өрсөлдөөнтэй явагдсаны эцэст тэмцээний дүн гарсан бөгөөд 1-р байранд МУИС-ХЗС-ийн баг, 2-р байранд Шихихутуг ХЗДС-ийн баг, 3-р байранд «Их засаг» ОУИС-ийн ХЗС-ийн баг тус тус шалгарсан байна.



Хууль зүйн сайдын нэрэмжит JUS оюутны эрдэм шинжилгээний бага хурлын Үндсэн хуулийн эрх зүйн салбарт «Үндсэн хуулийг шүүхэд хэрэглэх зарим асуудал», Захиргааны эрх зүйн салбарт «Хэрэглэгчийн эрхийг захиргааны журмаар хамгаалах зарим асуудал» сэдвүүдийг амжилттай хэлэлцүүлж, манай сургуулийн бизнесийн эрх зүйн 4 дүгээр дамжааны оюутан Г.Гантогтох дэд байр тус тус эзэлсэн билээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, «Эрх зүйн боловсрол» академиас хамтран хууль зүйн их, дээдсургуулиудын оюутнуудын дунд «Захиргааны хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа» сэдэвт эрдэмшинжилгээний эссэ бичлэгийн уралдаан зарласан бөгөөд 1-р шатанд нийтдээ 18 эссэ ирүүлжээ.

2-р шатанд 5 эссэг оролцуулахаар шалгаруулсан бөгөөд 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын байранд тэдгээр 5 эссэг хэлэлцүүлж 2-р шатны шалгаруулалт явагдаж дүнгээ гарган, шилдэгүүдээ тодруулаа.

1-р байранд

- Г.Гантогтох / «Шихихутуг» ХЗДС/

2-р байранд

- Ж.Буджав /МУИС-ын ХЗС/

3-р байранд

- Т.Пүрэвбазар /МУИС-ын ХЗС/

Тусгай байр

- Б.Алтанхуяг /МУИС-ын ХЗС/
- А.Базар /МУИС-ын ХЗС/ нар тус тус шалгарав.



Энэхүү уралдааны 2-р шатанд шалгарсан оюутнууд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хяналтын хүрээ, ялангуяа ЗХХШТХ-ийн 85 дугаар зүйлийн 85.3 дахь хэсэгт заасан «Давж заалдах шатны шүүх гомдолд заасан үндэслэлээр хязгаарлахгүй захиргааны хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй» гэдэг асуудалд судалгаа хийж, гадаад орнуудын захиргааны хэргийн давж заалдах шүүхийн хяналтын хүрээтэй харьцуулж, өөрсдийн саналаа дэвшүүлсэн байлаа.

Мөн нотлох баримт үнэлэх асуудал болон магадлал үндэслэлтэй байх сэдвүүдээр сонирхолтой санаа гарган хэлэлцүүлсэн болно.

Тэргүүн байранд шалгарсан Шихихутуг ХЗДС-ийн оюутан Г.Гантогтохдоо баяр хүргэж, цаашдын эрдэм судлалын ажилд нь өндрөөс өндөр амжилтыг нийт Шихихутуг сургуулийн хамт олноос дэвшүүлж байна.

*Шихихутуг ХЗДС-д элсэхийг хүсэгчдэд......*

*Захирлын 2013 оны 04-р сарын 01-ний өдрийн 17 тоот тушаалаар батлав.*

# ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

## 1. Ерөнхий зүйл

1.1. Шихихутуг ХЗДС-ийн магистрын болон бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт оюутан элсүүлэхэд БШУ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар баталсан «Оюутан элсүүлэх журам»-д нийцүүлэн гаргасан дараах журмыг удирдлага болгон элсэлтийг зохион байгуулна. Үүнд:

- 2013-2014 оны хичээлийн жилд Шихихутуг ХЗДС-д Улаанбаатар хотоос магистрын хөтөлбөр, бакалаврын өдөр болон эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- Хөдөө орон нутгаас бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэхэд «Аймаг, орон нутгаас Монголын их, дээд сургуулиудын консорциум /МИДСК/-ын гишүүн их, дээд сургууль, коллежид оюутан элсүүлэх журам»-ын дагуу МИДСК зохион байгуулна.[1]

1.2. Энэхүү журмын зорилго нь Шихихутуг ХЗДС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг зохицуулахад чиглэнэ.

1.3. Элсэлтийн ажлыг Захирлын тушаалаар батлагдсан комисс зохион байгуулна.

1.4. Элсэлтийн комисс үйл ажиллагаандаа ил тод, шударга, хүртээмжтэй, тэгш байдлыг хангах зарчмыг удирдлага болгон ажиллана.

1.5. Шихихутуг ХЗДС-д элсүүлэх оюутны хяналтын тоог БШУЯ-наас тогтооно.

1.6. Ерөнхий шалгалттай холбоотой мэдээллийг Боловсролын үнэлгээний төвийн сайт /www.eec.mn/, Шихихутуг ХЗДС-ийн элсэлттэй холбоотой мэдээллийг www.shihihutug.edu.mn сайтад тус тус мэдээлнэ.

## 2. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

2.1. Шихихутуг ХЗДС-д элсэгч бүрэн дунд болон түүнээс дээш боловсрол эзэмшсэн байна.

2.2. Улаанбаатар хотоос элсэгч «Нийгмийн тухай мэдлэг»-ийн ерөнхий шалгалт, хөдөө орон нутгаас элсэгч **Нийгмийн тухай мэдлэг /70 хувь/, Математик /30 хувь/**-ийн хичээлээр ерөнхий шалгалтыг өгнө.

2.3. Ерөнхий шалгалтын нийт онооны **50-иас** дээш хувийг авсан тохиолдолд бүртгүүлэх эрх нээгдэнэ.

2.4. Бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр 2012 эсвэл 2013 онд ерөнхий шалгалт өгсөн байна.

2.5. Бакалаврын зэрэгтэй иргэнийг «Эрх зүйч» мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт эчнээ хэлбэрээр элсүүлэн суралцуулна. Эчнээ хөтөлбөрт элсэгчид ерөнхий шалгалт өгөх шаардлагагүй. Үндсэн хуулийн мэдлэгийн шалгалт авна. Шалгалт өгсөн онооны дараалаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтаан шалгаруулж элсүүлнэ.

2.6. Бакалаврын зэрэгтэй иргэн өдрийн хөтөлбөрөөр «Эрх зүйч», «Бизнесийн эрх зүйч» мэргэжлээр суралцах хүсэлтэй бол энэ журмын 2.2, 2.3-т заасны дагуу элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байна.

1 Тайлбар: Хөдөө орон нутгийн элсэлт 2013 оны 7-р сарын 1-5-ны хооронд зохион байгуулагдана.

2.7. Эрх зүйн бакалаврын зэрэгтэй иргэнийг магистрын хөтөлбөрт суралцуулна. Магистрантурт элсэгчдээс мэргэжлийн суурь мэдлэг болон гадаад хэл /англи, орос хэл/-ний шалгалт авна.

2.8. Шихихутуг ХЗДС-д элсэн суралцахыг хүссэн гадаадын харьяат иргэний асуудлыг Шихихутуг ХЗДС-ийн «Гадаадын иргэдийг суралцуулах журам»-аар зохицуулна.

**3. Элсэлтийн бүртгэл**

3.1. Бакалаврын:

- өдрийн хөтөлбөрт элсэгчдийг 7-р сарын 1-нээс 7-р сарын 5-ныг дуустал
- эчнээ хөтөлбөрт элсэгчдийг 9-р сарын 10-наас 9-р сарын 25-ныг дуустал

3.2. Магистрантурын хөтөлбөрт элсэгчдийг 9-р сарын 10-наас 9-р сарын 25-ныг дуустал тус тус бүртгэнэ.

3.3. Бүртгэлийн хураамж 6000 төгрөг

**4. Бүртгүүлэх материал**

4.1. Бакалаврын өдрийн хөтөлбөрт бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг /нотариатаар батлуулсан хуулбар/
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ / хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг/, хуулбарын хамт
- Ерөнхий шалгалтын батламж, хуулбарын хамт
- Цээж зураг 2 хувь /сүүлийн 3 сард авахуулсан/
- Элсэхийг хүссэн өргөдөл /зохих загварын дагуу/
- Бүртгэлийн хураамж **/ХХБ дахь Шихихутуг ХЗДС-ийн 499092709 төгрөгийн, 499092710 валютын тоот дансанд тушаасан орлогын мэдүүлэг/**

4.2. Бакалаврын эчнээ хөтөлбөрт бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг /нотариатаар батлуулсан хуулбар/
- Өмнөх бакалаврын диплом, хуулбарын хамт /нотариатаар батлуулсан/
- Цээж зураг 2 хувь /сүүлийн 3 сард авахуулсан/
- Анкет бөглөх /төрийн албан хаагчийн/
- Бүртгэлийн хураамж

4.3. Магистрантурын хөтөлбөрт бүртгүүлэгч нь дараах материалыг бүрдүүлнэ.

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг /нотариатаар батлуулсан хуулбар/
- Эрх зүйн бакалаврын диплом, хуулбарын хамт /нотариатаар батлуулсан/
- Цээж зураг 2 хувь /сүүлийн 3 сард авахуулсан/
- Анкет бөглөх /төрийн албан хаагчийн/
- Бүртгэлийн хураамж

**5. Элсэгчдийг шалгаруулах ба зарлах**

5.1. Тус журмын 2.3-д заасан болзол хангасан бүртгүүлэгчдийн нийгмийн тухай мэдлэгийн ерөнхий шалгалтын оноон дээр боловсролын гэрчилгээний дундаж оноог нэмж, онооны жагсаалт хийн, хяналтын тоонд багтаан шалгаруулж, элсүүлнэ.

5.2. Шалгаруулалтыг 7-р сарын 20-ны дотор хийж, тэнцсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг Шихихутуг ХЗДС-ийн вейб сайтад /www.shihihutug.edu.mn/, болон сургуулийн мэдээллийн самбарт байрлуулна.

5.3. Тус журмын 2.5-д заасан болзол хангасан бүртгүүлэгчдээс шалгаруулалт хийхдээ

Үндсэн хуулийн мэдлэгийн шалгалтын оноогоор эрэмбэлэн онооны жагсаалт гаргана. Шалгаруулалтыг 9-р сарын 30-ны дотор хийж, тэнцсэн хүмүүсийн нэрсийг зарлана.

5.4. Тус журмын 2.7-д заасан болзлыг хангасан бүртгүүлэгчдээс шалгаруулалт хийхдээ мэргэжлийн суурь хичээлийн шалгалтан дээр англи хэлний шалгалтын дүнг нэмж, эрэмбэлэн онооны жагсаалт гаргана. Шалгаруулалтыг 9-р сарын 30-ны дотор хийж, тэнцсэн хүмүүсийн нэрсийг зарлана.

## 6. Хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх

6.1. Тухайн жилийн нийгмийн тухай мэдлэгийн эсвэл математикийн чиглэлээр олон улсын болон улс, аймаг, хот, дүүргийн олимпиадад I-III байрт шалгарсан сурагчийг нотлох баримтыг үндэслэн онооны дараалал харгалзахгүй шууд элсүүлнэ.

## 7. Элсэх эрх олгох

7.1. Онооны жагсаалт болон хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх болзол хангаж, хяналтын тоонд багтсан, сургалтын төлбөрийн зохих хувийг төлсөн элсэгчид суралцах эрхийн бичгийг олгоно.

7.2. Элсэгч энэхүү журмын 4-р зүйлд заасан материалыг эх хувиар, нэмж хувийн хэрэг, төгссөн сургууль болон ажиллаж буй байгууллагын тодорхойлолтыг бүрдүүлнэ.

7.3. Мөн 7.2-д заасан материалаас гадна сургалтын төлбөр төлсөн баримт /зээл авах, төрөөс хариуцах бол холбогдох бичиг баримтууд, төрийн албаны тухай хуулийн дагуу төлөгдөх бол эцэг, эхийн аль нэгний албан газартай хийсэн гэрээ/ зэрэг материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийж ирүүлнэ.

7.4. Сургалтын төлбөрийг суралцах тухай гэрээнд заасны дагуу 9-р сарын 15-ны дотор бүрэн төлж дуусгасан байна.

7.5. Тус сургуульд элсэх шалгаруулалтад тэнцсэн элсэгчдийн бүртгэлийг 7-р сарын 25-наар тасалбар болгох ба дурьдсан хугацаанд суралцах эрхийн бичгээ аваагүй хүмүүсийг элсээгүйд тооцно.

7.6. Элсэгч нь энэхүү журмын 7.1, 7.2, 7.3, 7.4-д заасан нөхцөлийг хангасан тохиолдолд сургууль дээр өөрийн биеэр ирж 8-р сарын 20-ноос 8-р сарын 25-ны хооронд бүртгүүлнэ.

7.7. Суралцах эрхийн бичиг авсан боловч заасан хугацаанд сургуульдаа ирж бүртгүүлээгүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн эрхийн бичгийг хүчингүйд тооцно.

7.8. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн элсэгчийг Шихихутуг ХЗДС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.

7.9. Оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргааныг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

## 8. Элсэлтийн комиссын эрх, үүрэг.

8.1 Шихихутуг ХЗДС-ийн Захирлын тушаалаар элсэлтийн комиссыг байгуулна.

8.2 Элсэлтийн комисс нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

8.3 Элсэлтийн комисс үйл ажиллагаагаа БШУ-ны сайдын баталсан «Оюутан элсүүлэх журам» болон энэхүү журмын дагуу зохион байгуулна.

8.4 Элсэлтийн комиссын дарга нь гишүүн нэг бүрийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, тэдний ажиллах боломжийг бүрдүүлнэ.

8.5 Элсэлтийн комиссын гишүүн нь санаачлагатай ажиллан элсэлтийн ажлыг боловсронгуй, үр дүнтэй явуулах, гарсан алдаа дутагдлыг засах талаар комиссын даргад мэдэгдэн ажиллана.

8.6 Комиссын дарга, гишүүд элсэгчдийн томилолтыг цэвэр нямбай, гаргацтай бичиж гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

8.7 Комиссын дарга, гишүүд нь элсэгчид, тэдний хууль ёсны төлөөлөгчидтэй зөв боловсон, зөлдэг харьцааг эрхэмлэн харьцаж, хандсан асуултанд шуурхай хариулт өгч байхаас гадна элсэлтийн хугацаанд ямар нэг зөрчил гаргахгүй ажиллах үүрэгтэй.

8.8 Комиссын гишүүд элсэлттэй холбоотой асуудлыг өөрөө дур мэдэн шийдвэрлэх, БШУЯ-наас баталсан хяналтыг тоог хэтрүүлэн элсүүлэхийг хориглоно.

8.9 Элсэлтийн комисс хариуцах ажлын хүрээнд элсэгчид, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан санал, гомдлыг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэнэ.

8.10 Элсэлтийн комиссын дарга, гишүүд элсэлттэй холбоотой асуудлаар зөрчил гаргавал буруутай этгээд өөрөө хариуцлага хүлээнэ.

## 9. Шихихутуг ХЗДС-д элсэлт авах мэргэжил

| Мэргэжлийн нэр | Суралтын хэлбэр | Элсэгчдийн боловсролын түвшин | Суралцах хугацаа | Олгох боловсролын зэрэг | Өгөх шалгалт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улаанбаатар хотоос элсэгчид | Орон нутгаас элсэгчид |
| Эрх зүйч | Өдөр | Бүрэн дунд болон түүнээс дээш | 4 | Бакалавр | Нийгмийн тухай мэдлэг | Нийгмийн тухай мэдлэг /70%/, математик /30%/ |
| | Эчнээ | Бакалавр | 3 | Бакалавр | Үндсэн хуулийн эрх зүй | |
| Бизнесийн эрх зүйч | Өдөр | Бүрэн дунд болон түүнээс дээш | 4 | Бакалавр | Нийгмийн тухай мэдлэг | Нийгмийн тухай мэдлэг /70%/, математик /30%/ |
| Эрх зүйч | Өдөр | Эрх зүйн бакалавр | 1.5 | Магистр | Мэргэжлийн суурь, гадаад хэл | |

# ШИХИХУТУГ ХЗДС-ИАС 2012-2013 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙГ «ОЮУТНАА ХӨГЖҮҮЛЭХ, ЭРДЭМЖҮҮЛЭХ ЖИЛ» БОЛГОСОНТОЙ ХОЛБОГДУУЛАН ОЮУТНУУДЫН ЗААВАЛ УНШИХ НОМЫН ЖАГСААЛТЫГ ГАРГАЛАА.

/ЦУВРАЛ БОЛГОН ТОЛИЛУУЛБАЛ/




**ХУУЛИЙН АМИН СҮНС**

| | |
|---|---|
| Зохиолч: | Шарль Монтеське |
| Орчуулсан: | Ү.Т.Төмөрхүлэг |
| Он: | 2008 |
| ISBN: | 99929-0469-0 |
| Нүүрний тоо: | 352 |
| Эрхлэн гаргасан: | "Монсудар" ХХК |
| Худалдаалж буй дэлгүүр: | "Интерном" номын дэлгүүр |




**ДЭЭД СУРТАХУУН**

| | |
|---|---|
| Хэвлэсэн байгууллага: | "Адмон" ХХК |
| Зохиолч: | Аристотель |
| Орчуулсан: | Б.Даш-Ёндон |
| Он: | 2006 |
| ISBN: | 99929-0-064-4 |
| Нүүрний тоо | 139 |
| Худалдаалж буй дэлгүүр: | Удирдлагын академийн номын дэлгүүр |




**ЭДИЙН ЗАСГИЙН АЛУУРЧДЫН ЗОЛИОСУУД /ЭЗЭРХЭГ ГҮРНИЙ ЭРТНИЙ БАШИР АРГУУД/**

| | |
|---|---|
| Зохиолч: | Стивен Хайт ба 11 авторууд |
| Он: | 2011 |
| ISBN: | 99929-0-064-4 |
| Нүүрний тоо | 510 |




**ЧӨЛӨӨТ НИЙГМИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД**

| | |
|---|---|
| Зохиолч: | Др.Найжель Ашфорд |
| Орчуулсан: | Д.Оюунсүрэн, Т.Бат-Эрдэнэ, Ч.Өнөрбаяр, М.Батсуурь |
| Орчуулгын редактор: | Х.Тэмүүжин |
| Он: | 2007 |




**АРДЧИЛЛЫН ХЭВ ЗАГВАР /ГУЧИН ЗУРГААН ОРНЫ ТӨР ЗАСГИЙН ХЭЛБЭР БА ИЛРЭЛ/**

| | |
|---|---|
| Зохиолч: | Аренд Лийпхарт |
| Орчуулсан: | Д.Ганбат |
| Редактор: | З.Эрэндоо, О.Машбат |
| Он: | 2007 |




**ИРГЭНШИЛ ХООРОНДЫН МӨРГӨЛДӨӨН, ШИНЭЧЛЭГДЭН БУЙ ДЭЛХИЙН ДЭГ ЖУРАМ/**

| | |
|---|---|
| Хэвлэсэн байгууллага: | "Адмон" ХХК |
| Зохиогч: | Самуэль П.Хантингтон |
| Орчуулсан: | Олхонуд Д.Баярхүү |
| Он: | 2005 |
| ISBN: | 978-99929-0-534-4 |
| Нүүрний тоо: | 382 |
| Эрхлэн гаргасан: | "Монсудар" хэвлэлийн газар |
| Худалдаалж буй дэлгүүр: | "Интерном" номын дэлгүүр |




**УЛС ТӨРИЙН БАЙГУУЛАМЖ, ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХЗҮЙ**

| | |
|---|---|
| Хэвлэсэн байгууллага: | "Адмон" ХХК |
| Зохиогч: | Морис Дюверже |
| Орчуулсан: | Т.Төмөрхүлэг |
| Он: | 2007 |
| ISBN: | 978-99929-0-136-5 |
| Нүүрний тоо: | 588 |
| Эрхлэн гаргасан: | "Монсудар" хэвлэлийн газар |
| Худалдаалж буй дэлгүүр: | "Интерном" номын дэлгүүр |




## ЭДИЙН ЗАСГИЙН АЛУУРЧНЫ НАМИНЧЛАЛ

| | |
|---|---|
| Зохиолч: | Джон Перкинс |
| Он: | 2011 |
| Нүүрний тоо: | 265 |




## МАРКСИЗМЫГ ӨМГӨӨЛХҮЙ

| | |
|---|---|
| Зохиолч: | Зулаагийн Бат - Отгон |
| Он: | 2008 |
| ISBN | 99929-1-261-8 |
| Нүүрний тоо: | 96 |
| Үнэ: | 5500₮ |



## УЛС ТӨР БОЛ МЭРГЭШИЛ МӨН, ШИНЖЛЭХ УХААН БОЛ МЭРГЭШИЛ МӨН

| | |
|---|---|
| Зохиолч: | Макс Вебер |
| Орчуулсан: | Ү.Нямдорж |
| Он: | 2000 |
| Нүүрний тоо: | 120 |




## НИКОМАХЫН ЁСЗҮЙ

| | |
|---|---|
| Хэвлэсэн байгууллага: | "Адмон" ХХК |
| Зохиогч: | Аристотель |
| Орчуулсан: | Б.Даш-Ёндон |
| Он: | 2007 |
| ISBN: | 978-99929-0-432-1 |
| Нүүрний тоо: | 388 |
| Эрхлэн гаргасан: | "Монсудар" хэвлэлийн газар |
| Худалдаалж буй дэлгүүр: | Удирдлагын академийн номын дэлгүүр |




### КАПИТАЛИЗМЫГ ӨМӨӨРӨХ НЬ

| | |
|---|---|
| Зохиолч: | Айн Рэнд |
| Орчуулсан: | Ж.Нэргүй |
| Он: | 2007 |
| ISBN | 99929-0-638-3 |
| Нүүрний тоо: | 380 |
| Худалдаалж буй дэлгүүр: | Удирдлагын академийн номын дэлгүүр |




### E-GOVERNANCE CONCEPT AND CASE STUDIES

| | |
|---|---|
| Зохиолч: | Prabhu CS.R |
| Он: | 2004 |
| ISBN | 81-203-2647-4 |
| Нүүрний тоо: | 247 |